

Б.Эрдэнэчимэг, Д.Энхцэцэг

# МАТЕМАТИК

## III

Ерөнхий боловсролын сургуулийн  
3 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2020 он

DDC  
371.32  
M-294

МАТЕМАТИК III: Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийн сурах бичиг  
(Эрдэнэчимэг.Б., Энхцэцэг.Д; Ред. Батболд.Г., -УБ., 2014. -152 х.)

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99973-69-33-8



## АГУУЛГА

Давтах.....	4
Ангилах.....	11
Арван мянга хүртэлх тоог унших, бичих, жиших, тоймлох.....	15
Арван мянга дотор тоог нэмэх, хасах.....	23
Дүрсийг таних.....	31
Асуудал шийдвэрлэх.....	41
Өгөгдөлтэй ажиллах.....	43
Арван мянга дотор тоог үржүүлэх, хуваах.....	51
Уртыг хэмжих.....	68
Талбайг хэмжих.....	73
Куб, түүний дэлгээсийг таних.....	77
Асуудал шийдвэрлэх.....	80
Хугацаа хэмжих.....	82
Эерэг, сөрөг тоог таних.....	89
Зүй тогтлыг олох.....	92
Хүндийг хэмжих.....	95
Байршил, хөдөлгөөнийг тогтоох.....	99
Асуудал шийдвэрлэх.....	102
Боломжийн тоо олох.....	104
Эзлэхүүнийг хэмжих.....	108
Энгийн бутархайтай танилцах.....	112
Тойрог, дугуйг таних.....	120
Нэгдсэн бататгал.....	124

## ТАНИХ ТЭМДЭГ



Сорих



Сэтгэн бодох



Хийж бүтээх

1

Цээжээр бодох

## ДАВТАХ

1 Тоонуудыг цифрээр бичиж, орны нэмэгдэхүүний нийлбэрт задлаарай.

- а. Гурван зуун далан тав                                  в. Найман зуу  
б. Хоёр зуун тав    г. Зургаан зуу

2 Тоонуудын хөрш тоог бичээрэй.

475		477
-----	--	-----

398	399	
-----	-----	--

	870	871
--	-----	-----

399		401
-----	--	-----

3 Тоонуудыг багаас их рүү жагсаан бичээрэй.

378, 901, 879, 645, 439, 500, 780, 110

4 Тоог бичээрэй.

- а.  $1 \text{ м} = \square \text{ см}$                                   в.  $1 \text{ см} = \square \text{ мм}$                                   д.  $1 \text{ м} = \square \text{ дм}$   
б.  $1 \text{ дм} = \square \text{ см}$                                   г.  $1 \text{ дм} = \square \text{ мм}$                                   е.  $2 \text{ м} = \square \text{ дм}$

5 Хүснэгтийг ажиглаад, гүйцээгээрэй.

△	34		50		75		50	69	90
□	30	20		40	40	21		60	
△ + □		90				101			
△ - □			1	51			41		9

6 Дэлгүүрт 200 кг гурил, 50 кг будаа, 20 кг үзэм, 10 кг жигнэмэг татан авав. Дэлгүүрт нийт хэдэн килограмм бараа татан авсан бэ?

7 Цээжээр бодоорой.

- а. Ямар хоёр аравтын нийлбэр 100 байх вэ? Хэдэн хувилбар байна вэ?  
б. Ямар хоёр зуутын нийлбэр 1000 байх вэ? Хэдэн хувилбар байна вэ?


8 Үйлдлийг гүйцэтгээд,  $<$ ,  $>$ ,  $=$  тэмдгийн тохирохыг бичээрэй.

- а.  $27 + 30 \square 65 - 20$                                   в.  $48 \div 8 \square 22 - 15$                                   д.  $81 \div 9 + 21 \square 35 - 30$   
б.  $135 - 30 \square 345 - 30$                                   г.  $56 \div 7 \square 100 - 92$                                   е.  $16 - 9 + 50 \square 144 - 40$

Нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдэл бүхий хаалтгүй жишээг бодохдоо эхлээд үржүүлэх, хуваах, дараа нь нэмэх, хасах үйлдлийг зүүнээс баруун гар тийш дараалан гүйцэтгэнэ.



9



Зураг дээрх нийт мөөгний тоог олоорой. Хэдэн аргаар бодож болох вэ? Ярилцаарай.

10

$3^a$ ,  $3^b$  ангиуд цэвэрлэгээ хийв. Анги бүр 25 сурагчтай бол нийт хэдэн сурагч цэвэрлэгээ хийсэн бэ?

11

Ангийн 36 сурагчийг 9, 9-өөр эгнүүлэн жагсаав. Хэдэн эгнээ болж жагссан бэ?

12

Хугацааны хүрдийг ажиглаад, тоонууд юу илэрхийлж байгааг ярилцаарай.

13

Жишээрэй.

а. 1 дм 3 см  1 дм 8 см

б. 5 дм  5 см    в. 1 дм 6 см  17 см

14

Эгнээ бүрд 9 хүүхэд жагсав. 10 эгнээнд хэдэн хүүхэд жагсах вэ? Янз бүрийн аргаар бодоорой.

15


Оёдолчин том хүний 5, хүүхдийн 3 дээл оёв. Том хүний дээлэнд 4 м, хүүхдийн дээлэнд 2 м даавуу ордог. Оёдолчин хэдэн метр даавуугаар дээл оёсон бэ?

16

Жишээг бодоорой.    а.  $35 \div 7 \times 5$       б.  $15 \div 5 + 21$       в.  $76 - 9 \times 3$

17

Дүрсүүдийг нэрлээрэй. Дүрсүүд юугаараа ижил, юугаараа ялгаатай байна вэ?



18

Зүй тогтлыг олж, дараагийн гурван тоог бичээрэй.

а. 2, 4, 6, 8, ...

в. 3, 6, 9, ...

д. 75, 70, 65, ...

б. 100, 90, 80, ...

г. 800, 700, 600, ...

е. 998, 992, 986, ...

19



1. Жишээг бодоорой.    а.  $49 + 3 \times 7$     б.  $4 \times 9 - 19$

2. 45 цэцгийг баглаа бүрд тэнцүү тооны цэцэг байхаар 9 хэсэгт хуваагаарай. Нэг баглаанд хэдэн цэцэг орох вэ?

**20** Бат, Туяа нар тус бүр 1000 төгрөгтэй. Тэд ахтайгаа дэлгүүр оржээ.



Барааны нэр	Үнэ (төгрөгөөр)
Тосон бал	50, 100, 200
Үзгэн бал	300, 450, 800
Үзгэн балны гол	150, 200, 250
Харандаа	120, 320, 550
Цавуу	230, 400

Барааны нэр	Үнэ (төгрөгөөр)
Дэвтэр	120, 240, 300
Шугам	350, 420, 550
Бийр	420, 580, 600
Баллуур	150, 360, 750
Савх	350, 549



120, 240, 300 төгрөгийн гээд олон янзын дэвтэр байна.

- 549 төгрөгийн үнэтэй савх, 50 төгрөгийн үнэтэй тосон бал авахад нийт хэдэн төгрөг төлөх вэ?
- Хамгийн хямд үнэтэй шугам болон 549 төгрөгийн үнэтэй савх авахад нийт хэдэн төгрөг төлөх вэ?
- 580 төгрөгийн үнэтэй бийр, 350 төгрөгийн үнэтэй шугам авахад нийт хэдэн төгрөг төлөх вэ?

**Жишээ 1** 549 төгрөгийн үнэтэй савх, 50 төгрөгийн үнэтэй тосон бал авахад нийт хэдэн төгрөг төлөхийг тооцоолов. Бодолтыг тайлбарлаарай.

$$549 + 50 = 500 + 40 + 9 + 50 = 500 + 90 + 9 = 599$$

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

	5	4	9
+		5	0
			9

Эхлээд нэгжээ нэмнэ.  
 $9 н + 0 н = 9 н$

	5	4	9
+		5	0
		9	9

Дараа нь аравтаа нэмнэ.  
 $4 а + 5 а = 9 а$

	5	4	9
+		5	0
	5	9	9

Дараа нь зуутаа нэмнэ.  
 $5 з + 0 з = 5 з$

**Жишээ 2** Хамгийн хямд үнэтэй шугам болон 549 төгрөгийн үнэтэй савх авахад нийт хэдэн төгрөг төлөхийг тооцоолжээ. Бодолтыг тайлбарлаарай.

	+	5	4	9		→		+	5	4	9		→		+	5	4	9
		3	5	0					3	5	0					8	9	9
				9							9	9						

**Жишээ 3** 580 төгрөгийн үнэтэй бийр, 350 төгрөгийн үнэтэй шугам авахад нийт хэдэн төгрөг төлөхийг олов. Бодолтыг тайлбарлаарай.

а.  $580 + 350 = 500 + 80 + 300 + 50 = 800 + 130 = 800 + 100 + 30 = 900 + 30 = 930$

б.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

	5	8	0
+	3	5	0
			0

Эхлээд нэгжээ нэмнэ.  
 $0 н + 0 н = 0 н$

↓ 1

	5	8	0
+	3	5	0
		3	0

Дараа нь аравтаа нэмнэ.  
 $8 а + 5 а = 13 а$   
 $13 а = 1 з 3 а$   
1 зуутаа санана.

↓ 1

	5	8	0
+	3	5	0
	9	3	0

Дараа нь зуутаа нэмнэ.  
 $5 з + 3 з = 8 з$   
 $8 з + 1 з = 9 з$

**21** Алдаа байгаа эсэхийг олж, тайлбарлаарай.

а. 

	+	2	5	8
				3
		2	5	1

 б. 

	+	2	5	8
			6	3
		3	1	1

 в. 

	+	2	5	8
		4	6	3
		6	2	1

 г. 

	+	5	4	7
		2	8	6
		7	3	3

**22** Нийлбэрийн утгыг олоорой.


а.  $63 + 25$       в.  $923 + 9$       д.  $320 + 680$       ж.  $238 + 641$   
б.  $400 + 500$       г.  $350 + 150$       е.  $7 + 116$       з.  $503 + 270$

Бодсон аргаа тайлбарлаарай.


**23** 29 см урттай, 18 см өргөнтэй жаазны хүрээний уртыг олоорой.

**24** Тоон шулуун хэрэглэн нэмэх үйлдлийг яаж гүйцэтгэснийг тайлбарлаарай.

$323 + 49 = ?$



**25** Өгсөн дүрсүүдийг нэрлээрэй. Нэрлэж мэдэхгүй дүрс байна уу? Дүрс бүр хэдэн тал, хэдэн оройтой вэ? Дүрсүүдийн хоорондын ялгааг ярилцаарай.



**Жишээ 4**

2012 онд зарим хүнсний бараа ямар үнэтэй байсныг үзүүлэв.



Талх  
650 төгрөг



1 кг лууван  
955 төгрөг



1 кг гурил  
757 төгрөг



1 кг байцай  
969 төгрөг



1 кг төмс  
800 төгрөг

1. Нэг килограмм лууван ба байцайн үнийн зөрөөг олсон аргыг тайлбарлаарай.



Хоёр тооны зөрөөг олохдоо ихээс багыг хасна.

а.  $969 - 955 = 969 - 900 - 50 - 5 = 69 - 50 - 5 = 19 - 5 = 14$

б.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

$$\begin{array}{r} 969 \\ - 955 \\ \hline \phantom{0}4 \end{array}$$

Эхлээд нэгжүүдээ хасна:  
 $9\text{ н} - 5\text{ н} = 4\text{ н}$

$$\begin{array}{r} 969 \\ - 955 \\ \hline \phantom{0}14 \end{array}$$

Аравтуудаа хасна:  
 $6\text{ а} - 5\text{ а} = 1\text{ а}$

$$\begin{array}{r} 969 \\ - 955 \\ \hline 014 \end{array}$$

Зуутуудаа хасна:  
 $9\text{ з} - 9\text{ з} = 0\text{ з}$

Шалгавал:  $955 + 14 = 969$

2. Үнийн зөрөөг олоорой.


а. 1 кг лууван ба 1 кг төмс

б. 1 кг байцай ба 1 кг төмс

**26** Бараа худалдан авах тухай бодлого зохиогоорой. Найзуудаараа бодуулаарай.

**27** Өгсөн загварыг ажиглаад, жишээг бодоорой.

$472 - 49 = ?$



а.  $321 - 42$

б.  $545 - 28$

в.  $222 - 59$

г.  $190 - 82$

д.  $604 - 71$

**28**



100 төгрөгийг тавт ба аравтаар задлахад 12 ширхэг дэвсгэрт болов. Тавт ба аравтын хэдэн дэвсгэртээр задалсан бэ?

**Жишээ 5** 1 кг лууван ба 1 кг гурилын үнийн зэрөөг олсон аргыг тайлбарлаарай.

а.  $955 - 757 = 955 - 700 - 50 - 7 = 205 - 7 = 190 + 15 - 7 = 190 + 8 = 198$

б.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

4 15

Эхлээд нэгжүүдийг хасна: 5-аас 7-г хасаж болохгүй тул 1 аравтыг задалъя.

$1 \text{ а } 5 \text{ н} = 15 \text{ н}, 15 \text{ н} - 7 \text{ н} = 8 \text{ н}$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

8 14 15

Аравтуудыг хасна: 1 аравтыг задлаад 4 аравт үлдсэн. 1 зуутыг задалъя.

$1 \text{ з} = 10 \text{ а}, 10 \text{ а} + 4 \text{ а} = 14 \text{ а}$   
 $14 \text{ а} - 5 \text{ а} = 9 \text{ а}$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

8 14 15

Зуутуудыг хасна:  $8 \text{ з} - 7 \text{ з} = 1 \text{ з}$

Шалгавал:  $198 + 757 = 198 + 2 + 755 = 200 + 755 = 955$

**29** 1 кг төмс ба 1 кг гурилын үнийн зэрөөг олъё.  $800 - 757 = ?$   
Бодолтыг тайлбарлаарай.

Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

7 9 10

Эхлээд нэгжүүдээ хасна: 0-ээс 7-г хасаж болохгүй. Аравт 0 тул 1 зуутыг задалъя.

$1 \text{ з} = 10 \text{ а}, 10 \text{ аравтаас } 1\text{-ийг задалъя.}$   
 $1 \text{ а} = 10 \text{ н}, 10 \text{ н} - 7 \text{ н} = 3 \text{ н}$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

7 9 10

Аравтуудаа хасна: 9 аравт үлдсэн.  $9 \text{ а} - 5 \text{ а} = 4 \text{ а}$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

7 9 10

Зуутуудаа хасна: 7 зуут үлдсэн.  $7 \text{ з} - 7 \text{ з} = 0 \text{ з}$

Шалгавал:  $43 + 757 = 40 + 3 + 700 + 50 + 7 = 700 + 90 + 10 = 800$

**30** Алдааг олж засаад, тайлбарлаарай.

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

$$\begin{array}{r} \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ - \phantom{0} \phantom{0} \phantom{0} \\ \hline \phantom{0} \phantom{0} \phantom{0} \end{array}$$

31



Ялгаврын утгыг олъё.

- а. 4 сурагч тус бүр 0-ээс 9 хүртэлх цифр бичсэн картууд бэлтгэнэ.  
 б. Картуудаа холино. Тоглогч бүр багцаас 6 карт авна.  
 в. Тоглогч авсан картуудаар гурван оронтой тоо 2-ыг зохиож, тэдгээрийн ялгаврын утгыг олно.  
 г. Ялгаврын утгыг хамгийн бага тоо гаргахын тулд яаж тоглох вэ?  
 Тоглоомын дүрмийг өөрчлөн тоглоорой. Жишээлбэл: Тоглогчдод 5 карт тараах, эсвэл хоёр ба гурван оронтой хоёр тоо зохиох гэх мэт.

32

Нэг ба хоёр оронтой тоо зохиогоорой.

- а. Нэг оронтой тоогоо 2, 3, 5-аар тус тус нэмэгдүүлэн тоолоорой.  
 б. Хоёр оронтой тоог 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9-өөр тус тус хорогдуулан тоолоорой.

33

Бодолтыг тайлбарлаарай.

а.  $144 + 48 = 144 + 50 - 2 = 194 - 2 = 192$

б.  $276 - 58 = 276 - 60 + 2 = 216 + 2 = 218$

Тохирох арга сонгон жишээнүүдийг бодоорой.

- а.  $35 + 63$     б.  $35 + 57$     в.  $123 - 96$     г.  $94 + 68 - 97$     д.  $695 + 278$

34

Оновчтой аргыг сонгон тооцоолоорой. Бодсоноо хэрхэн шалгах вэ?

- а.  $25 + 38 + 75$     б.  $17 + 400 + 583$     в.  $594 + 128 - 94$     г.  $350 - 180 + 650$

35

а. 155-ыг 47-оор хорогдуулаад, 23-аар ихэсгээрэй.

б. 248 ба 25-ын нийлбэрийг 14-өөр багасгаарай.

в. 367-г 39 ба 19-ийн нийлбэрээр багасгаарай.

36

Ангийн номын сан 178 номтой. 68 нь үлгэрийн ном, түүнээс 24-өөр цөөн хүүхдийн зохиол байв. Үлдсэн нь монгол хэлний ном бол гурван төрлийн ном тус бүрийн тоог олоорой.

37

Гурван тооны нийлбэр 136. Хоёрдугаар тоо нь нэгдүгээр тооноос 47-оор их, гуравдугаар тоо нь хоёрдугаар тооноос 18-аар их. Тоо тус бүрийг олоорой. Ихээс бага руу нь эрэмбэлээрэй.

38



1. Номын сангаар өдөр 251 уншигч үйлчлүүлэв. Өглөө түүнээс 127-оор цөөн, орой нь өглөөнийхтэй тэнцүү тооны уншигч үйлчлүүлжээ. Номын сангаар нийт хэдэн хүн үйлчлүүлсэн бэ?


2. Бодоорой. а.  $536 + 127$     б.  $8 \times 4 + 170$     в.  $800 - 267 - 474$

3. Жишээрэй. а. 1 дм 2 см  1 м 3 см    б. 135 см  1 м 36 см



## АНГИЛАХ

39



Зурагт юу дүрсэлснийг нэрлээрэй.

а. Дэвтэртээ дараах хүснэгтийг зураарай.

Алинд ямар шинж байгааг “+”-ээр тэмдэглээд, тайлбарлаарай.

Дугаар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Жимс		+												
Хүнсний ногоо													+	
Ногоон өнгөтэй														
Улаан өнгөтэй														
Улбар шар өнгөтэй														

Жимс, ногоо нь өөр ямар шинжтэй байна вэ? Бичээд, тэмдэглээрэй.

б. Жимс, хүнсний ногоог ангилж, дугаарыг хүснэгтэд бичээрэй.

Жимс	Жимс биш	Ногоон өнгөтэй	Ногоон биш
2,	8,		

в. Жимс, хүнсний ногоог ангилж, дугаарыг хүснэгтэд бичээрэй.

	Жимс	Жимс биш
Ногоон өнгөтэй		8,
Ногоон өнгөтэй биш		3,

г. Жимс, хүнсний ногооны ашиг тусын талаар эх зохиож бичээрэй.

**40** Зураг дахь юмсыг өгсөн шинжээр ялгаж, дугаарыг нь бичээрэй.



Тоглоом	Тоглоом биш

	Тоглоом	Тоглоом биш
Цэнхэр өнгө орсон		
Цэнхэр өнгө ороогүй		

Өөр ямар шинжээр ангилж болох вэ? Бичиж харуулаарай.

**41** 10 сурагчийн нэрийг дугаарлан бичээрэй. Нэрсийг ангилан дугаарыг бичнэ үү.

	Нэрийн үсгийн тоо 8-аас их	Нэрийн үсгийн тоо 8-аас их биш
Эрэгтэй		
Эмэгтэй		

**42** 5, 6, 7, 8, 9, 11, 12, 13, 14 тоонууд өгөгджээ.

а. Хүснэгтэд тоонуудыг ангилан бичээд, тайлбарлаарай.

Тэгш тоо	Тэгш тоо биш	10-аас бага тоо	10-аас бага биш тоо

б. Хүснэгтэд тоонуудыг ангилан бичээрэй.

	10-аас бага тоо	10-аас бага тоо биш
Тэгш тоо		
Тэгш тоо биш		



Дараах шинжтэй тоонууд хүснэгтийн аль нүдэнд байгааг ярилцаарай.


10-аас бага биш сондгой тоо	10-аас бага тэгш тоо	10-аас бага сондгой тоо	10-аас бага биш тэгш тоо
-----------------------------	----------------------	-------------------------	--------------------------

в. Тоонуудыг өөр ямар шинжээр ангилж болох вэ? Ангилаад, тайлбарлаарай.

**43** Дүрсүүдийг ангилжээ. Цэгийн оронд тохирох шинжийг бичээрэй.

.....	.....	.....	.....


**44** Зурагт юу дүрсэлсэн байна вэ?





а. Эдгээрт ямар шинж байгааг дэвтэртээ тэмдэглээрэй.

Дугаар	1	2	3	4	5	6	7	8
Амьтан								
Ургамал								

б. Зураг дахь юмсыг нэг шинжээр ангилж, дугаарыг зууван дугуйд бичээрэй. Зууван дугуйн гадна ямар дугаарыг бичих вэ? Хийснээ тайлбарлаарай.




в. Зураг дахь юмсыг хоёр шинжээр ангилж, дугаарыг зууван дугуйд бичээрэй.



Цэнхэр, шар зууван дугуйн давхардсан хэсэгт ямар дугаар байх вэ?  
 Шар дугуйд ямар дугаар байх вэ? Цэнхэр дугуйд ямар дугаар байх вэ?  
 Дугуйнуудын гадна ямар дугаарыг бичих вэ? Учрыг тайлбарлаарай.

**45** Алийг хийхэд мод хэрэглэдэг вэ? Ангилж дүрслээрэй.




Эдгээрийг ямар хоёр шинжээр ангилж болох вэ?



**46** Гэртээ модны ашиг тусын талаар бичээрэй. Модоо хайрлан хамгаалахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?



47 Амьтдыг нэрлээрэй.



а. Амьтдыг өгсөн шинжээр ангилж, нэрсийг зууван дугуйд бичээрэй. Дугуйн дотор, гадна ямар амьтдын нэрийг бичсэн бэ? Яагаад?



б. Амьтдыг өөр ямар шинжээр ангилж болох вэ? Дүрсэлж үзүүлээрэй.


в. Гэртээ “Амьтдыг хайрлая” сэдвээр эх бичиж, эсвэл зураарай.

48 Дүрслэлийг ажиглаад, асуултад хариулаарай.


а. Нисдэг мөртлөө шувуу биш амьтныг нэрлээрэй.

б. Шувуу мөртлөө нисдэггүй амьтныг нэрлээрэй.



в. Нисдэг шувуудыг нэрлээрэй.



49 Дүрсүүдийг ямар шинжээр ангилж болох вэ?



Шинж бичин ангилаарай. Зууван дугуйн гадна ямар дүрсүүд байх вэ?




50 Ангийнхаа 10 хүүхдээс явахыг хүсдэг нэг дугуйланг асууж бичээрэй. Охид, хөвгүүд ямар дугуйланд явахыг хүсдэгийг ангилж үзүүлээрэй.

51



203, 554, 960, 49, 342, 513, 2, 129, 378, 831, 13, 87 тоонуудыг өгчээ. Дэвтэртээ дугуй, хүснэгт зураарай. Тоонуудыг ангилж үзүүлээрэй.



	Сондгой тоо	Сондгой тоо биш
300-аас их тоо		
300-аас их биш		

## АРВАН МЯНГА ХҮРТЭЛХ ТООГ УНШИХ, БИЧИХ, ЖИШИХ, ТОЙМЛОХ

52



3 дугаар ангийн сурагчийн тоо:  
 Дорнод 1259      Хэнтий 1151  
 Дорноговь 1032      Төв 1217

а. Дорнодын сурагчийн тоог дүрсэлье. 1 сурагчийг -оор төлөөлүүлье.



Мянгат (мян)	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

10 н = 1 а  
 10 а = 1 з  
 10 з = 1 мян  
 10 мян = 1 а.мян

Тоог орон, ангийн хүснэгтэд бичье.

Цифрүүд аль оронд байрлаж, ямар утгыг илэрхийлэх вэ?


Мянгат (мян)	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
1	2	5	9
↑ 1000	↑ 200	↑ 50	↑ 9



1 мянгат + 2 зуут + 5 аравт + 9 нэгж

Орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичих:  $1259 = 1000 + 200 + 50 + 9$

Унших: **Нэг мянга хоёр зуун тавин ес**




б. Хэнтий, Дорноговь, Төв аймгийн сурагчдын тооны хувьд давтан хийгээрэй.

в. 9999-ийн дараах тоог бичээд, уншаарай. Уг тоог хэрхэн дүрслэх вэ?


53

Тооны орны утгын карт хэрэглэн тоо бүтээе. Бүтээсэн тоонуудаа:



- а. Орон, ангийн хүснэгтэд бичээрэй.
- б. Цифрүүдийн байрлах орон, утгыг бичээрэй.
- в. Орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.
- г. Үгээр бичээрэй.

54 Өгсөн тооноос эхлэн нэгээр нэмэгдүүлэн тоолоорой.



а. 1259, 1260, 1261, ..... 1269 хүртэл;



б. 1151-ээс 1160 хүртэл

в. 1032-оос 1045 хүртэл

55 Тоолоорой.

а. 1259-өөс 1349 хүртэл арваар нэмэгдүүлэн, 1692-оос 1602 хүртэл арваар хорогдуулан тус тус тоолоорой.



б. 1259-өөс 1959 хүртэл зуугаар нэмэгдүүлэн тоолоорой. 2032-оос 1032 хүртэл зуугаар хорогдуулан тоолоорой.

в. 75, 803, 1390 гэсэн тоо бүрээс эхлэн мянгаар нэмэгдүүлэн тоолоорой. 9259-өөс эхлэн мянгаар хорогдуулан тоолоорой.

56



Нуусан тоог олъё. Хосоороо ажиллана. Нэг нь хүснэгтийн зарим тоон дээр цаас тавин нууж, нөгөө нь нуусан тоог хэлнэ.

201	202	203	204	205	206	207	208	209	210
211	212	213	214	215	216	217	218	219	220
221	222	223	224	225	226	227	228	229	230
231	232	233	234	235	236	237	238	239	240
241	242	243	244	245	246	247	248	249	250
251	252	253	254	255	256	257	258	259	260
261	262	263	264	265	266	267	268	269	270
271	272	273	274	275	276	277	278	279	280
281	282	283	284	285	286	287	288	289	290
291	292	293	294	295	296	297	298	299	300

	302	303		305	306	307		309	310
				315	316				320
	322	323		325	326	327		329	330
331	332	333				337		339	340
341	342	343		345		347	348	349	350
351		353				357	358	359	360
361		363	364	365			368		
			374	375		377		379	
381		383	384	385		387	388	389	
391	392	393	394	395		397	398	399	

57



Өгсөн картуудаар боломжтой бүх 4 оронтой тоог зохиогоорой.

Зохиосон тоонуудаа орны нэмэгдэхүүний нийлбэрээр бичээрэй. Тоонуудаас 10, 100, 1000-аар их, бага тоог олоорой.

8	0	0	0		1	
5	0	0	0		6	
7	0	0			2	0
4	0	0			9	0

58

3 дугаар ангийн сурагчийн тоо:  
 Дорнод 1259 Хэнтий 1151  
 Дорноговь 1032 Төв 1217


Дорнод, Төв аймгийн аль нь 3 дугаар ангидаа олон сурагчтай байсан бэ?



Мянгат (мян)	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)

Тоонуудыг жишихдээ:  
 а. Орны тоог харна. Олон оронтой тоо нь их байна.  
 б. Орны тоо тэнцүү бол дээд орны нэгжүүдийг жишнэ. Нэгж ихтэй тоо нь их байна.  
 в. Тэнцүү байвал дараагийн орны нэгжүүдийг жишнэ. Нэгж ихтэй нь их тоо байна гэх мэт үргэлжлүүлнэ.

1 = 1      2 = 2      5 > 1    тул    1259 > 1217 байна.



Тоон шулуун дээрх хоёр тооны баруун гар талд байрлах тоо их, зүүн гар талд байрлах тоо бага байна.




59

Тоонуудыг тоон шулуун дээр цэгээр тэмдэглэн жишээрэй.

- а. 647 ба 641      б. 3206 ба 3216      в. 7325 ба 7125      г. 5105 ба 5150

60

Тоонд хэдэн мянгат (мян), зуут (з), аравт (а), нэгж (н) байгааг дүрсэлжээ. Тоонуудыг хамгийн ихээс бага руу жагсаан бичээрэй.



61

Тоонуудыг жишье.

- а. Орон бүрийн утгын картуудыг доош харуулж тавина.
- б. Багц бүрээс 1 карт сугалж, 4 оронтой тоо бүтээнэ.
- в. Дээрхийн адил 4 удаа тоо бүтээнэ. Бүтээсэн тоонуудаа хамгийн багаас их рүү жагсаан бичээрэй.




3 дугаар ангийн сурагчийн тоо:  
 Дорнод 1259 Хэнтий 1151  
 Дорноговь 1032 Төв 1217

Сурагчийн тоог  
 аравт, зуут, мянгатаар  
 тоймлоорой.



**Жишээ 1** 1217-г аравтаар тоймлоё.

1217 нь 1210 ба 1220-ийн алинд ойр вэ?



1217 нь 1220-д илүү ойр. Иймд 1217-г аравтаар тоймлоход 1220 болно.

**62** 1205, 1206, 1207, 1208, 1209, 1210, 1211, 1212, 1213, 1214, 1215, 1216, 1217, 1218, 1219 тоонуудыг аравтаар тоймлоорой.

Ямар тоонуудыг аравтаар тоймлоход 1210 гарсан бэ? Ялгаж бичээрэй.

Ямар тоонуудыг тоймлоход 1220 гарсан бэ? Ялгаж бичээрэй.


Тоонуудын нэгжийн орны цифрийг ажиглаарай. Ямар дүгнэлт хийх вэ?

Ямар тоог тоймлоход хэцүү байсан бэ? Яагаад?

**Жишээ 2** 3615 гэсэн тоог аравтаар тоймлоё.

3615 нь 3610 ба 3620-ийн дунд оршино. Энэ тохиолдолд тоймлох орныг 1-ээр ахиулна. Иймд 3615-ыг аравтаар тоймлоход 3620 болно.

**Жишээ 3** 1217-г зуутаар тоймлоё. 1217 нь 1200 ба 1300-ийн алинд ойр вэ?



1217 нь 1200-д илүү ойр. Иймд 1217-г зуутаар тоймлоход 1200 болно.

**63** 1210, 1220, 1230, 1240, 1250, 1260, 1270, 1280, 1290 тоонуудыг зуутаар тоймлоорой.

Тоймлоход 1200, 1300 гарсан тоонуудыг ялган бичээрэй.

Аравтын орны цифрүүдийг ажиглаарай. Ямар дүгнэлт хийж болох вэ?

**64** 1217, 1317, 1417, 1517, 1617, 1717, 1817, 1917 тоонуудыг мянгатаар тоймлоорой. Тоонууд 1000, 2000-ын алинд ойр вэ?

Тоймлоход 1000, 2000 гарсан тоонуудыг ялган бичээрэй.

Зуутын орны цифрүүдийг ажиглаарай. Ямар дүгнэлт хийж болох вэ?



Тоог тоймлохдоо түүнд хамгийн ойр байх аравт, зуут, мянгатаар сольжээ.

Тоймлох орны доод орны нэгж 5, 6, 7, 8, 9-ийн аль нэг бол тоймлох орны нэгж 1-ээр нэмэгдэж байна.





**65** 450-ийг мянгатаар тоймлоё. 450 нь 0 ба 1000-ын алинд ойр вэ?  
450 нь -д илүү ойр. Иймд 450-ийг мянгатаар тоймлоход  болно.


**66** Тоонуудыг аравт, зуут, мянгатаар тоймлоорой.  
3, 8, 26, 59, 62, 308, 414, 582, 555, 802, 1937, 2015, 8230, 3829, 7549

**67** 41, 35, 46, 72, 145, 843, 5471, 7425, 3018 тоонууд өгөгдөв.  
Сурагчид тоонуудыг дараах байдлаар аравт, зуут, мянгатаар тоймложээ.

Сурагч 1	Сурагч 2
а. Тоонуудыг аравтаар тоймлосон.	а. Тоонуудыг аравтаар тоймлосон.
б. Өгсөн тоонуудыг зуутаар тоймлосон.	б. Аравтаар тоймлоход гарсан тоонуудаа зуутаар тоймлосон.
в. Өгсөн тоонуудыг мянгатаар тоймлосон.	в. Зуутаар тоймлоход гарсан тоог мянгатаар тоймлосон.


2 сурагч зуутаар тоймлосны дараа ижил тоонууд гаргасан уу?  
2 сурагчийн мянгатаар тоймлосон тоо ижил гарсан уу? Шалгаарай.  
Тоог яаж зөв тоймлох вэ?


**68** Ямар тоонуудыг аравтаар тоймловол 20 болохыг олъё.  
14, 15, 16, 17, 18, 19, 21, 22, 23, 24, 25 гэсэн тоонуудыг аравтаар тоймлоорой.



Өнгөөр ялгасан тоонуудыг тоймлоход ямар тоо гарсан бэ?  
Ямар тоонуудыг тоймлоход 20 болсон бэ? Дүгнэлт гаргаарай.

**69** Асуултад хариулаарай.  
а. 140-өөс 149 хүртэлх тоонуудыг зуутаар тоймловол хэд болох вэ?  
б. 50-аас 149 хүртэлх тоонуудыг зуутаар тоймловол хэд болох вэ?  
в. 150-аас 249 хүртэлх тоонуудыг зуутаар тоймловол хэд болох вэ?

**70**  а. Ямар тоонуудыг аравтаар тоймловол 40 болох вэ?  
б. Ямар тоонуудыг зуутаар тоймловол 900 болох вэ?  
в. Ямар тоонуудыг мянгатаар тоймловол 7000 болох вэ?  
г. Ямар тоонуудыг мянгатаар тоймловол 0 болох вэ?

**71**  7499, 1054, 5009, 4800, 673, 18 гэсэн тоонуудыг:  
а. Орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.  
б. Хамгийн багаас их рүү жагсаан бичээрэй.  
в. Аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

## СОРИХ


**72** 1528, 2685, 5821, 8152 тоонуудын хувьд дараах асуултад хариулаарай.

Аль тоонд 8 нь 8 зуут гэсэн утгыг илэрхийлэх вэ?

Аль тоонд 5 нь 5 аравт гэсэн утгыг илэрхийлэх вэ?

Бусад цифрүүд аль оронд байрлаж, ямар утгыг илэрхийлэх вэ?

**73** Тоонд хэдэн мянгат (мян), зуут (з), аравт (а), нэгж (н) байгааг дүрсэлжээ.



а. Тоонуудыг дэвтэртээ бичээрэй.

б. Тоонуудыг орон, ангийн хүснэгтэд бичээрэй.


в. Тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.

г. Тоонуудыг хамгийн ихээс бага руу жагсаан бичээрэй.

д. Тоо бүрийг аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

е. Эхний тооноос 1, 10, 100, 1000-аар их, бага тоонуудыг бичээрэй.

**74** Тоонуудыг тоон шулуун дээрх харгалзах цэгтэй нь холбоорой.



## БАТАТГАХ

**75** Ажиглаад, мэдэгдэхгүй байгаа тоонуудыг олоорой.

5318	5328	5338		5358			5398
7152				7552	7652	7752	
1123	2123	3123			6123	7123	

**76**



Тоолъё.

Хосоороо 2, 3, 4, 5, 10, 50, 100, 1000 гэсэн тоотой картууд бэлтгэнэ.

а. Сурагч бүр нэг оронтой тоо зохиож бичнэ.

б. Картуудаа холиод, доош харуулан тавина.

в. Тоглогч бүр картуудаас нэгийг сонгоно.

г. Тэд зохиосон тоогоо карт дахь тоогоор нэмэгдүүлж (хорогдуулж) тоолон, таван тоо хэлнэ. Нэгнийгээ зөв тоолж буй эсэхийг хянана.

**77** Орон, ангийн хүснэгтэд тоонууд өгөгдөв.


Мянгат (мян)	Зуут (з)	Аравт (а)	Нэгж (н)
6	0	8	3
3	5	6	7
1	3	9	4

Тоо, хэмжээг хамгийн ихээс бага руу, эсвэл хамгийн багаас их рүү жагсаан бичихийг эрэмбэлэх гэж ойлгоно.

- Эдгээр тоог орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.
- Тоонууд дахь 3 гэсэн цифрийн байрлах орон, утгыг бичээрэй.
- Тоонуудыг ихээс бага руу эрэмбэлж бичээрэй.
- Тоо бүрээс 10, 100, 1000-аар их, бага тоог бичээрэй.
- Өгсөн тоонуудыг аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

**Жишээ 4** 6372 гэсэн тоо хэдэн аравт, зуут, мянгатыг агуулж байгаа вэ? Хүү, охин хэрхэн харуулсныг ойлгоод тайлбарлаарай.

Хүү тооны орны утгын карт хэрэглэн харуулжээ.



Охин орон, ангийн тууз хэрэглэн харуулав.



**78** 6590 ₮, 7800 ₮, 9320 ₮, 4651 ₮, 8955 ₮, 2599 ₮, 3900 ₮, 5128 ₮, 10000 ₮-ийг:  
 а. аравтаар, б. зуутаар, в. мянгатаар тус тус задлах болов.  
 Эдгээр дэвсгэртээс хэдийг бэлтгэх вэ? (Бодлогод төгрөгийг ₮-ээр тэмдэглэв.)

**79** Жишээд, тайлбарлаарай. Товчлол: мянгат (мян), зуут (з), аравт (а), нэгж (н).  
 5 з □ 52 а    19 мян □ 20 з    3 а 2 н □ 2 а 3 н    4 з 5 а □ 3 з 15 а

**80** Хэн их тоо бүтээх вэ?

- Тоглогч бүр орон, ангийн хүснэгт, 0-ээс 9 хүртэлх цифр бичсэн картууд бэлтгэнэ.
- Картуудаа холиод, багцаар нь доош харуулж тавина.
- Тоглогч бүр багцын дээрээс нэг карт авна. Тоог хүснэгтийн аль нэг нүдэнд бичнэ.
- Дахин нэг карт авч, тоог хүснэгтэд үлдсэн нүдний нэгэнд бичнэ. Уг үйлдлийг дахин 2 удаа давтана.
- Тоонуудаа жишнэ. Яаж тогловол их тоо бүтээх вэ? Үргэлжлүүлэн тоглоно. Дүрмээ өөрчилж болно.

Сурагч 1:

мян	з	а	н
			2

Сурагч 2:

мян	з	а	н
8			


**81** Үзвэрийн газраасурлагийн тоглолтын 1-ээс 4000 хүртэл дугаартай тасалбарыг худалдав. Сүүлийн гурван орон 789 байх дугаартай тасалбарын эзэд азтан болжээ. Ямар дугаартай тасалбар авсан үзэгчид азтан болсон бэ?

**82** Өгсөн тоонуудад харгалзах цэгийг тоон шулуун дээр олж тэмдэглээрэй.


а. 13, 17, 39, 52, 60, 65, 71, 78, 84, 96



б. 1, 6, 25, 34, 40, 48, 52, 73, 87, 99




в. 13, 21, 30, 42, 55, 58, 64, 76, 87, 99



г. 50, 29, 75, 40, 45, 60, 58, 80



**83** 3450, 3520, 3730, 3850, 3160 гэсэн тоонуудыг тоон шулуун дээр барагцаалан тэмдэглээрэй.



Орхисон тоо, үгийг бичээрэй.

$3450 < 3520$	$3450 > \square$	$\square < \square$
3450 нь 3520-аас . . . .	3450 нь $\square$ -аас . . . .	$\square$ нь $\square$ -аас . . . .
3520 нь 3450-аас . . . .	$\square$ нь 3450-аас . . . .	$\square$ нь $\square$ -аас . . . .

**Жишээ 5** 3, 6, 5, 4, 7, 2 цифрүүдээр “500-аас их, цифрүүд нь сондгой, давтагдаагүй байх хамгийн бага гурван оронтой тоо” зохиоё.

өгсөн цифрүүд: 3, 6, 5, 4, 7, 2

өгсөн цифрүүдээс сондгой нь: 3, 5, 7

500-аас их, цифр давтагдаагүй 3 оронтой тоо: 537, 573, 753, 735

эдгээрээс хамгийн бага 3 оронтой тоо: 537

**84** 1 9 6 5 2 цифрүүдийг хэрэглэн цифр давтагдахгүй байх дараах тоонуудыг зохиогоорой.

а. хамгийн бага гурван оронтой тоо,




б. хамгийн их дөрвөн оронтой тоо,

в. 3000-аас их, хамгийн бага дөрвөн оронтой тоо,

г. 600-аас бага, цифрүүд нь сондгой байх, хамгийн их гурван оронтой тоо.

## АРВАН МЯНГА ДОТОР ТООГ НЭМЭХ, ХАСАХ

- 85** Тавган дээр улаан, ногоон алим байлаа. Хоёр сурагч нийт алимын тоог шоо хэрэглэн олжээ. Тэдний хариуг жишээд, дүгнэлтийг гүйцээгээрэй.



$3 + 5$    $5 + 3$

Нэмэгдэхүүний байрыг солиход нийлбэрийн утга .....

- 86**



Хоёр сурагч цагариг шидэн тоглов. Тэд нийт цагаригийн тоог олох илэрхийлэл бичжээ.

$3 + 0$

$0 + 3$




Өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Тоон дээр тэгийг нэмэхэд .....  
Тэг дээр тоог нэмэхэд .....

Өөр ямар дүгнэлт гаргаж болох вэ?

- 87** Гурван өнгийн хэсэг шүр байв. Нийт шүрийн тоог хэдэн аргаар олж болох вэ? Бичиглэлийг ажиглаад, тайлбарлаарай.

$4 + 5 + 6 = ?$



Гурван сурагчийн хариу ямар гарсан бэ?  
 $4 + 5 + 6$  нийлбэрийг хэрхэн олох нь хялбар байсан бэ?

**Жишээ 1** Бодолтыг тайлбарлаарай.

- а.  $198 + 54 = 198 + (2 + 52) = (198 + 2) + 52 = 200 + 52 = 252$   
 б.  $86 + 67 = 86 + (14 + 53) = (86 + 14) + 53 = 100 + 53 = 153$

- 88** Илэрхийллийн утгыг олоорой.

- |                     |                    |                    |               |
|---------------------|--------------------|--------------------|---------------|
| а. $3 + 8 + 7$      | г. $240 + 90 + 60$ | ж. $58 + 3 + 27$   | к. $96 + 48$  |
| б. $30 + 80 + 70$   | д. $135 + 5 + 60$  | з. $96 + 235 + 4$  | л. $195 + 65$ |
| в. $300 + 180 + 20$ | е. $192 + 8 + 38$  | и. $467 + 75 + 25$ | м. $87 + 73$  |

- 89** Хүү 350, 180, 150 төгрөг хадгалав. Тэр нийт хэдэн төгрөгтэй болсон бэ?




а. Үлгэрийн ном, баримлын шавар худалдан авахад хэдэн төгрөг төлөх вэ?

1000 төгрөг

Үлгэрийн номын үнэ  ?

Баримлын шаврын үнэ  ?



илэрхийлэл


Нийлбэрийн утгыг яаж олох вэ?

6 мянга + 2 мянга = ..... мянга      6000 + 2000 = .....

б. Үлгэрийн ном, тэмдэглэлийн дэвтрийн үнийн зөрөө хэд вэ?

Үлгэрийн номын үнэ  ?

Тэмдэглэлийн дэвтрийн үнэ  ?



илэрхийлэл

Үнийн зөрөөг олохын тулд ялгаврын утгыг олно.


6 мянга – 3 мянга = ..... мянга      6000 – 3000 = .....

91 Тооцоолоорой.

- |                |                |                |                 |
|----------------|----------------|----------------|-----------------|
| а. 4 + 3       | д. 300 + 500   | и. 9 – 5       | н. 500 – 100    |
| б. 40 + 30     | е. 3000 + 500  | к. 90 – 50     | о. 5000 – 1000  |
| в. 400 + 300   | ж. 600 + 6000  | л. 900 – 500   | п. 8000 – 2000  |
| г. 4000 + 3000 | з. 1000 + 7000 | м. 9000 – 5000 | р. 10000 – 3000 |

92 Үлгэрийн ном, баримлын шавар, тэмдэглэлийн дэвтрийн аль нэгийг нь үнэ нөгөө хоёрын нийт үнээс ямар зөрөөтэй вэ? Хэрхэн олсноо тайлбарлаарай.

93



Дэвтэр, баллуур тус бүр нэгийг авахад хэдэн төгрөг төлөх вэ?

илэрхийлэл

$$750 + 230$$



Ном, өнгийн харандаа тус бүр нэгийг авахад хэдэн төгрөг төлөх вэ?

илэрхийлэл

$$3750 + 1230$$



Тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрт задалж бодвол:

$$\begin{aligned} 700 + 50 + 200 + 30 &= \\ = 700 + 200 + 50 + 30 &= \\ = 900 + 80 &= 980 \end{aligned}$$

$$\begin{aligned} 3000 + 700 + \dots + 1000 + \dots + \dots &= \\ = 3000 + 1000 + 700 + \dots + \dots + \dots &= \\ = 4000 + \dots + \dots &= \dots \end{aligned}$$



Тоонуудыг орон, ангийн хүснэгтэд байрлуулбал:

	Зуут	Аравт	Нэгж
	7	5	0
+	2	3	0

$7з + 2з$      $5а + 3а$      $0н + 0н$

	7	5	0
+	2	3	0
	9	8	0

Хариу: 980 төгрөг төлнө.

	Мянгат	Зуут	Аравт	Нэгж
	3	7	5	0
+	1	2	3	0

$3 \text{ мян} + 1 \text{ мян}$      $7з + 2з$      $5а + 3а$      $0н + 0н$

	3	7	5	0
+	1	2	3	0
	4	9	8	0

Хариу: 4980 төгрөг төлнө.

94

а.  $2750 + 230$

б.  $750 + 4230$

в.  $1750 + 5230$

г.  $3545 + 2314$

95

Нийлбэрийн утга олох загварыг ажиглаад, баганан бичиглэлийг гүйцээгээрэй.

	Мянгат	Зуут	Аравт	Нэгж
	4	5	6	9
+	2	3	7	3
	6	9	4	2

$\xrightarrow{10}$      $\xrightarrow{10}$

	4	5	6	9
+	2	3	7	3
			1	2
+		1	3	0
		8	0	0
	6	0	0	0
	6	9	4	2

		1	1
	4	5	6
+	2	3	7
	.	.	4
			2



3 оронтой тооны нэмэх үйлдэлтэй адил юм байна. Нийлбэрийн утга зөв эсэхийг яаж шалгах билээ?

96

Үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $3538 + 2365$

г.  $3508 + 4192$

ж.  $2358 + 4342$

к.  $6741 + 3157$

б.  $3665 + 4189$

д.  $1585 + 5256$

з.  $4259 + 651$

л.  $5163 + 3647$

в.  $1951 + 5930$

е.  $2097 + 3904$

и.  $5605 + 2395$


м.  $1826 + 7184$

97

Үзэгний сав, ном хэдэн төгрөгөөр хямдарсан бэ?




Үзэгний сав



илэрхийлэл

$$850 - 630$$



илэрхийлэл

Тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэрт задалж бодвол:

$$850 - 600 - 30 = 250 - \dots = \dots$$

$$6850 - 5000 - 600 - 30 = 1850 - 600 - \dots = 1250 - \dots = \dots$$

Тоонуудыг орон, ангийн хүснэгтэд байрлуулбал:

Зуут	Аравт	Нэгж
8	5	0
6	3	0

$8\text{з} - 6\text{з}$      $5\text{а} - 3\text{а}$      $0\text{н} - 0\text{н}$

8	5	0
-	6	3

Хариу: ..... төгрөгөөр хямдарсан.

Мянгат	Зуут	Аравт	Нэгж
6	8	5	0
5	6	3	0

$6\text{мян} - 5\text{мян}$      $8\text{з} - 6\text{з}$      $5\text{а} - 3\text{а}$      $0\text{н} - 0\text{н}$

6	8	5	0
-	5	6	3

Хариу: ..... төгрөгөөр хямдарсан.

98 а. 1850 – 630    б. 5850 – 2630    в. 8958 – 3615    г. 4367 – 1355

99 Ялгаврын утгыг олох загварыг ажиглаад, баганан бичиглэлийг гүйцээгээрэй.

Мянгат	Зуут	Аравт	Нэгж
3	8	2	3
1	2	3	8
2	5	8	5

		1	11	1	13
-	3	8	2	3	
	1	2	3	8	
	.	.	8	5	

3 оронтой тооны хасах үйлдэлтэй адил юм байна.



Ялгаврын утга зөв эсэхийг яаж шалгах вэ?

100 Үйлдлийг гүйцэтгээд, шалгаарай.

- а. 3538 – 2365    в. 4192 – 3508    д. 4342 – 2358    ж. 6780 – 3057  
 б. 3665 – 189    г. 7585 – 5256    е. 4259 – 651    з. 5400 – 3246

101 Үйлдлийг гүйцэтгээд, шалгаарай.

- а. 5106 – 327    в. 3279 + 821    д. 9521 – 532    ж. 3000 – 1518  
 б. 5106 + 327    г. 3279 + 4821    е. 9521 – 4532    з. 8000 – 5294



**Жишээ 2** Бодолтыг тайлбарлаарай.

$$123 - 56 = ?$$

56 дээр хэдийг нэмбэл 123 гарах вэ?

$$56 + 4 = 60$$

$$60 + 40 = 100$$

$$100 + 23 = 123$$

$$4 + 40 + 23 = 67$$

Иймд  $123 - 56 = 67$

$$4328 - 1973 = ?$$

1973 дээр хэдийг нэмбэл 4328 гарах вэ?

$$1973 + 7 = 1980$$

$$1980 + 20 = 2000$$

$$2000 + 2328 = 4328$$

$$2328 + 20 + 7 = 2355$$

Иймд  $4328 - 1973 = 2355$

**102** Тооцоолоод, зөв хариу гарсан эсэхийг шалгаарай.

а.  $413 - 254$

в.  $607 - 326$

д.  $1204 - 835$

ж.  $2139 - 720$

б.  $1165 - 537$

г.  $9136 - 3864$

е.  $8103 - 2860$

з.  $9000 - 5699$

**103** Охин эхний бодолтын алдааг тайлбарлав. Нөгөө бодолт зөв үү? Яагаад?

	7	0	5	0
-	3	4	3	2
	4	6	1	8

1 мянгатаа задалснаа мартжээ.

7 мян – 3 мян = 4 мян. Иймд ялгаврын мянгатын оронд 4 гэж бичсэн байна.



+	3	6	0	6
		2	9	5
	3	8	0	1

**104**

Дэвтэртээ бичээд, нийлбэр нь 1000 байх тоонуудыг олж холбоорой.

738      456      270  
730                                      5  
905      262      544

Нийлбэр нь 10000 байх тоонуудыг олж холбоорой.

3505      2900      2385  
7100                                      5050  
7615      4950      6495

**105** Бодолтыг ажиглаад, цээжээр бодоорой.

Жишээ:  $3245 + 697 = 3245 + 700 - 3 = 3945 - 3 = 3942$

$$4719 - 2199 = 4719 - 2200 + 1 = 6919 + 1 = 6920$$

а.  $576 + 299$

в.  $564 + 198$

д.  $841 + 998$

ж.  $1580 + 2900$

и.  $4189 + 3498$

б.  $580 - 299$

г.  $971 - 498$

е.  $657 - 386$

з.  $6925 - 3299$

к.  $8518 - 4975$

**106** Барааны хямдралын өмнөх ба дараах үнийг бичжээ. (₮ нь төгрөг)

а. Бээлий

б. Самар

в. Сам

г. Хоолны сав

9999₮ 6199₮

8199₮ 6599₮

2500₮ 1990₮

7900₮ 4990₮

Бараа бүр хэдээр хямдарсан бэ? Ямар бараа хамгийн их хямдарсан бэ?

10000 төгрөгөөр ямар бараануудаас авч болох вэ? Хэдэн төгрөг үлдэх вэ?

**Жишээ 3** Ойролцоогоор тооцоольё.

Дэлгүүр эхний сард 343, хоёр дахь сард 435 хос гутал худалджээ. Хоёр сард нийт хэдэн хос гутал худалдсаныг ойролцоогоор олоорой. Дараа нь нэмж тооцоолоорой.



Тоонуудыг зуутаар тоймловол, 343 нь 300, 435 нь 400 болно.  $300+400=700$ . Иймд 700 гаруй хос гутал худалдсан.

Тоонуудыг аравтаар тоймловол, 343 нь 340, 435 нь 440 болно.  $340+440=780$ . Иймд 780 орчим хос гутал худалдсан.



$$343 + 435 = (300 + 40 + 3) + (400 + 30 + 5) = (300 + 400) + (40 + 30) + (3 + 5) = 700 + 70 + 8 = 778 \text{ (хос гутал)}$$

**107** Төлөх нийт үнийг ойролцоогоор олоорой. Дараа нь нэмж тооцоолоорой.

- а. 4500 төгрөгийн аяга, 2700 төгрөгийн халбага, савхны хос
- б. 5850 төгрөгийн цамц, 1990 төгрөгийн шүдний сойз
- в. 1750 төгрөгийн дүүфүү, 2490 төгрөгийн шүүс, 2790 төгрөгийн үзэм

**108** Дараах барааг авахаар 10000₮ өгвөл хариултад хэдэн төгрөг авах вэ?

- а. 1 кг гадил 4990 төгрөг
- б. 1 кг алим 5490 төгрөг

**109** Усан будаг 3750₮, гортиг 2560₮, үзэг 730₮-ийн үнэтэй. Эдгээрийг худалдан авахад ойролцоогоор хэдэн төгрөг хэрэгтэй вэ? Уг мөнгийг өгвөл хэдэн төгрөгийн хариулт авах вэ? (Бодлогод төгрөгийг ₮-ээр тэмдэглэв.)

**110** Бараа бүр ойролцоогоор хэдэн төгрөгөөр хямдарсан бэ? Яаж олсон бэ? Бараа бүр хэдээр хямдарсан бэ? Ойролцоолсноос ямар зөрөөтэй гарсан бэ?

Барааны нэр	Үнэ (төгрөг)
Үзгэн бал	<del>800</del> 590
Дэвтэр	<del>250</del> 190
Тосон харандаа	<del>4000</del> 2990
Өнгийн харандаа	<del>1200</del> 790

Барааны нэр	Үнэ (төгрөг)
Өнгийн цаас	<del>2300</del> 1690
5 ширхэг саван	<del>6420</del> 5630
Шүдний оо	<del>2170</del> 1840
Халбага сэрээ	<del>5500</del> 4900

10000 төгрөгт багтаан ямар бараанууд авч болох вэ?

**111**



1.  $165 + 5337$      $2136 + 3864$      $8810 - 5879$      $9540 - 5647$
2. Халиун 2850₮ үнэтэй усан будаг, 1260₮ үнэтэй зургийн дэвтэр худалдан авчээ. Нийт хэдэн төгрөг төлсөн бэ? Усан будаг ба зургийн дэвтрийн үнийн зөрөөг олоорой.

## БАТАТГАХ

**112** Кинотеатрт том хүний тасалбар 5000 төгрөг, хүүхдийнх 4000 төгрөгийн үнэтэй байлаа.

- Том хүн хүүхэдтэйгээ кино үзвэл хэдэн төгрөг төлөх вэ?
- Хоёр хүүхэд кино үзвэл хэдэн төгрөгөөр тасалбар авах вэ?
- Хоёр том хүн кино үзвэл хэдэн төгрөгөөр тасалбар авах вэ?
- Хүүхдийн төрсөн өдрийн урамшуулал болгон тасалбарыг 500 төгрөгөөр хямдруулжээ. Том хүн ба хүүхдийн тасалбарыг хэдээр авах вэ?

**113** Бодолтуудын алдааг олж, тайлбарлаарай.

а. 

	2	7	2	
-	5	3	5	4
	8	0	7	4

 б. 

	2	8	5	3
-	7	1	5	1
	9	0	0	1

 в. 

	6	3	0	5
-		2	4	7
	6	0	5	8

 г. 

	5	5	5	4
-	2	3	4	5
	3	2	1	9

**114** Хамгийн их ба хамгийн бага тооны нийлбэрийн утга, зөрөөг олоорой.

- 3036, 2105, 1939, 1958
- 4001, 3452, 4000, 3453
- Цифрүүдээр дөрвөн оронтой 4 тоо зохиогоод, бодоорой.

**115** 2490, 6515, 9743, 37, 8001 тоо тус бүр дээр хэдийг нэмбэл 10000 гарах вэ? 2490, 6515-ыг мянгатаар тоймлон нэмээрэй. Зуутаар тоймлон нэмээрэй.

**116** Нийлбэр, ялгаврын утгыг олоорой.

- $8786 + 47$
- $4355 + 928$
- $5789 + 1234$
- $2386 + 3459$
- $4472 - 98$
- $3250 - 752$
- $7925 - 3819$
- $7123 - 5654$

**117**



Тэгш тоонуудын нийлбэрийн утга тэгш тоо гарна. Харин хоёр тэгш тооны ялгаврын утга сондгой тоо гарна.

Хоёр сондгой тооны нийлбэрийн утга сондгой тоо гарна. Хоёр сондгой тооны ялгаврын утга тэгш тоо гарна.



Хүүхдүүд үнэн хэлсэн эсэхийг шалгаад, учрыг тайлбарлаарай. Гурван сондгой тоог нэмэхэд тэгш, сондгой тооны аль нь гарах вэ? Яагаад?

**118** Иргэд бямба гарагт 1596, ням гарагт 2667 мод тарив. Хэдэн мод тарьсан бэ?


**119** Дүрсүүдийг нэрлээрэй. Дүрс бүр бусдаасаа ямар ялгаатай вэ?



Адил талт дүрсүүдийн талын урт 8 см байвал периметр нь хэд байх вэ?

120

Тоог тоймлосон аргыг тайлбарлаарай. Гүйцээн бичээрэй



- а. 256 гэсэн тоог аравтаар тоймлоё. 256 нь 250 ба 260-ын алинд ойр вэ?  
 $256 - 250 = 6$  буюу 256 нь 250-аас 6 нэгж зайд оршино.  
 $260 - 256 = 4$  буюу 256 нь 260-аас . . . . нэгж зайд оршино.  
 $6 > 4$  тул 256 нь 260-д илүү ойр. Иймд 256-г аравтаар тоймлоход . . . .
- б. 256 гэсэн тоог зуутаар тоймлоё. 256 нь 200 ба 300-ийн алинд ойр вэ?  
 $256 - 200 = . . . . .$  буюу 256 нь 200-аас . . . . . нэгж зайд оршино.  
 $300 - 256 = . . . . .$  буюу 256 нь . . . . .

121

Дээрх аргаар тоонуудыг аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

3, 8, 17, 532, 455, 1271, 2530, 5, 49, 86, 120, 5918, 9083, 1706, 3512, 6009

122

Бараа бүр ойролцоогоор хэдэн төгрөгөөр хямдарсан бэ? Яаж олсон бэ? Бараа бүр хэдээр хямдарсан бэ? Ойролцоолсноос ямар зөрөөтэй гарсан бэ?


Барааны нэр	Үнэ (төгрөг)	Барааны нэр	Үнэ (төгрөг)
Шингэн саван	<del>4550</del> 3790	Шүүс	<del>7160</del> 5730
Ариун цэврийн цаас	<del>3080</del> 2460	Шоколад	<del>2310</del> 1970
Гоймон	<del>1130</del> 940	Жигнэмэг	<del>3920</del> 3140

10000 төгрөгт багтаан ямар бараанууд авч болох вэ?


123

Хамгийн дээд талын тэгш өнцөгтөд ямар тоо бичигдэх вэ?

- а. 7, 3, 5-ыг доод мөрөнд байрлуулж, сумын дагуу нэмэхэд хамгийн дээд талд 18 гарав.  
 7, 3, 5-ын байрлах дарааллыг өөрчилбөл 18 гарах уу? Яагаад?



- б. 4, 7, 6, 9 тоонуудыг доод мөрөнд яаж байрлуулан нэмбэл дээд талд хамгийн их тоо гарах вэ? Яаж байрлуулбал хамгийн бага тоо гарах вэ? Хамгийн бага ба их тооны хоорондох бүх тоог гаргаж чадах уу? Хийж туршаад, тайлбарлаарай.



124




1. Өгсөн тоонуудын хамгийн ихээс хамгийн багыг хасаарай.

5600, 6710, 5601, 5699, 6709, 5599, 6711


2. Хамгийн их гурван оронтой тоо ба хамгийн бага дөрвөн оронтой тооны нийлбэрийг олоорой.
3. Гурван сурагч нийт 5030 төгрөгтэй байв. Нэг дэх сурагч 1260, хоёр дахь нь 1980 төгрөгтэй. Гурав дахь сурагч хэдэн төгрөгтэй вэ?

## ДҮРСИЙГ ТАНИХ




**125** Өнцгийн талаар чи юу мэдэх вэ? Дээрх зургаас өнцгийн жишээг олоорой.


**126** Шугам, харандаа хэрэглэн өнцөг зуръя.



Дэвтэртээ  
цэг тэмдэглэе.




Цэгээс шулуун зураас  
зуръя. Цацраг үүснэ.




Цэгээс дахин цацраг  
зуръя. Өнцөг үүснэ.



Нэг цэгээс эхлэлтэй хоёр цацрагийн  
хооронд хашигдсан дүрс нь **ӨНЦӨГ** юм.





**127**

 Цаас, савх, баримлын шавар хэрэглэн тэгш өнцөг хийе.

а. Зурагт үзүүлснээр цаасыг  
нугалж, тэгш өнцөг хийе.


б. Савхаар тэгш өнцөг хийе.



Битүү ирмэгийг давхцуулж  
нугалахад тэгш өнцөг үүснэ.


Хийсэн өнцгөө тэгш эсэхийг цаасаар  
хийсэн тэгш өнцгөөр шалгана.

**128** Аль нь тэгш өнцгөөс их, бага, тэнцүү болохыг шалгаарай.






Тэгш өнцгөөс их хэмжээтэй өнцгийг **МОХОО ӨНЦӨГ** гэнэ.




Тэгш өнцгөөс бага хэмжээтэй өнцгийг **ХУРЦ ӨНЦӨГ** гэнэ.




Нэг тал нь давхацсан байх 2 тэгш өнцгөөр үүссэн өнцгийг **ДЭЛГЭМЭЛ ӨНЦӨГ** гэнэ.

**129** Тэгш өнцөг зуръя.



Дэвтэрт зурах:



Тэгш өнцгийг зурагт үзүүлснээр тэмдэглэдэг байна.

**130** Хурц, мохоо өнцгийг зураарай. Яаж зурснаа тайлбарлаарай.

**131** Хүснэгтийг дэвтэртээ зуръя.

Тэгш өнцөг агуулсан	Хурц өнцөг агуулсан	Мохоо өнцөг агуулсан

Зургаас өнцгийн жишээг олоорой. Ямар өнцөг агуулснаар нь хүснэгтэд ангилж бичээрэй. Хийснээ тайлбарлаарай.



**132** Хүснэгт дэх тоонуудын нийлбэрийн утга хэд гарах вэ? Тоо бүрийг тоймлоод нэмэхэд өмнөх нийлбэрийн утгаас ямар тоо гарах вэ? Тооцоолж шалгаарай.

а. Тоо бүрийг аравтаар тоймлон нэмэх

23	45	37	55
61	52	39	18
77	65	33	15

б. Тоо бүрийг зуутаар тоймлон нэмэх

693	328	754
286	819	147
571	465	932

в. Тоо бүрийг мянгатаар тоймлон нэмэх

2065	610	172
726	1148	1504
1689	590	213

Шалгахдаа хүснэгтийг дэвтэртээ зурж, тоймлоход гарах тоонуудыг бичээрэй.


**133**



Өнцгийг нэрлэе.


Тоглогчид ээлжлэн цагийн хоёр зүүг хөдөлгөн өнцөг үүсгэнэ.

Нөгөө тоглогч өнцгийг нэрлэнэ. Таалгасан нь зөв эсэхийг шалгана.



**134** Зурагт юу нь шулуунтай төстэй вэ? Тэдгээр нь ямар байрлалтай байна вэ?


**135** Аль хос шулуун огтлолцсон бэ? Огтлолцсон шулуунууд хоорондоо тэгш, хурц, мохоо өнцгийн алийг үүсгэсэн бэ?




Шулуунууд хоёр тийш тасралтгүй үргэлжилнэ.



**136** Цаасаар хийсэн тэгш өнцгөө дэлгэе. Нугалаасуудыг шулуун гэж төсөөлье. Эдгээр нь тэгш өнцгөөр огтлолцоно.



**137** Дэвтрийн зэрэгцээ хоёр шугамын хоорондох зайг хэмжээрэй. Шугамаа шилжүүлэхэд энэ хоёр шугамын хоорондох зай өөрчлөгдөж байна уу? Шалгаарай.



Хоорондоо тэгш өнцөг үүсгэн огтлолцсон хоёр шулууныг **харилцан эгц шулуунууд** гэнэ.

Хоорондоо ижил зайтай орших, үл огтлолцох хоёр шулууныг **зэрэгцээ шулуунууд** гэнэ.



Харилцан эгц гэдгийг өөрөөр перпендикуляр, зэрэгцээг параллел гэж хэлдэг.



**138** Харилцан эгц, зэрэгцээ шулуунуудын жишээг олъё.



Эргэн тойрноо ажиглая. Харилцан эгц, зэрэгцээ шулуунуудын жишээг олж хүснэгтэд бичье.



Харилцан эгц шулуунуудын жишээ	Зэрэгцээ шулуунуудын жишээ
Хүснэгтийн хэвтээ, босоо зураасууд, ширээний урт, өргөн	Хүснэгтийн хэвтээ зураасууд, ширээний зэрэгцээ ирмэгүүд

**139** а. Харилцан эгц хоёр шулууныг зуръя. б. Зэрэгцээ хоёр шулууныг зуръя.



в. Дэвтэртээ харилцан эгц, зэрэгцээ тус бүр 2 хос шулуун зураарай.

**140** Зохиомж бүтээе.



**141**



Заавар бичээрэй: Хоёр шулуун харилцан эгц болохыг яаж мэдэх вэ?  
Хоёр шулуун зэрэгцээ болохыг яаж мэдэх вэ?

Харилцан эгц ба зэрэгцээ шулуунуудыг зурж, найздаа шалгуулаарай.

**142**

Өгсөн тоог дээд орноор нь тоймлоорой.

Тоймлоход гарах тоон дээр ямар үйлдэл хийвэл өгсөн тоо гарах вэ?

29, 97, 91, 83, 86, 72, 78, 563, 528, 607, 674, 875, 825, 1893, 2340, 7265, 7635

**143**

Жишээг ажиглаад, бодоорой.

$$74 - 39 = 74 - 40 + 1 = 34 + 1 = 35$$

$$634 - 283 = 634 - 300 + 17 = 334 + 17 = 351$$

$$61 - 38$$

$$83 - 29$$

$$72 - 46$$

$$90 - 36$$

$$53 - 17$$

$$84 - 28$$

$$293 - 59$$


$$721 - 396$$

$$453 - 275$$

$$6583 - 478$$


$$8402 - 3295$$





144 Бид ямар дүрсийн талаар мэдэх билээ? Дээрх зургаас дүрсийг олж, нэрлээрэй.

145 а. Дэвтэртээ дүрсийн дугаар, түүний ард тал, орой, өнцгийн тоог бичээрэй. Нэг дүрсийн тал, орой, өнцгийн тооны талаар юу хэлж болох вэ?



б. Хүснэгтийг зураарай. Дүрсүүдийг ялгаж, дугаарыг хүснэгтэд бичээрэй.

Гурван өнцөгтэй	Дөрвөн өнцөгтэй	Таван өнцөгтэй	Зургаан өнцөгтэй	Долоон өнцөгтэй

в. Дүрсүүдийг нэрлээрэй.

Эдгээр нь **хавтгай**, **битүү** дүрс. Дүрсийн тал бүр **шулуун шугам** байна. Ихэнх дүрсийг өнцгийн тоогоор нэрлэж болох нь.




г. Өгсөн шинжээр дүрсүүдийг ялгаж, хүснэгтэд дугаарыг бичээрэй.

	Харилцан эгц талуудтай	Зэрэгцээ талуудтай
Тэгш өнцөгтэй	1,	1,
Тэгш өнцөггүй		5,

д. Аль дүрс хэдэн тэгш өнцөгтэй байна вэ?

е. 3, 13, 15 дугаартай дүрсүүд ямар ялгаатай байна вэ?


**146** Дүрсүүдийг нэрлээрэй. Өмнөх дүрсүүдээс ямар ялгаатай байна вэ? Эдгээр нь битүү дүрс мөн үү?



**147** Хэрчмийн уртыг хэмжээрэй. Хэмжээг дэвтэртээ бичээрэй.



**148** Дүрсүүдийг дугаарлав.



а. Өгсөн шинжээр дүрсүүдийг ангилж, дугаарыг хүснэгтэд ялгаж бичээрэй.


Шинж	Бүх өнцөг нь тэгш	Тэгш өнцөггүй
Дөрвөн талтай	2,	
Дөрвөн талтай биш		

б. 3, 6 дугаар дүрс хэдэн тал, өнцөгтэй вэ? Дүрсийг нэрлээрэй.

Дөрвөн өнцөгт, таван өнцөгт, зургаан өнцөгт, найман өнцөгт зэрэг дүрсүүдийг өөрөөр **олон өнцөгт** гэж нэрлэдэг байна.



**149** Зураг бүрээс олж харсан дүрсийн нэр, тоог бичээрэй.



**150** Дүрсүүдийг нэрлээрэй. Дүрс бүр ямар тоог төлөөлж байна вэ?

			= 26	Нийлбэрийн утга
			= 33	
			= 23	
= 31	= 24	= ?	= ?	
Нийлбэрийн утга				

Үйлдлийг гүйцэтгээрэй.

$$\text{Blue trapezoid} + \text{Yellow circle} + \text{Pink arrow} + \text{Red pentagon} = ?$$

$$8 \times \text{Blue trapezoid} + 9 \times \text{Pink arrow} - \text{Green triangle} = ?$$

$$50 \div \text{Green triangle} + 56 \div \text{Yellow circle} - \text{Red pentagon} = ?$$

Үүнтэй адил бодлого зохиогоорой.

151




Бид тэнхлэгийн тэгш хэмийн тухай юу мэдэх вэ? Тэгш хэмтэй юмсыг олж, нэрлээрэй.


152

Доорх 3 зургийг цаасан дээр зураарай. Цэгүүдээ холбох, зайг хэмжих, цаасаа нугалах зэргээр цэгүүд босоо зураасны хувьд тэгш хэмтэй эсэхийг шалгаарай.


а.




б.



в.







Тэгш хэмтэй цэгүүдийг холбосон хэрчим тэгш хэмийн тэнхлэгтэй харилцан эгц байна. Цэгүүд тэнхлэгээс ижил зайд оршино.



153

Дүрсүүдийн аль нь тэгш хэмтэй вэ? Яаж мэдсэн бэ?




154

Цаасаар дүрсүүд хийгээрэй. Аль нь тэгш хэмтэй байна вэ? Нугалж шалгаарай.


155

Тэгш хэмийн тэнхлэгийг зурагт дүрслэв. Дүрсийг дэвтэртээ гүйцээж зураарай.


а.




б.




в.



г.




д.




156

Дүрсүүдийг дэвтэртээ зураарай. Дүрсүүдийн тэгш хэмийн тэнхлэгийг зураарай.


а.




б.




в.



г.



д.




157

Үгэнд тэгш хэмтэй хэдэн ялгаатай үсэг байна вэ?


**ТЭГШ ХЭМ**

Тэгш хэмийн тэнхлэгийг нь зураарай. Өөр ямар цифр, үсэг тэгш хэмтэй вэ? Тэгш хэмтэй үсгүүдээр үг зохиогоорой.


**158** Дүрс тэгш хэмийн хэдэн тэнхлэгтэй вэ? Тэгш хэмийн тэнхлэгийг зураарай.



**159** Тэгш хэмтэй дүрс, чимэглэл бүтээгээрэй.




**160** Тэгш хэмтэй дүрс зурж, хээ үүсгэе.



**161** Зааварт өгсөн дүрсийг гүйцээж зураад, хэлэлцээрэй.

- а. 5 талтай, тэгш хэмийн нэг тэнхлэгтэй дүрс      б. 6 талтай, тэгш хэмийн нэг тэнхлэгтэй дүрс      в. 6 талтай, тэгш хэмийн хоёр тэнхлэгтэй дүрс



**162** Тэгш хэмийн тэнхлэгийг цэнхэрээр зуржээ.

- а. Хүснэгт дэх тоонуудыг орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.  
 б. Хамгийн их ба бага тооны зөрөөг олоорой.  
 в. Цэнхэр тэнхлэгийн хувьд тэгш хэмтэй байрлах нүднүүд дэх тоонуудын нийлбэр болон ялгаврын утгыг олоорой.  
 г. Аль тоонуудыг нэмэхэд 10000-д хамгийн ойр тоо гарах вэ?


	1845	4572	3187
6158		2691	1928
3519	5269		5265
1940	6152	2837	

## СОРИХ

**163** Дэвтэртээ дараах өнцгүүдийг зураарай.  
а. тэгш      б. мохоо      в. хурц      г. дэлгэмэл

**164** Хоёр олон өнцөгт зураарай. Зурсан дүрсүүдийн нэр, шинжийг бичээрэй.

**165** Дүрсүүдийг ангилж, хүснэгтэд дугаарыг бичээрэй.




Зэрэгцээ талуудтай	Харилцан эгц талуудтай	Тэгш өнцөгтэй

Тэгш хэмтэй дүрсүүдийн тэгш хэмийн тэнхлэгийг зураарай.


## БАТАТГАХ

**166** Цаас нугалан хийж үзээд хариулаарай.  
а. Дэлгэмэл өнцгийг яаж хурц, мохоо өнцгүүдэд хуваах вэ?  
б. Мохоо өнцгийг яаж тэгш, хурц өнцгүүдэд хуваах вэ?

**167** Харилцан эгц, зэрэгцээ шулуунуудыг олоорой.  
Зурагт өнцгийг өнгөөр буджээ. Тэгш, хурц, мохоо, дэлгэмэл өнцгийг олоорой.



**168** Өгсөн хэрчмийг дэвтэртээ зураарай.  
Түүнтэй харилцан эгц, зэрэгцээ хэрчмүүдийг тус тус зураарай.




Яаж зурснаа тайлбарлаарай.


**169** Хэдэн тэгш өнцөгтэй байна вэ?



Дэвтэр



Шугам



Өрөөний булан




Хайрцаг

170




Дүрсүүдээр зохиомж хийе.

Дугуй, гурвалжин, дөрвөн өнцөгт, таван өнцөгт, зургаан өнцөгт дүрсүүдийг бэлтгэнэ. Дүрсүүдийг эвлүүлэн зохиомж хийнэ. Зохиомжид ямар дүрс хэд орсон бэ?



171


Зохиомж бүрийг хэдэн ширхэг ямар дүрсүүдээр бүтээсэн бэ?



Аль дүрс тэгш хэмтэй вэ? Дүрс, тэгш хэмийн тэнхлэгийг дэвтэртээ зураарай. Гэр, орчноосоо тэгш хэмтэй дүрс, хээг олоод, бичээрэй.

172

Тэгш хэмийн тэнхлэгийг зураарай.



173

Би ямар дүрс вэ? Зурж үзүүлээрэй.

- а. Би 4 талтай. Бүх өнцөг тэгш.
- б. Би гурван өнцөгтэй, нэг нь тэгш. Би тэгш хэмийн нэг тэнхлэгтэй.
- в. Би зургаан мохоо өнцөгтэй. Мөн тэгш хэмийн хоёр тэнхлэгтэй.

174




5, 6 дугаар дүрсэд будсан ▲ хэдэн ширхэг байх вэ?

- 1. ▲
- 2. ▲ ▲
- 3. ▲ ▲ ▲
- 4. ....
- 5. ....
- 6. ....

175

Дараах тоонуудыг тоон шулуун дээрх харгалзах цэгтэй нь холбоорой.


- а. 3, 7, 19, 31, 42, 54, 67, 75, 86, 98




- б. 10, 90, 150, 230, 370, 460, 520, 640, 780, 855, 975




## АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ



**176** Өгсөн үгнүүдээр бодлого зохиож, бодоорой. Бодолтоо тайлбарлаарай.



**Жишээ 1** Сургууль 1892 сурагчтай. Эдгээрийн 965 нь хөвгүүд. Сургуульд хэдэн охин суралцдаг вэ? Охид, хөвгүүдийн аль нь хэдээр олон бэ? Бодолтыг гүйцээн, тайлбарлаарай.



1) Сургуульд хэдэн охин суралцдаг вэ?

$$1892 - 965 = \boxed{\phantom{000}} \text{ (охин)}$$

2) ..... нь .....-аас хэдээр олон бэ?

$$\boxed{\phantom{000}} - \boxed{\phantom{000}} = \boxed{\phantom{000}} \text{ (.....)}$$

Шалгая:  $\boxed{\phantom{000}} + \boxed{\phantom{000}} = \boxed{\phantom{000}} \text{ (.....)}$

**177** Гэрээс сургууль хүртэл 565 м, сургуулиас дэлгүүр хүртэл 1326 м. Болд гэрээс сургууль, сургуулиас дэлгүүр хүртэл явсан бол барагцаагаар хэдэн метр газар явсан бэ?

**178** Бат дэлгүүрээс 1800 төгрөгөөр дэвтэр, 3200 төгрөгөөр ном, дэвтэр ба номын үнэтэй тэнцүү төгрөгөөр хавтас худалдан авав. Дэвтэр, ном, хавтсыг барагцаагаар хэдэн төгрөгөөр авсан бэ?

**179** Сарнай 1950 төгрөгөөр дэвтэр, 260 төгрөгөөр харандаа авахад 2790 төгрөг үлджээ. Сарнай анх хэдэн төгрөгтэй байсан бэ?

**180** Сарнай дэлгүүрээс жимс 2500, жигнэмэг 3750, ундаа 3000 төгрөгөөр худалдан авав. Чимэгмаа жигнэмэг 2900, боорцог 5600 төгрөгөөр худалдан авав. Хэн нь хэдэн төгрөг илүү зарцуулсан бэ?

**181** Суудлын галт тэргэнд 1365 том хүн, 278 хүүхэд суужээ. Дараагийн буудлаас 276 том хүн, 46 хүүхэд сууж, 419 том хүн, 28 хүүхэд буухад галт тэрэг хэдэн том хүн, хэдэн хүүхэдтэй явсан бэ? Энэ үед хэдэн зорчигчтой болсон бэ?

**182** Ногооны зооринд 4917 кг төмс, түүнээс 72 кг-аар их байцай байсан. Нийт хэчнээн килограмм хүнсний ногоо байсан бэ?

**183** Барааны агуулахад эхний боодолд 1794 м даавуу байв. Хоёр дахь боодолд түүнээс 676 м-ээр их даавуу байсан бол энэ агуулахад бүгд хэдэн метр даавуу байсан бэ?

**184** Үзэсгэлэн худалдаанд эмэгтэй хүний 1517 гутал, түүнээс 800-аар цөөн эрэгтэй хүний гутал байв. Эрэгтэй хүнд зориулсан гутал хэд байсан бэ? Нийт хэдэн гутал байсан бэ?


**185** Гурван анги нийлээд 950 кг хаягдал цаас цуглуулав. Эхний анги 427 кг хаягдал цаас, хоёр дахь анги эхнийхээс 192 кг-аар бага цаас цуглуулав. Гурав дахь анги хэдэн килограмм хаягдал цаас цуглуулсан бэ?

**186** Сургууль 2035 сурагчтай. Үүнээс 920 нь урлагийн, 815 нь биеийн тамирын дугуйланд суралцдаг. 108 сурагч ямар нэг дугуйланд суралцдаггүй байв.  
 а. Дугуйланд нийт хэдэн сурагч суралцдаг вэ?  
 б. Хэдэн сурагч урлаг, биеийн тамираас өөр дугуйланд суралцдаг вэ?

**187** Ажилчид эхний өдөр 345 м, хоёр дахь өдөр эхнийхээс 124 м-ээр илүү, гурав дахь өдөр хоёр дахь өдрөөс 287 м-ээр бага шуудуу ухав. Гурван өдөр нийлээд хэдэн метр шуудуу ухсан бэ?

**188** Дэлгүүр 8617 шуудай гурилыг дөрвөн газар тараав. Нэгдүгээр газарт 2490, хоёрдугаар газарт нэгдүгээрээс 120-оор бага шуудай гурил хүргэв. Гуравдугаар газарт нэгдүгээрээс 84 шуудай илүү хүргэсэн. Дөрөвдүгээр газарт хэдэн шуудай гурил хүргэсэн бэ?

**189** Зураглалаар бодлого зохиож бодоорой.



**190** Бодлого зохиож бодоорой.


а. 

Хасагдагч	6105	5000	?
Хасагч	3095	?	1996
Ялгаврын утга	?	2438	4055

 б. 

1 дэх дэлгүүр	610	1500	?
2 дахь дэлгүүр	309	?	398
Бүгд	?	3052	651

**191** Зураглалаар бодлого зохиож бодоорой.





## ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

Бид сайн болон муу үйлийн тухай юу мэдэх билээ?



**192** Сайн, муу үйлийг ялган бичээрэй. Учрыг тайлбарлаарай.

Бусадтай  
зелдэг  
харилцах

Бусдын эд  
зүйлийг  
асуулгүй авах

Утас,  
компьютероор  
удаан тоглох

Бусдын  
амжилтад  
баярлах

Бусдыг  
өрөвдөн  
хайрлах

Бусдад  
сайныг  
хүсэх

Бусдыг  
муулах

Худал  
хэлэх

Амьтан  
хооллох

Хогоо ил  
задгай хаях

Зөв зүйлд  
бусдад туслах

Амьтны  
амь таслах

Бусдад  
атаархах

**193**



Ямар үйл нь  
илүү чухал вэ?

- А. Худал хэлэхгүй байх.
- Б. Амьтныг зовоохгүй байх.
- В. Хогоо ил задгай хаяхгүй байх.
- Г. Хулгай хийхгүй байх.

Сурагчид саналаа цаасан дээр бичжээ.

Г	Б	Г	Б	А	В	Г	Б	Г	Б
Б	А	В	Г	Б	А	Б	Г	Б	А
А	Г	Б	А	В	Б	Г	В	Б	Г

- а. Хэдэн сурагч хариулсан бэ? Тэд ямар үйлийг чухал гэснийг яаж мэдэх вэ?
- б. Хүснэгт зураарай. Хоёр дахь баганад саналыг зураасаар бүртгээрэй.

Үйл	Бүртгэл	Давтамж
А. Худал хэлэхгүй байх		6
Б. Амьтныг зовоохгүй байх		
В. Хогоо ил задгай хаяхгүй байх		
Г. Хулгай хийхгүй байх		

1 -
2 -
3 -
4 -
5 -

- в. Тэмдэглэгээг тоолж, хүснэгтийн гурав дахь баганад бичээрэй. Давтамжийн нийт тоо санал өгсөн бүх сурагчийн тоотой тэнцүү байна уу?
- г. Сурагчид ямар үйлийг илүү чухал гэж үзсэн бэ?

**194**





Дээрх үйлүүдийн аль нь илүү чухал болохыг ангийнхаа сурагчдаас асууж бүртгээрэй. Сурагчид ямар үйлд илүү санал өгсөн бэ?

**195** Өмнөх хүснэгтээ хэрэглэн саналын тоог зурган диаграммаар дүрсэлье.

а. 1 сурагчийн саналыг  дүрсээр илэрхийлэн зураарай.

Сурагчдын хувьд чухал үйл



А. Худал хэлэхгүй байх	
Б. Амьтныг зовоохгүй байх	
В. Хогоо ил задгай хаяхгүй байх	
Г. Хулгай хийхгүй байх	


Түлхүүр:  
 нь 1 санал

Дүрсийн тоо нь саналын тоотой тэнцүү эсэхийг шалгаарай.

б. 2 сурагчийн саналыг  дүрсээр илэрхийлэн, гүйцээж зураарай.

Сурагчдын хувьд чухал үйл

А. Худал хэлэхгүй байх	
Б. Амьтныг зовоохгүй байх	
В. Хогоо ил задгай хаяхгүй байх	
Г. Хулгай хийхгүй байх	

Түлхүүр:  
 нь 2 санал

- Дугуйн тоо яагаад багассан бэ? 1 хагас дүрс хэдэн саналтай тэнцүү вэ?
- Бүх дугуй хэдэн саналыг илэрхийлэх вэ? Энэ нь нийт сурагчдын тоотой тэнцэх эсэхийг шалгаарай.
- Ямар үйлийг хамгийн цөөн сурагч чухал гэсэн бэ?
- Худал хэлэхгүй байх болон амьтныг зовоохгүй байхыг сонгосон сурагчдын тооны зөрөөг олоорой.
- Асуулт зохиож, сурагчдаас асуугаарай. Хариултыг шалгаарай.



Диаграмм байгуулбал юмсын давтамжийг харьцуулахад хялбар болно.


Зурган диаграммыг босоогоор, хэвтээгээр ч дүрсэлж болно.



Зурган диаграмм байгуулахад анхаарах зүйлс:

- 1 Диаграммын гарчгийг (нэрийг) бичнэ.
- 2 Тоо, хэмжээг нь дүрслэх юмсын нэрийг бичнэ.
- 3 Түлхүүр хэсэгт зураг ямар тоо, хэмжээг илэрхийлснийг бичнэ.
- 4 Агуулгыг төлөөлөх зураг, дүрсээ сонгож байрлуулна (зурна).

1 Гарчиг



4



2

3

Түлхүүр:  .....

**196** Диаграммуудыг ажиглаад, ярилцаарай.


а) Сурагчдын хувьд чухал үйл      б) Сурагчдын хувьд чухал үйл



б) в) диаграммууд юугаараа ижил, юугаараа ялгаатай вэ?



в) Сурагчдын хувьд чухал үйл



а)-д үзүүлсэн зурган диаграммыг гүйцээн зураарай.

б)-д байгаа диаграммыг ажиглаарай. а) дахь дугуйн тоогоор дөрвөлжнийг будаарай. Босоо хуваарийн 1 нэгж хэдэн сурагчийн саналыг илэрхийлэх вэ?

в)-д байгаа диаграммыг ажиглаарай. Босоо хуваарийн тоо ямар утгатай вэ?

Будсан нэг дөрвөлжин хэдэн саналыг илэрхийлэх вэ?


- Сурагчдын саналын тоог дэвтэртээ гүйцээн зураарай.

- Будсан нийт дөрвөлжин санал өгсөн бүх сурагчийн тоотой тэнцүү юу?

- Худал хэлэхгүй байх саналын тоог дүрслэхдээ яагаад 3 нүд будсан бэ?

Багнанан диаграммыг дүрслэхэд анхаарах зүйлс:

- ① Диаграмм зурах зайг тооцоолно.
- ② Диаграммын гарчгийг бичнэ.
- ③ Давтамжийн тоог босоо (хэвтээ) тэнхлэгийн дагуу бичнэ.
- ④ Хэмжих нэгжийг бичнэ.
- ⑤ Юмсыг ангилсан нэрийг хэвтээ (босоо) тэнхлэгийн дагуу бичнэ.
- ⑥ Ангилал бүрээр давтамжийн тоог дүрсэлнэ.



**197** Зурган болон багнанан диаграммуудын ялгааны талаар ярилцаарай.

**198** Зурагт ямар амьтдыг дүрсэлсэн байна вэ?



а. Сурагчид таалагдаж байгаа нэг амьтныг сонгон, хүснэгтэд бүртгэжээ.

Амьтан	1	2	3	4	5	6	7	8	9
Бүртгэл									
Давтамж									

б. Давтамжийн тоог зурган, баганан диаграммаар дүрслэн харуулаарай.

в. Нийт хэдэн сурагч санал өгсөн бэ? Ямар амьтныг олонх нь сонгосон бэ?

г. Амьтан бүрд өгсөн сурагчдын саналын тоог эрэмбэлээрэй.

**199**



Та нарт дээрх амьтдын аль нь хамгийн их таалагдаж байна вэ?

а. Сурагч бүр 1-ийг сонгон, хүснэгтэд бүртгээрэй.

б. Давтамжийн тоог зурган, баганан диаграммаар дүрслээрэй.

в. Та нар өөр ямар амьтанд хайртай вэ? Яагаад? Амьтанд ээж, аав, үр зулзага байдаг болов уу?

г. Амьтдад ямар муу үйл хийж болохгүй вэ? Яагаад?

д. Амьтдыг яаж хамгаалах талаар ярилцаарай. Нэг амьтныг сонгоорой. Хүмүүс өөрт нь яаж хандаасай гэж хүсдэгийг төсөөлөн бичээрэй.

**200**

Отгоо сурагчдаас өгсөн үйлүүдийн ямар нь илүү сайн болохыг асууж бүртгэв.

Илүү сайн үйл

Үйл	Бүртгэл	Давтамж
Бусдад талархах		
Бусдад туслах		
Бусдыг хүндэтгэх		
Бусдыг уучлах		

Илүү сайн үйл



а. Давтамжийн тоог бичээрэй.

б. Баганан диаграммыг гүйцээгээрэй.

в. Ямар үйлд хамгийн олон ба цөөн сурагч санал өгсөн бэ?

г. Хүснэгтэд бичсэн үйлүүд яагаад сайн болохыг бичээрэй.



д. Отгоо: “Хүснэгтэд бичсэн ‘бусдад’, ‘бусдыг’ гэдэгт хүн, амьтан бүгд хамаарна.” гэв. Тэр яагаад тэгж хэлсэн бол? Та юу гэж боддог вэ?

**201** Сурагчид илүү дуртай нэг жимсний нэртэй саванд 1 савх хийжээ.

- Нэг сурагч 1 саванд 2 савх хийж болох уу? Яагаад?
- Нэг сурагч хоёр саванд савх хийж болох уу?
- Хүснэгтэд саналыг бүртгэн, тоог бичээрэй.
- Сурагчдын идэх дуртай жимсний давтамжаар зурган, баганан диаграмм зурж, тайлбарлаарай.
- Нийт хэдэн сурагч санал өгсөн бэ?
- Ямар жимсийг хамгийн олон сурагч сонгосон бэ?



**202** Нэгэн өрхийн хашаандаа тарьсан хүнсний ногооны заримыг зурагт үзүүлжээ.




- Өрхийн хураан авсан ногооны хэмжээг зурган диаграммаар харуулав. Зурган диаграммыг баганан диаграммаар илэрхийлээд, тайлбарлаарай.

Хураан авсан хүнсний ногооны хэмжээ

Лууван	● ● ● ●
Улаан лооль	● ● ● ● ● ●
Цэцэгт байцай	● ● ●
Хаш	● ●

Түлхүүр: ● нь 5 кг





- Та нарын зурсан диаграмм юугаараа ижил, эсвэл ялгаатай байна вэ? Ногоо тус бүрээс хэдэн килограммыг хураасан бэ? Хамгийн их, хамгийн бага хэмжээтэй ногоог бичээрэй. Зөрөөг олоорой. Нийт хэдэн килограмм ногоо хураасан бэ?
- Эдгээр хүнсний ногооны ашиг тусын талаар судалж бичээрэй.

**203**



Та нар аль хүнсний ногоог тарьж үзэхийг илүү хүсэж байна вэ?




- Сурагч бүр 1-ийг сонгоно. Салаа, багаар саналаа хүснэгтэд бүртгээрэй.
- Давтамжийг зурган, баганан диаграммаар дүрслээд, тайлбарлаарай.
- Ангийн нийт сурагчийн саналыг хэрхэн нэгтгэн харуулах вэ?
- Жимс, хүнсний ногоо хүний эрүүл мэндэд ямар ашиг тустай вэ?


204

Хүүхдүүд дахин хэрэглэж болох хаягдал зүйлсийг цуглуулж ангилав. Тэд цуглуулсан хаягдлыг жинлэж үзээд, хэмжээг хүснэгтэд бичжээ.

Цуглуулсан хаягдлын хэмжээ

Хаягдал	Цаас	Лааз	Хуванцар сав	Хагараагүй шилэн сав
Хэмжээ	24 кг	48 кг	36 кг	54 кг

- а. Нэг  нь 6 кг хаягдлыг илэрхийлэх зурган диаграмм зураарай.  
 б. Баганан диаграммыг дэвтэртээ гүйцээж зураарай.




- в. Ямар төрлийн хаягдлын хүндийн хэмжээ хамгийн их байна вэ? Хэмжээ (кг)  
 Шил, лааз нийлээд хэдэн килограмм болох вэ? Зөрөө нь хэд вэ?  
 Хүүхдүүд бүгд хэдэн килограмм хаягдал цуглуулсан бэ?  
 Өөр асуулт зохиож, бусад сурагчдаас асуугаарай.  
 г. Эдгээр хаягдлаар юу хийдэг бол? Өөр ямар хаягдлыг хэрэглэж болох вэ?  
 д. Хог хаягдал их байх нь байгаль орчин, эрүүл мэндэд ямар нөлөөтэй вэ?  
 е. Сарын турш ямар хог хаяснаа өдөр бүр бичээрэй. Сарын дараа бичсэн хаягдлаа ангилан бүртгээрэй. Хогоо багасгахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

205

Бид хэрэглээгээ яаж хэмнэх вэ? Сурагчдын хариултын давтамжийг диаграммд харуулав.

Хэрэглээг хэмнэх арга



- а. Диаграммаас юуг олж чадах вэ?  
 б.  нь 2 хариултыг илэрхийлэх зурган диаграмм зураарай.  
 в. Та цаасаа яаж хэмнэдэг вэ?  
 г. Зөвхөн хэрэгцээтэй зүйлс авах гэдгийг юу гэж ойлгох вэ?  
 д. Та өөрт байгаа ямар зүйлсээ дахин хэрэглэж болох вэ?  
 е. Хэрэглээг хэмнэх ашиг тус юу вэ?

**206** Дөрөвдүгээр сард цаг агаар ямар байсныг үзүүлжээ.

Дөрөвдүгээр сарын цаг агаарын мэдээ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24
25	26	27	28	29	30						


Тайлбар: нартай, үүлэрхэг,  
 бороотой, цастай.

а. Сарын хэдэн хоногт цаг агаар ямар байсныг хүснэгтэд бүртгээрэй.

Дөрөвдүгээр сарын цаг агаар

Төлөв	Бүртгэл	Давтамж
Нартай		
Цастай		
Бороотой		
Үүлэрхэг		


Дөрөвдүгээр сарын цаг агаар



Нартай  
Үүлэрхэг  
Бороотой  
Цастай

нь 3 хоног

Дөрөвдүгээр сарын цаг агаар



Нартай  
Үүлэрхэг  
Бороотой  
Цастай

- б. Зурган диаграммыг байгуулаарай. 3 хоногийг нэг -аар дүрслээрэй.
- в. Баганан диаграммыг гүйцээгээрэй.
- г. Диаграммыг тайлбарлаарай.

**207** Долоо хоногийн хугацаанд хэдэн цаг нартай байсныг диаграммаар дүрсэлжээ.

1 дэх долоо хоногт	
2 дахь долоо хоногт	
3 дахь долоо хоногт	
4 дэх долоо хоногт	
5 дахь долоо хоногт	
6 дахь долоо хоногт	

8 цаг нартай байсан.  
 4 цаг нартай байсан.







- а. Сурагч бүр 1-ээс 3 асуулт гаргаарай. Бусад сурагчаас асуугаарай.
- б. Өгүүлбэртэй бодлого зохион бодоорой.
- в. Баганан диаграмм зурж, тайлбарлаарай.

**208**






Долоо хоногийн цаг агаарын мэдээг ажиглан тэмдэглээрэй. Хэдэн өдөр ямар байсныг бүртгээд, диаграммаар дүрслээрэй.

- 209** Золоо, Азаа хоёр шоо орхих туршилт хийв. Шоо аль талсаар буусныг тэд хүснэгтэд зураасаар тэмдэглэжээ.

Буусан талс	 1 оноо	 2 оноо	 3 оноо	 4 оноо	 5 оноо	 6 оноо	Нийт
Золоо							
Азаа							


- а. Хүүхэд бүр хэдэн удаа шоо орхисон бэ? Яаж мэдсэн бэ?  
 б. Шоо аль талсаараа хамгийн олон удаа буусан байна вэ?  
 в. Хэн хэдэн оноо авсан бэ? Яаж олсон бэ?  
 г. Хүүхдүүдийн авсан оноог баганан диаграммаар харуулаарай.  
 д. Азаагийн шоо аль талсаар хэдэн удаа буусныг диаграммаар харуулаарай.
- 210** Хоёр сурагч ижил хэмжээтэй 6 шар, 5 улаан, 3 цэнхэр квадратууд хийжээ. Тэд уутнаас 1 квадратыг таамгаар авч буцаах туршилтыг зургаан удаа хийж, үр дүнг хүснэгтэд бүртгэв.

Сугалсан квадратын өнгө			
Сурагч 1			
Сурагч 2			

- а. Сурагч бүр квадрат сугалах туршилтыг хэдэн удаа хийсэн бэ?  
 б. Ямар өнгийн квадратыг хамгийн цөөн сугалсан бэ? Ямар учиртай бол?  
 в. Туршилтын үр дүнг баганан диаграммаар яаж дүрсэлж болох вэ? Зурж харуулаарай. Бусад сурагчийн диаграммтай харьцуулж ярилцаарай.
- 211** Сурагчид хайрцагт байгаа дүрсийг харалгүйгээр барьж нэрлэв.




Бүх дүрсийг зөв нэрлэхэд А сурагч 40 секунд, Б сурагч 48 секунд, В сурагч 32 секунд зарцуулжээ. Сурагчдын зарцуулсан хугацааг баганан диаграммаар харуулаарай. Өгүүлбэртэй бодлого зохион бодоорой.

- 212**  Бяцхан ном хийе. Номоо хийхэд танд дараах асуултууд тусална.
- Өгөгдөл, мэдээллээ яаж цуглуулах вэ?
  - Цуглуулсан өгөгдөл, мэдээллээ яаж ангилж бүртгэх вэ?
  - Зурган, баганан диаграммуудын юу нь ижил, юу нь ялгаатай вэ?
  - Зурган диаграммыг дүрслэхдээ юуг анхаарах хэрэгтэй вэ?
  - Баганан диаграммыг дүрслэхдээ юуг анхаарах хэрэгтэй вэ?
  - Зурган, баганан диаграммын талаар нэмж юу бичмээр байна вэ?



## АРВАН МЯНГА ДОТОР ТООГ ҮРЖҮҮЛЭХ, ХУВААХ

**Жишээ 1** Сургуулийн цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны тоог зургаар үзүүлэв. Сурагч бүр нийт модны тоог тооцоолжээ. Бодолтыг тайлбарлаарай.



Бодолт 1.  $21 + 35 = 56$  (нийт мод)

Бодолт 2.  $35 + 21 = 56$  (нийт мод)

$21 + 35 = 35 + 21$       Нэмэгдэхүүний байр солиход  
 + = +      нийлбэрийн утга өөрчлөгдөхгүй.

Бодолт 3.  $8 \times 7 = 56$  (нийт мод)

Бодолт 4.  $7 \times 8 = 56$  (нийт мод)

$8 \times 7 = 7 \times 8$       Үржигдэхүүний байр солиход  
 × = ×      үржвэрийн утга өөрчлөгдөхгүй.

Бодолт 5.  $(3 + 5) \times 7 = 56$  (нийт мод)

Бодолт 6.  $3 \times 7 + 5 \times 7 = 56$  (нийт мод)



Нийлбэрийг тоогоор үржүүлэхдээ нэмэгдэхүүн тус бүрийг уг тоогоор үржүүлээд, гарсан утгуудыг нэмнэ.

$(3 + 5) \times 7 = 3 \times 7 + 5 \times 7$   
 + × = × + ×   
 $(3 + 5) \times 7 = 7 \times (3 + 5)$

**213** Дээрх зургийг ажиглаад, хус нь улиаснаас хэдээр олон байгааг олоорой. Бодолтуудыг харьцуулан ярилцаарай.

Бодолт 1.  $(5 - 3) \times 7 = 14$  (зөрөө)

Бодолт 2.  $5 \times 7 - 3 \times 7 = 14$  (зөрөө)

$(5 - 3) \times 7 = 5 \times 7 - 3 \times 7$   
 - × = × - ×   
 $(5 - 3) \times 7 = 7 \times (5 - 3)$

Ялгаврыг тоогоор үржүүлэхдээ хасагдагч ба хасагчийг уг тоогоор үржүүлээд, гарсан утгуудыг хасна.



**214** Нийлбэрийг тоогоор үржүүлэх дүрмийг хэрэглэн тоог 12, 13, 14, 15 гэх мэт аль нэг тоогоор үржүүлэх хүрдийг зохиогоорой. Үлгэрлэвэл:

$$\begin{aligned}
 1 \times 11 &= 1 \times (10 + 1) = 1 \times 10 + 1 \times 1 = 10 + 1 = 11 \\
 2 \times 11 &= 2 \times (10 + 1) = 2 \times 10 + 2 \times 1 = 20 + 2 = 22 \\
 3 \times 11 &= 3 \times (10 + 1) = 3 \times 10 + 3 \times 1 = 30 + 3 = 33 \\
 4 \times 11 &= 4 \times (10 + 1) = 4 \times 10 + 4 \times 1 = 40 + 4 = 44 \\
 5 \times 11 &= 5 \times (10 + 1) = 5 \times 10 + 5 \times 1 = 50 + 5 = 55 \\
 6 \times 11 &= 6 \times (10 + 1) = 6 \times 10 + 6 \times 1 = 60 + 6 = 66 \\
 7 \times 11 &= 7 \times (10 + 1) = 7 \times 10 + 7 \times 1 = 70 + 7 = 77 \\
 8 \times 11 &= 8 \times (10 + 1) = 8 \times 10 + 8 \times 1 = 80 + 8 = 88 \\
 9 \times 11 &= 9 \times (10 + 1) = 9 \times 10 + 9 \times 1 = 90 + 9 = 99 \\
 10 \times 11 &= 10 \times (10 + 1) = 10 \times 10 + 10 \times 1 = 100 + 10 = 110
 \end{aligned}$$

$$\begin{aligned}
 1 \times 11 &= 11 \\
 2 \times 11 &= 22 \\
 3 \times 11 &= 33 \\
 4 \times 11 &= 44 \\
 5 \times 11 &= 55 \\
 6 \times 11 &= 66 \\
 7 \times 11 &= 77 \\
 8 \times 11 &= 88 \\
 9 \times 11 &= 99 \\
 10 \times 11 &= 110
 \end{aligned}$$



Яг энэ аргаар ямар ч тооны хүрдийг зохиож болох нь ээ.

**215** Номын сангийн нэг дэх тавиурт 342, хоёр дахь тавиурт 263, гурав дахь тавиурт 237 ном байв. Гурван тавиурт бүгд хэдэн ном байна вэ? Хэдэн аргаар бодож болох вэ?



$$\square + \triangle + \bullet = (\square + \triangle) + \bullet = \square + (\triangle + \bullet)$$

загвараар бодож болно.

**216**



Ангийн 11 сурагч аяллаар явав. Сурагч бүр 2 хайрцаг жигнэмэг авчээ. Хайрцаг тус бүрд 4 ширхэг жигнэмэг байсан бол нийт хэдэн ширхэг жигнэмэг авсан бэ? Дараах загварыг хэрэглэн бодоорой.

$$\square \times \triangle \times \bullet = (\square \times \triangle) \times \bullet = \square \times (\triangle \times \bullet)$$



**217** Үйлдлийн ямар чанар хэрэглэн бодоход хялбар байгааг ярилцаарай.

а.  $17 + 752$       б.  $5 \times 16$       в.  $(452 + 29) + 171$   
     $38 + 962$       г.  $8 \times 17$       д.  $(15 \times 5) \times 2$

**218** Зүй тогтлыг ажиглаад, үргэлжлүүлээрэй.

1	1 + 3	1 + 3 + 5	...	...
$1 \times 1$	$2 \times 2$	$3 \times 3$		

Товчлол: нэгж (н), аравт (а), зуут (з), мянгат (мян), арван мянгат (а.мян)

$$10 \text{ н} = 1 \text{ а} \quad 10 \text{ а} = 1 \text{ з} \quad 10 \text{ з} = 1 \text{ мян} \quad 10 \text{ мян} = 1 \text{ а.мян}$$

$$1 \text{ а} = 10 \text{ н} \quad 1 \text{ з} = 10 \text{ а} = 100 \text{ н} \quad 1 \text{ мян} = 10 \text{ з} = 100 \text{ а} = 1000 \text{ н}$$

**219** Орон ангийн хүснэгт хэрэглэн хийсэн үйлдлийг ажиглан, тайлбарлаарай.

а.

Мянгат	Зуут	Аравт	Нэгж
			1
		1	0
	1	0	0
1	0	0	0

$$10 \times 1 = 10 \text{ н} = 1 \text{ а} = 10$$

$$10 \times 100 = 10 \times 1 \text{ з} = 10 \text{ з} = 1 \text{ мян} = 1000$$

$$10 \times 10 \times 10 = 100 \times 10 = 1000$$

б.

Мянгат	Зуут	Аравт	Нэгж
1	0	0	0
	1	0	0
		1	0
			1

$$1000 \div 10 = 10 \text{ з} \div 10 = 1 \text{ з} = 100$$

$$1000 \div 100 = 100 \text{ а} \div 10 = 1 \text{ а} = 10$$


$$1000 \div 10 \div 10 = 1000 \div (10 \times 10) = 10$$



Тоог 10, 100-аар үржүүлэхэд тооны цифр бүр харгалзан 1, 2 орноор ахина. Харин 10, 100-д хуваахад тооны цифр бүр харгалзан 1, 2 орон буурна.


**Жишээ 2** Бодолтыг тайлбарлаарай. (Арвыг а, зууг з гэж тэмдэглэв.)

а. Арван төгрөгийн үнэтэй цааснаас тавыг авбал хэдийг төлөх вэ?



$$5 \times 10 = 5 \times 1 \text{ а} = 5 \text{ а} = 50 \text{ (төгрөг)}$$

б. Зуун төгрөгийн үнэтэй үзэгнээс дөрвийг авбал хэдийг төлөх вэ?



$$4 \times 100 = 4 \times 1 \text{ з} = 4 \text{ з} = 400 \text{ (төгрөг)}$$

**Жишээ 3** Бодолтыг ажиглаад, тайлбарлаарай.

а. Дугтуй бүрд арван ширхэг зуун төгрөг байв. Таван дугтуйд хэдэн төгрөг байгаа вэ?  $5 \times 10 \times 100 = 5 \times 1000 = 5000 \text{ (төгрөг)}$

б. 8000 төгрөгийг зуутаар задлан 10 хүүхдэд өгчээ. Нэг хүүхдэд зуутын хэдэн дэвсгэрт өгсөн бэ?

$$8000 \div 100 \div 10 = 8000 \div (100 \times 10) = 8000 \div 1000 = 8 \text{ (зуутын дэвсгэрт)}$$



Тоог 10-аар, бас 100-аар үржүүлбэл 1000-аар үржүүлсэнтэй адил юм байна. Тоог 10-д, бас 100-д хуваавал 1000-д хуваасантай адил юм байна.

**220** Үржвэрийн утгыг олоорой.

- |                    |                    |                    |                    |
|--------------------|--------------------|--------------------|--------------------|
| а. $2 \times 10$   | д. $60 \times 10$  | и. $10 \times 120$ | н. $100 \times 59$ |
| б. $20 \times 10$  | е. $600 \times 10$ | к. $100 \times 12$ | о. $10 \times 310$ |
| в. $20 \times 100$ | ж. $60 \times 100$ | л. $1000 \times 9$ | ё. $100 \times 75$ |
| г. $2 \times 1000$ | з. $6 \times 1000$ | м. $10 \times 730$ | п. $1000 \times 4$ |


**221** Ногдворын утгыг олоорой.

- |                     |                     |                     |                      |
|---------------------|---------------------|---------------------|----------------------|
| а. $20 \div 10$     | д. $60 \div 10$     | и. $2400 \div 10$   | н. $5900 \div 100$   |
| б. $200 \div 10$    | е. $600 \div 10$    | к. $2400 \div 100$  | о. $10000 \div 10$   |
| в. $200 \div 100$   | ж. $600 \div 100$   | л. $9000 \div 1000$ | ё. $10000 \div 100$  |
| г. $2000 \div 1000$ | з. $6000 \div 1000$ | м. $5900 \div 10$   | п. $10000 \div 1000$ |

**222** Үржүүлэхийн хүрдээ сэргээн санаад, бодоорой.

Үржигдэхүүн	8		9		3		4		9		5	7			6
Үржигдэхүүн		6	7	8		5	6	6		3	8		9	7	
Үржвэрийн утга	56	42		72	18	45		36	18	24		49	81	35	54

**223** Бодолтыг гүйцээж, тайлбарлаарай.



- а. 10 төгрөгийн үнэтэй цааснаас хоёрыг авбал хэдийг төлөх вэ?
- б. 30 төгрөгийн үнэтэй өнгийн цааснаас хоёрыг авбал хэдийг төлөх вэ?
- в. 300 төгрөгийн үнэтэй үзгээс хоёрыг авбал хэдийг төлөх вэ?
- г. 3000 төгрөгийн үнэтэй номоос хоёрыг авбал хэдийг төлөх вэ?

илэрхийлэл

$$2 \times 30 = 2 \times 3 \text{ а} = \dots \text{ а} = \dots$$

$$2 \times 300 = 2 \times 3 \text{ з} = \dots = \dots$$

$$2 \times 3000 = 2 \times 3 \text{ мян} = \dots = \dots$$

**Жишээ 4** Бодолтуудын ялгааг ажиглаад, тайлбарлаарай.

$$3 \times 20 = 3 \times 2 \text{ а} = 6 \text{ а} = 60$$

$$3 \times 200 = 3 \times 2 \text{ з} = 6 \text{ з} = 600$$

$$3 \times 2000 = 3 \times 2 \text{ мян} = 6 \text{ мян} = 6000$$

$$3 \times 20 = 3 \times 2 \times 10 = 6 \times 10 = 60$$

$$3 \times 200 = 3 \times 2 \times 100 = 6 \times 100 = 600$$

$$3 \times 2000 = 3 \times 2 \times 1000 = 6 \times 1000 = 6000$$

**224** Үржвэрийн утгыг олоорой.

- |                    |                   |                    |                   |
|--------------------|-------------------|--------------------|-------------------|
| а. $5 \times 10$   | г. $9 \times 7$   | ж. $30 \times 3$   | к. $7 \times 6$   |
| б. $100 \times 5$  | д. $90 \times 7$  | з. $300 \times 3$  | л. $7 \times 60$  |
| в. $1000 \times 5$ | е. $700 \times 9$ | и. $3000 \times 3$ | м. $600 \times 7$ |

**225** Бодолтыг гүйцээж, тайлбарлаарай.



(2 бохь)

60 ₮



(2 жигнэмэг)

600 ₮

а. 2 хүүхэд 60 төгрөгийн үнэтэй боодол бохины мөнгийг тэнцүү гаргах бол тус бүр хэдийг төлөх вэ?

илэрхийлэл

б. Тэд 600 төгрөгийн үнэтэй, хоёроор савласан жигнэмгээс 1-ийг авбал тус бүр хэдийг төлөх вэ?

илэрхийлэл

а.  $60 \div 2 = 6$  а  $\div 2 = \dots$  а = ... (төгрөг)

б.  $600 \div 2 = 6$  з  $\div 2 = \dots$  з = ... (төгрөг)

**Жишээ 5** Бодолтуудын ялгааг ажиглаад, тайлбарлаарай.

$80 \div 2 = 8$  а  $\div 2 = 4$  а = 40

$800 \div 2 = 8$  з  $\div 2 = 4$  з = 400





$8000 \div 2 = 8$  мян  $\div 2 = 4$  мян = 4000

$80 \div 2 = 8 \times 10 \div 2 = 8 \div 2 \times 10 = 40$

$800 \div 2 = 8 \times 100 \div 2 = 8 \div 2 \times 100 = 400$

$8000 \div 2 = 8 \times 1000 \div 2 = 4 \times 1000 = 4000$

**226** Ногдворын утгыг олоорой. Дүрсүүдийг нэрлээрэй.



**227** Ногдворын утгыг олоорой.

а.  $36 \div 9$

д.  $40 \div 5$

и.  $1800 \div 3$

н.  $720 \div 8$

б.  $360 \div 9$

е.  $400 \div 5$

к.  $2400 \div 3$

о.  $7200 \div 8$

в.  $3600 \div 9$

ж.  $4000 \div 5$

л.  $2700 \div 3$

ё.  $4200 \div 7$

г.  $7200 \div 9$


з.  $4500 \div 5$

м.  $6300 \div 7$

п.  $5400 \div 9$

**228** Сурагчийн цуглуулсан хаягдлын хэмжээг харуулав.

Шил	Лааз	Гялгар уут	Хуванцар сав
8 ширхэг	4 кг	2 кг	16 ширхэг



Эдгээрийг тушааж, хэдэн төгрөгтэй болсон бэ?

Тоо, хэмжээг өөрчлөн бодоорой.

**229** Үржигдэхүүн, хуваагдагчийг дээд орноор нь тоймлон, ойролцоо утгыг олно уу.

Жишээ:  $3 \times 2694 = ?$   $3 \times 3000 = 9000$ .

$4300 \div 5 = ?$   $4000 \div 5 = 800$

а.  $6 \times 850$

в.  $487 \div 5$

д.  $693 \times 9$

ж.  $1720 \div 4$



б.  $8 \times 199$

г.  $2999 \div 5$

е.  $2499 \times 3$

з.  $6250 \div 2$

**Жишээ 6** Ажиглаад, тайлбарлаарай.



$$3 \times 12 \begin{cases} \rightarrow 3 \times 10 \\ \rightarrow 3 \times 2 \end{cases} \rightarrow 3 \times 10 + 3 \times 2 = 30 + 6 = 36$$

$10 + 2$

$$3 \times 312 \begin{cases} \rightarrow 3 \times 300 \\ \rightarrow 3 \times 10 \\ \rightarrow 3 \times 2 \end{cases} \rightarrow ?$$

$$3 \times 12 = 3 \times (10 + 2) = 3 \times 10 + 3 \times 2 = 30 + 6 = 36 \quad 3 \times 312 = 3 \times (300 + 10 + 2) = \dots$$

×	1	2
		3

×	1	2
		3
+		6
	3	0
	3	6

→ 3 × 2  
→ 3 × 10



×	3	1	2
			3

×	3	1	2
			3
			6
+		3	0
	9	0	0
	9	3	6

→ 3 × 2  
→ 3 × 10  
→ 3 × 300



- 230**     $3 \times 13$      $4 \times 21$      $32 \times 2$      $233 \times 3$      $123 \times 2$      $1230 \times 2$   
 $3 \times 130$      $4 \times 210$      $320 \times 2$      $434 \times 2$      $123 \times 3$      $1132 \times 3$   
 $3 \times 213$      $4 \times 321$      $332 \times 2$      $313 \times 3$      $230 \times 3$      $1221 \times 4$

**Жишээ 7** Ажиглаад, тайлбарлаарай.

×	7	9
		6

×	7	9
		6
+		5 4
	4	2 0
	4	7 4

→ 6 × 9  
→ 6 × 70



×	4	7	9
			6

×	4	7	9
			6
			5 4
+		4	2 0
	2	4	0 0
	2	8	7 4

→ 6 × 9  
→ 6 × 70  
→ 6 × 400



$6 \times 479$  үржвэрийн утгыг хэрхэн олсныг тайлбарлаарай.

		5		
×	4	7	9	
			6	
			4	



	4	5		
×	4	7	9	
			6	
		7	4	



	4	5		
×	4	7	9	
			6	
	2	8	7	4

**231** Бодох аргын талаар эргэцүүлээрэй. Үйлдлийг гүйцэтгээрэй.

Жишээ:  $2 \times 130 = 2 \times 13 \times 10 = 26 \times 10 = 260$

- а.  $14 \times 5$     в.  $16 \times 6$     д.  $34 \times 4$     ж.  $3 \times 85$     и.  $9 \times 27$     л.  $25 \times 8$   
 б.  $140 \times 5$     г.  $160 \times 6$     е.  $340 \times 4$     з.  $3 \times 850$     к.  $3 \times 270$     м.  $250 \times 8$

**232** а.  $9 \times 74$     в.  $4 \times 69$     д.  $8 \times 75$     ж.  $46 \times 6$     и.  $7 \times 1038$     л.  $2 \times 3690$   
 б.  $528 \times 4$     г.  $192 \times 9$     е.  $317 \times 6$     з.  $6 \times 890$     к.  $1447 \times 4$     м.  $3 \times 1978$

**Жишээ 8** Бодолтыг тайлбарлаарай.

Diagram illustrating the distributive property of multiplication:

$$\begin{array}{r} \times \\ 209 \\ \hline 6 \end{array}$$

$$\begin{array}{r} \times \\ 209 \\ \hline 6 \\ + \\ 1200 \\ \hline 1254 \end{array}$$

→  $6 \times 9$   
 →  $6 \times 200$

**233** а.  $9 \times 309$     б.  $2 \times 506$     в.  $408 \times 7$     г.  $604 \times 5$     д.  $6 \times 1207$     е.  $3 \times 2902$

**234**



Тоог аравтаар үржүүлье.

1-ээс 9, 10-аас 90 хүртэлх тоо бүхий хоёр багц карт бэлтгэнэ.

- а. Гурав, гурваар баг болно: сонгогч, таагч, үйлдэл гүйцэтгэгч.  
 б. Сонгогч 1-ээс 9, 10-аас 90 хүртэлх тоотой хоёр багц картаас тус бүр 1-ийг сонгоно.  
 в. Үйлдэл гүйцэтгэгч сонгосон хоёр тоог үржүүлнэ.  
 г. Таагч хариуг цээжээр тооцоолон хэлэхэд, гишүүд шалгана.  
 д. Тоглогчид үүргээ сольж тоглоно.

**235** Боодолдоо 32 см урттай туузаас Бат 4 боодлыг, Туяа 6 боодлыг авав. Хүүхэд бүрийн авсан туузын нийт уртыг олоорой.

**236** Ихэр охид ижил зүйл цуглуулах дуртай байв. Нэг нь 26 тэмдэг, 49 зураг, 15 үзэг, 28 ном цуглуулжээ. Нөгөө нь мөн ижил тооны юмс цуглуулсан бол нийлээд хэдэн тэмдэг, зураг, үзэг, ном цуглуулсан бэ?

**237** 6 сурагчийн тус бүр 250 төгрөг нийлүүлж авсан жигнэмэг ямар үнэтэй вэ?

**238** Тоог 4 дахин багасгаад, 396-аар ихэсгэхэд 544 гарсан бол уг тоог олоорой.

**239**



Дөрөв ба нэг оронтой ямар тоонуудын үржвэрийн утга 6000-аас их, 6200-аас бага байх вэ? Хэдэн ялгаатай хувилбар олсон бэ?

240



27-оос бага бүх тэгш тооны нийлбэрийн утгыг хялбар олох ямар арга байгаа вэ?

241

379, 6, 259 гэсэн тоонуудаар бодлого зохиогоорой. Зохиосон бодлогоо ангийнхаа сурагчтай сольж бодоорой. Өөр ямар бодлого зохиож болох вэ?

Жишээ 9

Бодолтыг тайлбарлаарай.

а.  $28 \times 9 = 28 \times (10 - 1) = 28 \times 10 - 28 \times 1 = 280 - 28 = 252$

б.  $28 \times 11 = 28 \times (10 + 1) = 28 \times 10 + 28 \times 1 = 280 + 28 = 308$

в.  $317 \times 9 = 317 \times (10 - 1) = 317 \times 10 - 317 \times 1 = 3170 - 317 = 2853$

г.  $317 \times 11 = 317 \times (10 + 1) = 317 \times 10 + 317 \times 1 = 3170 + 317 = 3487$

242

Тооцоолоорой.

а.  $2 \times 90$       г.  $12 \times 100$       ж.  $350 \times 10$       к.  $7 \times 1000$       н.  $715 \times 10$       п.  $3 \times 9000$

б.  $28 \times 9$       д.  $128 \times 9$       з.  $35 \times 9$       л.  $86 \times 9$       о.  $715 \times 9$       р.  $493 \times 9$

в.  $28 \times 11$       е.  $128 \times 11$       и.  $65 \times 11$       м.  $94 \times 11$       ө.  $327 \times 11$       с.  $509 \times 11$

243

Бодоорой. а.  $900 \times 2 + 450$       в.  $597 \times 2 - 210$       д.  $808 \times 9 + 159 \times 11$   
 б.  $8 \times 120 - 519$       г.  $699 \times 3 + 3560$       е.  $818 \times 12 - 18 \times 12$

244

Баяраа 600 төгрөгийн үнэтэй 4 дэвтэр, 750 төгрөгийн үнэтэй 2 үзэг, 1250 төгрөгийн үнэтэй 1 зургийн дэвтэр худалдан авчээ.

Худалдагч  $4 \times 600 + 2 \times 750 + 1250$  гэж бичив. Нийт үнийг олоорой.

$4 \times 600$ ,  $2 \times 750$ , 1250 илэрхийлэл тус бүр юуг илэрхийлэх вэ?

245

Үржвэрийн утгыг цээжээр олоорой.

а.  $4 \times 100$       г.  $18 \times 100$       ж.  $200 \times 40$       к.  $72 \times 100$

б.  $45 \times 10$       д.  $672 \times 10$       з.  $30 \times 200$       л.  $340 \times 10$

в.  $270 \times 10$       е.  $410 \times 10$       и.  $28 \times 300$       м.  $50 \times 160$

246

Болд 1000 төгрөгөөр ижил дэвтрүүд худалдан авах болжээ. Дэлгүүрт 240, 300, 400 төгрөгийн үнэтэй дэвтрүүд байв. Болд аль дэвтрээс хэдийг худалдан авах боломжтой вэ?

247



Тоо зохиож, үржүүлэе.

Сурагч бүр 0-ээс 9 хүртэлх цифр бүхий картууд бэлтгэнэ.

- Цифрүүдээс сонгон нэг, хоёр, гурван оронтой тоонууд зохиогоорой.
- Найздаа тоонуудаа хэлж өгөөрэй.
- Найзынхаа хэлсэн хоёр, гурван оронтой тоог нэг оронтой тоогоор нь үржүүлээрэй.
- Дэвтрээ солилцон, зөв үржүүлсэн эсэхийг шалгаарай.



**Жишээ 10** 18 номыг 2 хүүхдэд тэнцүү тоогоор хуваарилан өгчээ. Хүүхэд бүр хэдэн ном авсан бэ? Хэдэн ном үлдсэн бэ?

$$18 \div 2 = 9$$

хуваагдагч    хуваагч    ногдворын утга

18 нь 2-т үлдэгдэлгүй хуваагдана.



Хүүхэд бүр 9 ном авсан бөгөөд ямар ч ном үлдээгүй.

**Жишээ 11** 19 номыг 2 хүүхдэд тэнцүү ногдохоор хуваарилан өгчээ. Хүүхэд бүр хэдэн ном авсан бэ? Хэдэн ном үлдсэн бэ?



2 хүүхдэд 9 ном өгвөл нийт 18 ном болно.  $18 < 19$

2 хүүхдэд 10 ном өгвөл  $2 \times 10 = 20$  ном хэрэгтэй.  $20 > 19$  тул 9-ийг сонгоё.

$$19 \div 2 = 9 \text{ (үлд 1)}$$

хуваагдагч    хуваагч    ногдворын утга    үлдэгдэл

Үлдэгдэл нь хуваагчаас үргэлж бага байна.

Хүүхэд бүрд 9 ном өгч, 1 ном үлджээ.

Шалгая. 2 хүүхдэд өгсөн ном:  $2 \times 9 = 18$  (ном)

Үлдсэн номоо нэмбэл:  $18 + 1 = 19$  (ном).

**Жишээ 12** 65 номыг 4 хүүхдэд тэнцүү ногдохоор хуваарилан өгвөл хүүхэд бүр хэдэн ном авах вэ? Хэдэн ном үлдэх вэ?

	6	5	4		
-	4		1	6	
	2	5			
-	2	4			
		1			

6 аравтыг 4-д хуваахад 1 аравт ногдож, 2 аравт үлдэнэ.

1-ийг ногдворын аравтын оронд бичнэ.

Үлдэгдэл 2 аравт нь 20 нэгж болно.

5 нэгжийг нэмбэл нийт 25 нэгж болно.

25 нэгжийг 4-д хуваахад 6 ногдож, 1 нэгж үлдэнэ.

6-г ногдворын утгын нэгжийн оронд бичнэ.

65-ыг 4-д хуваахад ногдвор 16, үлдэгдэл нь 1 гарна.

Шалгая:  $4 \times 16 + 1 = 65$ . Хариу: Хүүхэд бүр 16 ном авч, 1 ном үлдэнэ.

**248** 17 харандааг 3 хүүхдэд тэнцүү ногдохоор хуваарилан өгвөл хүүхэд бүр хэдэн харандаа авах вэ? Хэдэн харандаа үлдэх вэ?

**249** Үйлдлийг гүйцэтгээрэй.

а.  $18 \div 7$     в.  $24 \div 5$     д.  $30 \div 4$     ж.  $44 \div 8$     и.  $74 \div 3$     л.  $91 \div 5$

б.  $65 \div 7$     г.  $81 \div 6$     е.  $30 \div 9$     з.  $37 \div 3$     к.  $92 \div 8$     м.  $68 \div 4$

**250** Бодох аргын талаар эргэцүүлээд, тайлбарлаарай.

$$26 \div 2 = \square + \square =$$

$$\begin{array}{r} 20 + 6 \\ 20 \div 2 = \square \\ 6 \div 2 = \square \end{array}$$

$$56 \div 4 = \square + \square =$$

$$\begin{array}{r} 40 + 16 \\ 40 \div 4 = \square \\ 16 \div 4 = \square \end{array}$$

$$315 \div 5 = \square + \square =$$

$$\begin{array}{r} 300 + 15 \\ 300 \div 5 = \square \\ 15 \div 5 = \square \end{array}$$

**251** Тооцоолоорой.

- а.  $84 \div 2$       в.  $36 \div 3$       д.  $48 \div 4$       ж.  $96 \div 3$       и.  $78 \div 6$   
 б.  $840 \div 2 = 84 \text{ а} \div 2$       г.  $360 \div 3$       е.  $480 \div 4$       з.  $416 \div 4$       к.  $792 \div 6$

Зөв гүйцэтгэсэн эсэхээ яаж шалгах вэ? Бичиж үзүүлээрэй.

**Жишээ 13** Ажиглаад, хуваах аргын талаар эргэцүүлэн бодоорой.

а.  $68 \div 2 = ?$

б.  $78 \div 6 = ?$

	6	8	2	
-	6		3	4
		8		
		8		
		0		

	6	8	2	
-	6	0	3	0
		8		4
		8	3	4
		0		



	7	8	6	
-	6		1	3
		1	8	
		1	8	
		0		

	7	8	6		
-	6	0	1	0	
		1	8	3	
		1	8	1	3
		0			



$68 = 60 + 8$

6 аравтыг 2-т хуваахад 3 аравт буюу 30 ногдоно.

8 нэгжийг 2-т хуваахад 4 нэгж ногдоно.

Иймд 68 ба 2-ын ногдворын утга  $30 + 4 = 34$  болно.  $68 \div 2 = 34$

Шалгая:  $2 \times 34 = 68$

$78 = 70 + 8$

7 аравтыг 6-д хуваахад 1 аравт ногдож, 1 аравт үлдэнэ.

1 аравт = 10 нэгж, 10 нэгж + 8 нэгж = 18 нэгж, 18 нэгжийг 6-д хуваахад 3 нэгж ногдоно.

78 ба 6-ийн ногдворын утга  $10 + 3 = 13$  болно.

Шалгая:  $6 \times 13 = 78$

в.  $315 \div 5 = ?$

	3	1	5	5	
-	3	0		6	3
		1	5		
		1	5		
		0			

	3	1	5	5	
-	3	0	0	6	0
		1	5		3
		1	5	6	3
		0			



$315 = 300 + 10 + 5$ , аравт  $\rightarrow$  а, нэгж  $\rightarrow$  н

300-г 5-д хуваахад бүтэн зуут ногдохгүй.

$300 = 30 \text{ а}$ ,  $30 \text{ а} + 1 \text{ а} = 31 \text{ а}$ .

31 аравтыг 5-д хуваахад 6 аравт ногдож, 1 аравт үлдэнэ.

Үлдсэн 1 а = 10 н,  $10 \text{ н} + 5 \text{ н} = 15 \text{ н}$ .

15 нэгжийг 5-д хуваахад 3 нэгж ногдоно.

Иймд  $315 \div 5 = 63$ . Шалгая:  $5 \times 63 = 315$

**252** Тооцоолоорой.

- а.  $45 \div 3$       в.  $645 \div 3$       д.  $518 \div 2$       ж.  $644 \div 4$       и.  $3591 \div 7$       л.  $9288 \div 6$   
 б.  $138 \div 6$       г.  $404 \div 4$       е.  $765 \div 9$       з.  $812 \div 7$       к.  $1712 \div 8$       м.  $2577 \div 3$

**Жишээ 14** Бодолтыг тайлбарлаарай.

-	4	7	8	6	
	4	2		7	9
	-	5	8		
		5	4		
			4		

-	4	7	8		6	
	4	2	0		7	0
	-	5	8			9
		5	4		7	9
			4			



$$478 = 400 + 70 + 8$$

400-г 6-д хуваахад бүтэн зуут ногдохгүй.

$$400 = 40 \text{ а}, \quad 40 \text{ а} + 7 \text{ а} = 47 \text{ а.}$$

47 аравтыг 6-д хуваахад 7 аравт ногдож, 5 аравт үлдэнэ.

$$\text{Үлдсэн } 5 \text{ а} = 50 \text{ н}, \quad 50 \text{ н} + 8 \text{ н} = 58 \text{ н.}$$

58 нэгжийг 6-д хуваахад 9 нэгж ногдож, 4 нэгж үлдэнэ.

Иймд 478-ыг 6-д хуваахад 79 ногдож, 4 нэгж үлдэнэ. Шалгавал,  $6 \times 79 + 4 = 478$

**253** Бодоод, шалгаарай.

- а.  $324 \div 9$     в.  $592 \div 8$     д.  $726 \div 9$     ж.  $105 \div 3$     и.  $250 \div 7$     л.  $395 \div 4$   
б.  $608 \div 5$     г.  $493 \div 6$     е.  $288 \div 7$     з.  $519 \div 8$     к.  $312 \div 4$     м.  $902 \div 1$

Бодсон аргаа тайлбарлаарай.

**254** Орхисон тоог олоорой.

- а.  $7 \times \square = 602$     г.  $\square \times 4 = 504$     ж.  $632 = 8 \times \square$   
б.  $\square \div 2 = 627$     д.  $\square \div 8 = 24 \times 5 + 3$     з.  $143 = \square \div 5$   
в.  $3 \times \square + 25 = 73$     е.  $143 \times 6 + \square = 861$     и.  $9 \times \square + 276 = \square$

**255** Санасан тоог 2 дахин ихэсгэж, 341-ээр хорогдуулаад, ялгаврыг 3 дахин ихэсгэхэд 687 гарав. Санасан тоог олоорой.

**256** Хэд хэдэн аргаар бодоорой. Бодолтоо шалгаарай.

- а.  $42 \div 3$     г.  $76 \div 4$     ж.  $65 \div 5$     к.  $81 \div 9$     н.  $96 \div 4$     л.  $160 \div 8$   
б.  $420 \div 3$     д.  $760 \div 4$     з.  $650 \div 5$     л.  $810 \div 9$     о.  $960 \div 4$     р.  $184 \div 8$   
в.  $435 \div 3$     е.  $796 \div 4$     и.  $675 \div 5$     м.  $801 \div 9$     ө.  $952 \div 4$     с.  $144 \div 8$

**257** 42 алимьг 8-аар нь уутанд савлав. Хэдэн уутанд 8 алим хийсэн бэ? Бүх алимьг савлахад нийт хэдэн уут хэрэгтэй вэ?

**258** 274 кг будааг 5 кг-аар нь савлав. Хэдэн уутанд 5 кг будаа хийсэн бэ? Хэдэн килограмм будаа савлагдаагүй үлдсэн бэ? Нийт будааг савлахад хэдэн уут хэрэгтэй вэ?

**259**



Тоо зохиож, хуваах үйлдэл гүйцэтгэе.

Сурагч бүр 0-ээс 9 хүртэлх цифр бүхий картууд бэлтгэнэ.

- а. Цифрүүдээс сонгон нэг, хоёр, гурван оронтой тоо зохиогоорой.  
б. Найздаа тоонуудаа хэлж өгөөрэй.  
в. Найзынхаа хэлсэн хоёр, гурван оронтой тоог нэг оронтой тоонд нь хуваагаарай.  
г. Дэвтрээ солилцон, зөв хуваасан эсэхийг шалгаарай.

## БАТАТГАХ

- 260** Тооцоолоод, дүгнэлт гаргаарай.
- а. 43, 69, 84 тоонуудыг 10-аар, гарсан тоог дахин 10-аар үржүүлээрэй. Өгсөн тоо бүрийг 100-аар үржүүлээрэй.
- б. 2500, 8700, 1900 тоонуудыг 10-д, гарсан тоог дахин 10-д хуваагаарай. Өгсөн тоо бүрийг 100-д хуваагаарай.

- 261** Хүү ээж аавдаа зориулан бэлэг авахаар мөнгө цуглуулжээ. Тэр цуглуулсан мөнгөө тоолж хүснэгтэд бичив. Бодолтыг гүйцээн, ярилцаарай.

Ширхэг	Дэвсгэрт	Дүн
126	10 ₮	$126 \times 10 = \square$ ₮
15	100 ₮	$15 \times 100 = \square$ ₮
3	1000 ₮	$3 \times 1000 = \square$ ₮

$126 \times 1 \text{ а} = 126 \text{ а} \quad 15 \times 1 \text{ з} = 15 \text{ з}$

$126 \times 10 = \square \quad 15 \times 100 = \square$

$3 \times 1 \text{ мян} = 3 \text{ мян} \quad 3 \times 1000 = \square$

Хүү хэдэн төгрөг цуглуулсан бэ?

- 262** Тооцоолоорой.
- а. 100 аравтын, 40 зуутын, 5 мянгатын дэвсгэрт нийлээд хэд болох вэ?
- б. 250 аравтын, 35 зуутын, 4 мянгатын дэвсгэрт нийлээд хэд болох вэ?

- 263** Тооцоолоорой.
- а.  $287 + 598$     в.  $375 - 299$     д.  $899 - 270$     ж.  $3400 + 276 + 1600$
- б.  $250 \times 5 \times 4$     г.  $35 \times 7 \times 2$     е.  $320 \times 5 \div 4$     з.  $1580 \times 4 \div 5$     и.  $307 \times 9$

- 264** Жишээг ажиглаад, тооцоолоорой:  $375 \times 5 = 375 \times 10 \div 2 = 3750 \div 2 = 1875$ .
- а.  $683 \times 5$     б.  $5 \times 784$     в.  $932 \times 5$     г.  $903 \times 5$     д.  $683 \times 5$

- 265** Хүүхдүүд 4 өдөрт 56 чацарганын бут суулгажээ. Эхний өдөр 14, хоёр дахь өдөр эхнийхээс 2 дахин их бут суулгав. Гурав ба дөрөв дэх өдөр тэнцүү тооны бут суулгасан байж болох уу? Яагаад?

- 266** 140 ширхэг алимьг 3, 3-аар уутлав. Хэдэн уут алим болсон бэ? Уутлагдаагүй хэдэн ширхэг алим үлдсэн бэ?

- 267** Үржүүлэх үйлдлийг гүйцэтгээд, тайлбарлаарай.

$$\begin{array}{r} 7 \times 8 = \begin{array}{|c|c|} \hline \square & 56 \\ \hline \end{array} \\ 7 \times 10 = \begin{array}{|c|c|} \hline \square & 70 \\ \hline \end{array} \\ 7 \times 18 = \begin{array}{|c|c|} \hline 1 & 26 \\ \hline \end{array} \end{array}$$

$$\begin{array}{r} б. \quad 8 \times 9 = \begin{array}{|c|c|} \hline \square & \square \\ \hline \end{array} \\ 8 \times 20 = \begin{array}{|c|c|} \hline \square & \square \\ \hline \end{array} \\ 8 \times 29 = \begin{array}{|c|c|} \hline \square & \square \\ \hline \end{array} \end{array}$$

$$\begin{array}{r} в. \quad 332 \times 20 = \begin{array}{|c|c|c|c|} \hline 6 & 6 & 4 & 0 \\ \hline \end{array} \\ 332 \times 4 = \begin{array}{|c|c|c|c|} \hline 1 & 3 & 2 & 8 \\ \hline \end{array} \\ 332 \times 24 = \begin{array}{|c|c|c|c|} \hline \square & \square & \square & \square \\ \hline \end{array} \end{array}$$

- 268** Тооцоолоорой.
- а.  $23 \times 8$     г.  $41 \times 50$     ж.  $70 \times 54$     к.  $145 \times 30$     н.  $326 \times 20$
- б.  $62 \times 7$     д.  $67 \times 24$     з.  $36 \times 43$     л.  $145 \times 2$     о.  $326 \times 8$
- в.  $32 \times 90$     е.  $28 \times 54$     и.  $45 \times 38$     м.  $145 \times 32$     ө.  $326 \times 28$

## ТООН ИЛЭРХИЙЛЭЛ, ТООН ТЭНЦЭТГЭЛ, ТООН ТЭНЦЭТГЭЛ БИШ

269 Зургаан найз аяллаар явжээ.





Хүүхэд бүр 1 шүүс, 1 жүрж худалдан авав. Тэд нийт хэдэн төгрөг төлсөн бэ? Бодолтыг тайлбарлаарай.



1 лааз шүүс 900 төгрөг



1 ширхэг жүрж 50 төгрөг



Нэг хүүхдийн авсан шүүс болон жүржийн үнийг олоод, 6-аар үржүүлнэ.

$$6 \times (900 + 50) = 6 \times 950 = 5700$$

Нийт шүүсний үнэ болон нийт жүржийн үнийг тус тусад нь олоод нэмнэ.

$$6 \times 900 + 6 \times 50 = 5400 + 300 = 5700$$



$$6 \times (900 + 50) = 6 \times 900 + 6 \times 50$$

$$\bullet \times (\blacksquare + \blacktriangle) = \bullet \times \blacksquare + \bullet \times \blacktriangle$$

Тоо, үйлдлийн тэмдэг оролцсон бичиглэлийг **тоон илэрхийлэл** гэнэ. Тоон илэрхийллийг хаалт оролцуулан бичиж болно.

Тоон илэрхийллийг хамгийн сүүлд гүйцэтгэх үйлдлээр нь нэрлэдэг. Жишээ:  $34 - 5 \times 6 + 3$  нь нийлбэрийг олох илэрхийлэл юм.

Тоон илэрхийллийн үйлдлийг гүйцэтгээд гарах хариуг түүний утга гэдэг.

Тоон илэрхийллийн утгыг олох дараалал:

1. Хаалтан доторх үйлдлийг гүйцэтгэнэ.
2. Үржүүлэх, хуваах үйлдлийг аль эхэнд орсноос нь эхэлж гүйцэтгэнэ.
3. Нэмэх, хасах үйлдлийг аль эхэнд орсноос нь эхэлж гүйцэтгэнэ.

**270** Охин хүү хоёрын бодолтыг ажиглаад, тайлбарлаарай. в, г-д байгаа тоон илэрхийллийн утгыг олоорой.

**а**

$$34 - 5 \times 6 + 3 = 7$$

- 1)  $5 \times 6 = 30$
- 2)  $34 - 30 = 4$
- 3)  $4 + 3 = 7$



**б**

$$50 + 90 \div 2 - 65 = 30$$



$$50 + 90 \div 2 - 65 = 50 + 45 - 65 = 95 - 65 = 30$$

**в**

$$36 \div 4 - 2 \times 3 + 5 = ?$$

**г**

$$1200 \div (452 - 352) + 17 \times 5 = ?$$

Цаашид тоон илэрхийллийн үйлдлийн дарааллыг дараах байдлаар тэмдэглэж бодоорой.

$$1200 \div (452 - 352) + 17 \times 5 = ?$$

**271** Үйлдлийн дарааллыг тогтоож, илэрхийллийн утгыг олоорой.

а.  $40 \times 5 - 72 \div 3 + 15$

г.  $6 + 12 \times 5 - 72 \div 8$

б.  $54 - 3 \times 4 \div 6 + 9$

д.  $(92 - 54) \div 2 \times (40 - (5 + 8) - 7) \div 5$

в.  $54 + (41 - 5) \div 4 + 67 - 39$

е.  $118 - 32 \div 4 - (15 \times 6 \div 2 - (5 - 3) \times 7)$

**272** Бодлогуудыг тоон илэрхийлэл зохиож бодоорой.

а. Сурагч Самбуу 246 хуудастай ном уншиж дууссан. Энэ нь Туяагийн уншсан номоос 2 дахин цөөн хуудастай. Туяа хэдэн хуудастай ном уншсан бэ?

б. Сурагч Баяр сургууль хүртэл 848 алхам явдаг. Энэ нь сурагч Энхээгийн сургууль орох алхмын тооноос 2 дахин олон. Энхээ сургууль хүрэхдээ хэд алхдаг вэ? 2 алхмыг 1 метр гэвэл Баяр, Энхээ нар сургуулиас хэдэн метр зайтай амьдардаг вэ?

в. Тэгш өнцөгт хэлбэртэй газарт 56 модыг 7 эгнээнд тэнцүү тоогоор суулгав. Мод бүрийн хоорондох зай 1 м. Тэгш өнцөгт газрын хүрээний дагуух моднуудыг тойруулан барьсан хашааны уртыг олоорой. Яаж олсон бэ?

**273**



1) Үйлдлийн дарааллыг тогтоож, илэрхийллийн утгыг олоорой.


$$14 \times 3 + 51 \div 3 - 15 \qquad (170 - 25) \times 3 + 180 \div 20$$

2) Дүү 152 савхтай. Ах нь түүнээс 3 дахин олон савхтай.

Тэд нийт хэдэн савхтай вэ?


**274** Жинлүүрийн хоёр тавганд хэдэн дөрвөлжин байгааг бичээд, жишээрэй. Ачааг тэнцүүлэхийн тулд ямар үйлдэл хийх вэ? Яагаад?

а.




		3	<	6		
3	+	3	=	6		
		3	=	6	-	3

б.




в.








Тоон илэрхийллүүдийг = тэмдгээр холбоход **тоон тэнцэтгэл** үүснэ.  $5 = 2 + 3$  нь үнэн тоон тэнцэтгэл,  $5 - 2 = 2$  нь худал тоон тэнцэтгэл. Тоон илэрхийллүүдийг  $>$ ,  $<$  тэмдгээр холбоход **тоон тэнцэтгэл биш** үүснэ.  $5 > 1 + 3$  нь үнэн тоон тэнцэтгэл биш,  $4 - 2 < 2$  нь худал тоон тэнцэтгэл биш.

**275** Жинлүүрийн хоёр тавган дахь ачаа тэнцүү хэмжээтэй байв. Дараах үйлдэлд тохирох тэнцэтгэл бишийг бичээрэй.


а.



б.



в.



Ямар үйлдэл хийвэл жинлүүр тэнцвэртэй болох вэ? Бичээд, шалгаарай.

**276** Жинлүүрийн хоёр тавган дахь ачаа тэнцүү хэмжээтэй байв. Дараах тохиолдол бүрд тохирох тэнцэтгэл бишийг бичээрэй.



- а. Жинлүүрийн нэг талаас 3 ачаа авсан.
- б. Жинлүүрийн нэг тал дээр 3 ачаа нэмсэн.
- в. Жинлүүрийн нэг талын ачааг 2 дахин багасгасан.
- г. Жинлүүрийн нэг талын ачааг 2 дахин ихэсгэсэн.

Ямар үйлдэл хийвэл жинлүүр тэнцвэртэй болох вэ? Бичээд, шалгаарай.

**277** Аль тоог  $\triangle$ -ны оронд орлуулахад тэнцэтгэл биш үнэн байх вэ?

а.  $\triangle < 10$

6	8	10	12
---	---	----	----

б.  $\triangle + 6 > 10$

2	3	4	5
---	---	---	---

в.  $\triangle \times 4 > 20$

8	7	6	5
---	---	---	---

г.  $3 \times \triangle < 15$

2	3	4	5
---	---	---	---

Үнэн тоон тэнцэтгэл болгохын тулд ямар үйлдэл гүйцэтгэх вэ?

**278** Эхний жишээг ажиглаарай.  $\square$ -ны оронд байх тоог олоорой. Яаж олсон бэ?

а.  $\square + 4 = 9$

$\square + 4 - 4 = 9 - 4$

$\square = 5$

б.  $\square - 6 = 10$

в.  $\square \times 5 = 35$

г.  $42 \div \square = 6$

## ҮЙЛДЛИЙН ГИШҮҮДИЙН ХАМААРАЛ

**279** Үйлдлийн гишүүнийг өөрчлөхөд дүн хэрхэн өөрчлөгдөж байгааг ярилцаарай.

$$\begin{array}{l} 70 + 20 = 90 \\ \downarrow +8 \\ 78 + 20 = 98 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} +8$$

Нэг нэмэгдэхүүнийг хэвээр авч, нөгөө нэмэгдэхүүнийг хэчнээн нэгжээр ихэсгэхэд (**багасгахад**) нийлбэрийн утга төчнөөн нэгжээр ихэснэ (**багасна**).



$$\begin{array}{l} 70 - 20 = 50 \\ \downarrow +8 \\ 78 - 20 = 58 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} +8$$

Хасагчийг хэвээр авч, хасагдагчийг хэчнээн нэгжээр ихэсгэхэд (**багасгахад**) ялгаврын утга төчнөөн нэгжээр ихэснэ (**багасна**).



$$\begin{array}{l} 70 - 20 = 50 \\ \downarrow +8 \\ 70 - 28 = 42 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} +8$$

Хасагдагчийг хэвээр авч, хасагчийг хэчнээн нэгжээр ихэсгэхэд (**багасгахад**) ялгаврын утга төчнөөн нэгжээр багасна (**ихэснэ**).



**280** Үйлдлийн гишүүнийг өөрчлөхөд дүн хэрхэн өөрчлөгдөж байгааг ярилцаарай.

$$\begin{array}{l} 3 \times 4 = 12 \\ \downarrow \times 2 \\ 6 \times 4 = 24 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} \times 2$$

Нэг үржигдэхүүнийг хэвээр авч, нөгөө үржигдэхүүнийг хэд дахин ихэсгэхэд (**багасгахад**) үржвэрийн утга төчнөөн дахин ихэснэ (**багасна**).



$$\begin{array}{l} 24 \div 6 = 4 \\ \downarrow \times 2 \\ 48 \div 6 = 8 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} \times 2$$

Хуваагчийг хэвээр авч, хуваагдагчийг хэд дахин ихэсгэхэд (**багасгахад**) ногдворын утга төчнөөн дахин ихэснэ (**багасна**).



$$\begin{array}{l} 24 \div 6 = 4 \\ \downarrow \div 2 \\ 24 \div 3 = 8 \end{array} \left. \begin{array}{l} \\ \\ \end{array} \right\} \div 2$$

Хуваагдагчийг хэвээр авч, хуваагчийг хэд дахин ихэсгэхэд (**багасгахад**) ногдворын утга төчнөөн дахин багасна (**ихэснэ**).



**281** Үйлдлийн гишүүнийг өөрчлөхөд дүн хэрхэн өөрчлөгдөхийг олж, ярилцаарай.

а.  $74 + 26 = \square$   
 $\downarrow +4$   
 $74 + \square = \square$  ?

в.  $240 - 120 = 120$   
 $\downarrow +20$   
 $\square - 120 = \square$  ?

д.  $4 \times 9 = 36$   
 $\downarrow \times 2$   
 $\square \times 9 = \square$  ?

б.  $74 + 26 = 96$   
 $\downarrow +4$     $\downarrow -4$   
 $78 + \square = \square$  ?

г.  $240 - 120 = 120$   
 $\downarrow -20$   
 $240 - \square = \square$  ?

е.  $36 \div 4 = 9$   
 $\downarrow \div 3$   
 $\square \div 4 = \square$  ?

**282** Хүснэгтэд өгсөн барааны тоо, хэмжээг хэрэглэн бодлого зохиож бодоорой.

Барааны нэр	Тоо ширхэг	Нийт үнэ (₮)
Өнгийн харандаа	3	2400
	$3 \times 3$	?
Үзэг	4	2600
	$4 \div 2$	?



**283** Тоог гүйцээгээрэй. Ажиглаад, дүгнэлт зөв эсэхийг шалгаарай.

а.

Хасагдагч	9	→	10	→	12	→	6	→	11
Хасагч	4	→		→		→		→	
Ялгаврын утга	5		5		5		5		5

Хасагдагч ба хасагчийг ижил тоогоор “нэмэгдүүлбэл” (хорогдуулбал) ялгаврын утга өөрчлөгдөхгүй.

б.

Хуваагдагч	3	→	6	→	12	→	18	→	9
Хуваагч	1	→		→		→		→	
Ногдворын утга	3		3		3		3		3

Хуваагдагч ба хуваагчийг “ижил тоогоор үржүүлэхэд” (ижил тоонд хуваахад) ногдворын утга өөрчлөгдөхгүй.

**284** Дээрх дүгнэлтийг хэрэглэн бодоорой.

а.  $100 - 57 = 99 - \square = \square$

г.  $48 \div 12 = \square \div 6 = \square$

б.  $100 - 57 = 103 - \square = \square$

д.  $64 \div 16 = \square \div 8 = \square$

в.  $98 + 46 = 100 + \square = \square$

е.  $18 \times 5 = \square \times 10 = \square$

**285** Нэгжид ногдох тоо, хэмжээг олохгүйгээр бодоорой.

а. 4 модон сойзоор жилд 16 хуванцар сойзыг орлуулж болно. 16, 24, 32 модон сойзоор жилд тус бүр хэдэн хуванцар сойзыг орлуулах вэ?



б. 3 хүүхэд усны савтай байвал жилд 501 усны хуванцар сав хэрэглэхгүй. 15, 30 хүүхэд усны савтай байвал жилд хэдэн хуванцар сав хэрэглэхгүй вэ?



в. 12 хүн даавуун тор хэрэглэвэл жилд 2040 гялгар тор хог болж хаягдахгүй. 6, 24, 36, 48 хүн даавуун тор хэрэглэвэл жилд хэдэн гялгар тор хаяхгүй вэ?



г. 20 хүн өөрийн аягаа авч явж хэрэглэдэг болсноор жилд 10000 нэг удаагийн цаасан аяга хэмнэнэ. 10, 15 хүн жилд тус бүр хэдэн цаасан аяга хэмнэх вэ?



д. Олон удаа хэрэглэдэг 9 соруулаар жилд 4860 нэг удаагийн хуванцар соруулыг орлуулна. Олон удаагийн 6, 18 соруулаар жилд хэдэн хуванцар соруул орлуулах вэ?



е. Бодлогууд юуны тухай болохыг эргэцүүлээрэй. Яагаад хуванцар сав, гялгар тор, нэг удаагийн цаасан аяга хэрэглэхгүй байх хэрэгтэйг ярилцаарай.

**286**



1) Хялбар аргаар бодоорой.

а.  $496 + 1428$

б.  $89 \times 5$



в.  $216 \div 8$

2) Нэгжид ногдох тоо, хэмжээг олохгүйгээр бодоорой.

а. 4 дэвтрийг 4800 төгрөгөөр авсан бол 8 дэвтрийг хэдэн төгрөгөөр авах вэ? 2 дэвтрийг хэдэн төгрөгөөр авах вэ?

б. Хайрцаг бүрд тэнцүү тооны савх хийжээ. 6 хайрцагт 96 савх хийсэн бол 2 хайрцагт хэдэн савх хийсэн бэ?

## УРТЫГ ХЭМЖИХ



Уртыг хэмжих нь ямар хэрэгтэй вэ? Зургийг ажиглан ярилцаарай.

- 287** Ширээний уртыг төөлөөрэй. Хэдэн төө байна вэ?  
Харандаагаар ширээний уртыг хэмжихэд төөлсөнтэй адил тоо гарах уу?  
Аль нь ширээний урт болох вэ? Яагаад?


Сонгосон нэгжээс хамаарч уртын хэмжээ өөр байна. Иймд хэмжээг бичихдээ тооны ард хэмжсэн нэгжээ бичдэг. Жишээ: 4 харандаа, 5 төө.





- 288** Уртыг хэмжихэд хэрэглэдэг багаж хэрэгслийн талаар чи юу мэдэх вэ?




- 289** Хэрчмүүдийн аль нь 1 см, 1 мм, 1 дм урттай вэ?  
Их нэгжийг багаар нь илэрхийлж бичээрэй.




- 290** Хэрчмийн уртыг хэмжихдээ шугамаа яаж байрлуулах нь зөв бэ?



- 291** Уртыг сантиметр, миллиметрээр илэрхийлэн бичээрэй.



Хадаас 3 см ..... мм урттай.



Харандаа .....см .....мм урттай.

**292** Хэрчмийн уртыг хэмжиж, хэмжээг сантиметр, миллиметр гэсэн нэгжүүдээр илэрхийлэн бичээрэй.




Бүх хэрчим нийлээд ямар урттай болохыг олоорой.

**293** 2 см, 1 см 3 мм, 1 см 7 мм, 3 см 5 мм, 1 дм урттай хэрчмүүдийг зураарай.


**Хуваарьтай шугам хэрэглэн хэрчим зурах**

0 хуваариас эхлэн хэрчмийг зурахаар шугамаа дэвтэр дээр байрлуулна.

Хэрчмийн эхлэл, төгсгөлийн цэгийг тэмдэглэнэ. Шугам хэрэглэн цэгүүдээ холбож хэрчим зурна. Хэмжээг бичнэ.



Хэмжих хэрэгслийн хэмжээнд харгалзах зураас бүр хуваарь юм.



**294** Цаасаар тус бүр 1 см, 1 дм, 1 м урттай гурван тууз хийгээрэй. Уртыг харьцуулаарай. Уртыг хэмжих их нэгжийг багаар нь илэрхийлээрэй.

**295** Хийсэн цаасан тууз, эсвэл хэмжих хэрэгсэл хэрэглэн 1 м нь хэр зэрэг урттай болохыг хараарай.

1 м урттай 10 туузыг уртаар нь залгаж тавьсан гэж төсөөлөөрэй. 10 м нь хэр зэрэг урт вэ? Ангийн урт 10 м хүрэх үү?

100 м нь хэр зэрэг урт вэ? 1000 м нь хэр зэрэг урт вэ? Төсөөлж байна уу?

**Уртын нэгжүүд:**

километр (км),  
метр (м),  
дециметр (дм),  
сантиметр (см),  
миллиметр (мм)

**Уртын нэгжүүдийн хоорондын хамаарал:**

1 км = 1000 м  
1 м = 10 дм = 100 см  
1 дм = 10 см = 100 мм  
1 см = 10 мм

Уртыг хэмжих үндсэн нэгж нь метр.




**296** Зурагт дүрсэлсэн юмсын уртыг ямар нэгжээр хэмжих нь тохиромжтой вэ?



**297** Зурагт сумаар заасан тоо, хэмжээг дэвтэртээ бичээрэй.

а. Тоог бичээрэй.

б. Хэмжээг см, мм-ээр илэрхийлээрэй.



**Жишээ 1** Хэмжих нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлснийг тайлбарлаарай.

- а.  $4 \text{ см} = (4 \times 10) \text{ мм} = 40 \text{ мм}$       г.  $70 \text{ дм} = (70 \div 10) \text{ м} = 7 \text{ м}$   
 б.  $15 \text{ м} = (15 \times 100) \text{ см} = 1500 \text{ см}$       д.  $600 \text{ см} = (600 \div 100) \text{ м} = 6 \text{ м}$   
 в.  $3 \text{ км} = (3 \times 1000) \text{ м} = 3000 \text{ м}$       е.  $10000 \text{ м} = (10000 \div 1000) \text{ км} = 10 \text{ км}$

**298** Тохирох тоог олж бичээрэй.

- а.  $8 \text{ м} = \square \text{ дм}$     в.  $5 \text{ дм} = \square \text{ мм}$     д.  $1400 \text{ см} = \square \text{ м}$     ж.  $900 \text{ см} = \square \text{ м}$   
 б.  $4 \text{ м} = \square \text{ мм}$     г.  $2000 \text{ м} = \square \text{ км}$     е.  $240 \text{ дм} = \square \text{ м}$     з.  $30 \text{ м} = \square \text{ см}$

**Жишээ 2** Хэмжих нэгжийг хэрхэн шилжүүлснийг тайлбарлаарай.

- а.  $5 \text{ км } 230 \text{ м} = 5 \text{ км} + 230 \text{ м} = (5 \times 1000) \text{ м} + 230 \text{ м} = 5230 \text{ м}$   
 б.  $2470 \text{ м} = 2000 \text{ м} + 470 \text{ м} = (2000 \div 1000) \text{ км} + 470 \text{ м} = 2 \text{ км } 470 \text{ м}$

**299** Өгсөн нэгжээр илэрхийлж бичээрэй.

- а.  $8 \text{ дм } 9 \text{ см} = \square \text{ см}$     в.  $74 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$     д.  $38 \text{ мм} = \square \text{ см } \square \text{ мм}$   
 б.  $1 \text{ м } 6 \text{ см} = \square \text{ см}$     г.  $1 \text{ км } 50 \text{ м} = \square \text{ м}$     е.  $1738 \text{ м} = \square \text{ км } \square \text{ м}$

**300** Жишээрэй.

- а.  $7 \text{ дм } 1 \text{ см} \square 7 \text{ дм } 9 \text{ мм}$     в.  $8 \text{ м } 5 \text{ дм} \square 8 \text{ м } 49 \text{ см}$     д.  $2 \text{ м} \square 20 \text{ дм}$   
 б.  $125 \text{ см} \square 1 \text{ м } 2 \text{ дм}$     г.  $3 \text{ км } 7 \text{ м} \square 3 \text{ км } 70 \text{ дм}$     е.  $4 \text{ дм} \square 41 \text{ см}$

**301** Хэмжээг тоймлоод бичээрэй.

- а. Сантиметрээр:  $5 \text{ см } 8 \text{ мм}$ ,  $7 \text{ см } 4 \text{ мм}$ ,  $3 \text{ см } 5 \text{ мм}$ ,  $18 \text{ см } 7 \text{ мм}$ ,  $65 \text{ мм}$   
 б. Метрээр:  $3 \text{ м } 5 \text{ дм}$ ,  $2 \text{ м } 80 \text{ см}$ ,  $1 \text{ м } 39 \text{ см}$ ,  $1 \text{ м } 9 \text{ см}$ ,  $71 \text{ дм}$ ,  $460 \text{ см}$   
 в. Километрээр:  $7 \text{ км } 350 \text{ м}$ ,  $4 \text{ км } 760 \text{ м}$ ,  $1 \text{ км } 1 \text{ дм}$ ,  $1862 \text{ м}$ ,  $2460 \text{ м}$

**Жишээ 3** Бодолтыг тайлбарлаарай.

$$296 \text{ м} \div 8 = 37 \text{ м}$$

$\begin{array}{r} + 415 \\ + 227 \\ \hline 642 \end{array}$	$\begin{array}{r} + 4 \text{ м } 15 \text{ см} \\ + 2 \text{ м } 27 \text{ см} \\ \hline 6 \text{ м } 42 \text{ см} \end{array}$	$\begin{array}{r} - 415 \\ - 227 \\ \hline 188 \end{array}$	$\begin{array}{r} - 4 \text{ м } 15 \text{ см} \\ - 2 \text{ м } 27 \text{ см} \\ \hline 1 \text{ м } 88 \text{ см} \end{array}$	$\times \begin{array}{r} 974 \\ \times \quad 6 \\ \hline 5844 \end{array}$	$\times \begin{array}{r} 974 \text{ м} \\ \times \quad 6 \\ \hline 5844 \text{ м} \end{array}$
---	--	---	--	--	--

2	9	6	8	
2	4		3	7
	5	6		
	5	6		
		0		

**302** Бодоод, тайлбарлаарай.

- а.  $593 \text{ см} + 204 \text{ см}$       д.  $13 \text{ м } 90 \text{ см} + 59 \text{ м } 34 \text{ см}$       и.  $2 \text{ км } 300 \text{ м} \times 4$   
б.  $4907 \text{ м} - 3495 \text{ м}$       е.  $5 \text{ км } 785 \text{ м} + 2 \text{ км } 127 \text{ м}$       к.  $17 \text{ см } 9 \text{ мм} \times 9$   
в.  $204 \text{ см} + 99 \text{ см}$       ж.  $50 \text{ м } 37 \text{ см} - 29 \text{ м } 45 \text{ см}$       л.  $4 \text{ м } 50 \text{ см} \div 9$   
г.  $320 \text{ км} - 168 \text{ км}$       з.  $8 \text{ дм } 5 \text{ см} - 39 \text{ см}$       м.  $1 \text{ км } 827 \text{ м} \div 7$

**303** Хэмжээг буурах эрэмбээр бичээрэй.

- а. 1000 м, 1 км 3 м, 1200 м,      в. 1 м 76 см, 18 дм, 177 см  
б. 2200 мм, 225 см, 23 дм, 2 м      г. 40 дм, 4 м 3 см, 401 см


**304** Юмсын уртыг таамаглан бичиж, хэмжиж шалгаарай.

- а. Хичээлийн хэрэгсэл, савх зэргийн уртыг таамаглан, хэмжиж шалгаарай.  
б. Гэрийн эд зүйлсийн урт, өргөн, өндрийг таамаглан, хэмжиж шалгаарай.

**305** Тахир шугамын уртыг хэмжээрэй. Хэмжээг сантиметр, миллиметрээр илэрхийлэн бичээрэй.



**306** Талын уртыг хэмжээд, дүрсийн хүрээний уртыг олоорой.



Дүрсийн хүрээний уртын хэмжээг периметр гэж нэрлэдэг.



## СОРИХ

**307** Хэрчмийн уртыг сантиметр, миллиметрээр илэрхийлэн бичээрэй.



**308** 3 см, 1 см 5 мм, 2 см 7 мм, 1 см 8 мм, 1 дм 1 см урттай хэрчмүүд зураарай.

**309** Гүйцээж бичээрэй.

- а.  $6 \text{ дм } 7 \text{ см} = \square \text{ см}$       б.  $95 \text{ см} = \square \text{ дм } \square \text{ см}$       в.  $48 \text{ мм} = \square \text{ см } \square \text{ мм}$

**310** Хэмжээг их нэгжээр нь тоймлон бичээрэй.


- а. 9 см 5 мм      б. 6 м 34 см      в. 7 дм 9 см      г. 5 км 42 дм

**311** Багаас их уруу эрэмбэлээрэй: 1 м 57 см, 6 дм 8 см, 65 см, 8 см 9 мм.

**312** Сурагч нэг хайрцгийг 1 м 59 см, хоёр дахь хайрцгийг 143 см урт туузаар ороов. 2 туузын уртын зөрөөг олоорой. Хоёр туузын нийт уртыг олоорой.

## БАТАТГАХ

**313** Ургамал бүрийн өндрийн хэмжээг бичээрэй.



Хамгийн өндөр ургамлын хэмжээг метр, сантиметрээр илэрхийлээрэй.  
Хамгийн өндөр нь бусдаасаа хэдээр илүү байна вэ?

**314** Туяа 124 см, Бат 1 м 27 см, Билгүүн 1 м 19 см өндөртэй.

а. Өндрийн хэмжээг ихээс бага уруу эрэмбэлээрэй.

Туузан метр дээр хэмжээг олж заагаарай.

б. Сурагчдын өндрийн зөрөөг олоорой.

**315** Нэгэн сурагч “Хүний алд ба өндрийн хэмжээ ойролцоо.” гэв.

Та юу гэж бодож байна вэ? Шалгаад, тайлбарлаарай.

**316** Улаанбаатар хот, 4 аймаг хоорондын зайг хүснэгтэд үзүүлжээ.

Улаанбаатар	Хот, аймаг хоорондын зай (километрээр)			
477	Архангай	Увс	Сүхбаатар	
1417	940	1982	886	Сэлэнгэ
565	1042	1361		
321	617			

а. Архангай нь Сүхбаатар аймгаас 1042 км зайд оршино.

Үүнийг хүснэгтээс яаж олж байгааг тайлбарлаарай.


б. Улаанбаатар хот Сүхбаатар аймгаас ямар зайд орших вэ?

в. Жуулчид Улаанбаатар хотоос Увс аймаг, Увсаас Архангай уруу аялж,


тэндээс Улаанбаатар хотод ирэв. Тэдний туулсан замын уртыг олоорой.

г. Хүснэгтийг хэрэглэн бодлого зохиож бодоорой.

**317** Дүрсийн талуудын уртыг хэмжээрэй. Дүрсийн периметрийг олоорой.




## ТАЛБАЙГ ХЭМЖИХ



Цэцэрлэгт хүрээлэнгийн ажилтнууд хэсэг газрыг квадрат хэлбэртэй хавтангаар бүрээд, газрыг тойруулан хайс барихаар шийджээ.

Хэдэн хавтан хэрэгтэйг яаж мэдэх вэ? Уг газрыг тойруулан ямар урттай хайс барих хэрэгтэй вэ?

**318** Хүүхдүүд квадратыг өрж янз бүрийн дүрс бүтээжээ.



Дүрс бүр хэдэн квадратаас тогтож байна вэ? Тоог гүйцээж бичээрэй.

Дүрс	А	Б	В	Г	Д	Е
Квадратын тоо	6					

Битүү хавтгай дүрсэд багтах нэгж талтай квадратын тоо нь уг дүрсийн талбайн хэмжээ болно.

Жишээ нь, А дүрсийн талбайн хэмжээ нь 6 юм.

**319** Ижил хэмжээтэй квадрат дүрсүүдээс бүтсэн зохиомж зураарай. Зохиомжийнхоо талбайн хэмжээг олоорой.



**320** Тэгш өнцөгтийн талбайн хэмжээг олъё.

а. Зурагт үзүүлсэн дүрсүүдийг өгсөн тоо, хэмжээгээр цаасан дээр зураарай. Зурсан дүрсүүдээ хайчлан бэлтгээрэй.

б. Тэгш өнцөгт хэдэн том квадратаас тогтох вэ?

в. Тэгш өнцөгт хэдэн жижиг квадратаас тогтох вэ?

г. Олсон тоонуудын аль нь тэгш өнцөгтийн талбайн хэмжээ болох вэ? Яагаад?




8 ширхэг




Хэмжилт хийж байгаа нэгж квадратын хэмжээнээс хамаарч дүрсийн талбайн хэмжээ өөр гарч болно. Иймд тоон утгын ард талбайг хэмжсэн нэгжийг заавал бичдэг.

Хүмүүс талбайг хэмжихдээ тодорхой нэгжүүдийг хэрэглэдэг.



1 см талтай квадратаар дүрсийн талбайг хэмжиж болно. Ийм нэгжийг **1 см.кв** гэж тэмдэглээд, **“1 сантиметр квадрат”** гэж уншина.




**Жишээ 1** Дүрсийн талбайн хэмжээ, периметрийг олъё.




Дүрсийн талбай олъё. Дүрс 1 см талтай 5 квадратаас тогтох тул талбай нь 5 см.кв болно.

Дүрсийн хүрээний уртыг (периметр) олъё. Дүрс 6 талтай. Эдгээр талын уртын нийлбэрийг олъё.  $2\text{ см} + 2\text{ см} + 1\text{ см} + 1\text{ см} + 1\text{ см} + 3\text{ см} = 10\text{ см}$

**321** Дүрсийн талбайн хэмжээ, периметрийг олоорой.



**322** Хоёр сурагч тэгш өнцөгтийн периметр, талбайн хэмжээг олох санааг гаргажээ. Тэдний бодолтыг гүйцээж, бодсон аргын талаар ярилцаарай.



Сурагч 1.

Периметрийг олъё.  $\square\text{ см} + \square\text{ см} + \square\text{ см} + \square\text{ см} = \square\text{ см}$

Тоолж үзвэл тэгш өнцөгт  $\square$  ширхэг 1 сантиметр квадратаас тогтож байна.

Иймд талбайн хэмжээ:  $\square\text{ см.кв}$ .

Сурагч 2.




Тэгш өнцөгтийн урт  $\square\text{ см}$ , өргөн  $\square\text{ см}$ . Зэрэгцээ талууд тэнцүү урттай.

Периметрийг олъё.  $2 \times \square\text{ см} + 2 \times \square\text{ см} = 2 \times (\square + \square)\text{ см} = \square\text{ см}$

Тэгш өнцөгт  $\square \times \square = \square$  квадратаас тогтох тул талбайн хэмжээ  $\square\text{ см.кв}$ .




**323** Дүрсийн талуудын уртыг хэмжээд, сантиметрээр тоймлоорой. Тоймлосон хэмжээг хэрэглэн дүрсийн талбайн хэмжээг олж, тайлбарлаарай.



**324** Сургуулийн тоглоомын талбай квадрат хэлбэртэй. Түүний тал 100 м урттай. Бат тоглоомын талбайг нэг удаа тойрч алхав. Тэр хэр хол алхсан бэ? 2 удаа тойрвол хэдий хэмжээний зам туулах вэ?

**325** Өрөө, түүнд байрлуулж болох юмсыг дүрсээр илэрхийлэн харуулав.





- Дээрх “өрөө” гэсэн том тэгш өнцөгтийг дэвтэртээ зураарай.
- квадратыг 1 см талтай гэж тооцъё. Зурагт “өрөө”-ний баруун гар талд дүрсэлсэн юмсын эзлэх талбайн хэмжээг өсөх эрэмбээр бичээрэй.
- Зураг дахь ширээ, шүүгээ зэргээс сонгон, “өрөө”-нд байрлуулан зураарай.
- “Өрөө”-нд зурсан юмс шалны ямар талбайг эзэлж байна вэ? Шалны сул талбайн хэмжээг олоорой.

**326** Өгсөн талбайтай дүрсүүдийг зурж, тэдгээрийн периметрийг жишээрэй.

- а. 6 см.кв      б. 12 см.кв      в. 9 см.кв      г. 18 см.кв      д. 5 см.кв


**327** Зүй тогтлыг олоорой. 4, 9 дэх дүрс хэдэн квадратаас тогтох вэ?



...




## СОРИХ


- 328** А, Б, В дүрсүүдийн талбайн хэмжээг бичээрэй. Г дүрсийн талуудыг хэмжиж, сантиметрээр тоймлоод, периметр, талбайн хэмжээг олоорой.




- 329** Тэгш өнцөгтийн урт 6 см, өргөн 4 см-тэй тэнцүү. Уг тэгш өнцөгтийн периметр, талбайн хэмжээг олоорой.


## БАТАТГАХ

- 330** Хүүхдүүд 1 см талтай , түүний хагас  ба хагасын хагастай тэнцэх  дүрсүүдээр зохиомж хийв.




- а. Хүүхдүүдийн бүтээсэн зохиомжийн талбайн хэмжээг олоорой.  
б. Квадрат, гурвалжин хайчлан, зохиомж хийгээрэй. Талбайг олоорой.

- 331** Өгсөн талбайтай, ялгаатай тэгш өнцөгтүүд зураарай. Өөр ямар дүрс зурж болох вэ? Ижил талбайтай дүрсүүдээс хамгийн их периметртэйг олоорой.  нь дөрвөлжин шугамтай цаасны 1 нүд болно.

а. 10  б. 8  в. 16  г. 24 

- 332** Өгсөн дүрсийн талуудын уртыг хэмжээрэй. Периметрийг олоорой.



- 333** Тэгш өнцөгт 6 см урттай, 2 см өргөнтэй байв. Уртыг 2 дахин багасгавал тэгш өнцөгтийн периметр, талбайн хэмжээ яаж өөрчлөгдөх вэ?

- 334** Периметр нь 10 см байх тэгш өнцөгтүүдийг зураарай. Тэдгээрийн талбайн хэмжээг олоорой.

**335**



Гурван цаасны нийт талбайн хэмжээ 198 см.кв. Нэг ба хоёр дахь цаасны талбайн хэмжээний нийлбэр 108 см.кв. Хоёр ба гурав дахь цаасны талбайн хэмжээний нийлбэр 145 см.кв байв. Цаас тус бүрийн талбайн хэмжээг олоорой.

## КУБ, ТҮҮНИЙ ДЭЛГЭЭСИЙГ ТАНИХ

**336**




Зурагт юуг харуулсан байна вэ? Эдгээр нь ямар хэлбэртэй вэ?




**337**

Хайрцгийг судалъя.

- а. Дээрх хэлбэртэй хайрцаг олж бэлтгээрэй.
- б. Юуг талс, орой, ирмэг гэснийг анхаараарай.
- в. Хайрцгийн талсуудыг дугаарлаарай.




Хайрцгийн талс бүрийг цаасан дээр байрлуулж, хүрээлж зураарай.  
Хүрээлсэн талсын дугаарыг цаасан дээрх дүрсэд бичээрэй.  
Ямар дүрс хэдийг зурсан бэ? Дүрсүүдийн хэмжээ ямар байна вэ?



- г. Хайрцгийн ирмэгүүдийг тоолоорой. Хэдэн ирмэг тэнцүү урттай байна вэ?
- д. Хайрцаг хэдэн оройтой байна вэ?
- е. Хийснээ дүгнэн ярилцаарай. Хүснэгтэд үр дүнг бичээрэй.

Биетийн нэр	Талсын тоо	Ирмэгийн тоо	Оройн тоо	Талсын хэлбэр
				квадрат




**338**



дүрсийн орой, талын тоог хүснэгтэд бичээрэй.

Дүрсийн нэр	Талын тоо	Оройн тоо

**339**




Зурагт үзүүлсэн дүрс, биетийн оройн тоо тэнцүү байна уу? Эдгээр дүрс, биетийн ялгааг тайлбарлаарай.  
Орчноосоо квадрат, куб хэлбэртэй зүйлсийг олж бичээрэй.

**340**



Квадрат, куб бүтээе.

- а. Цаасаар квадрат, баримлын шавраар куб хийгээрэй.
- б. Баримлын шавар, соруул, савхаар квадрат, кубийн загвар бүтээгээрэй.




341

Өмнөх дадлага ажилд тулгуурлан асуултад хариулж бичээрэй.

а. Куб хийхэд хэдэн савх хэрэглэсэн бэ? Энэ нь кубийн юу болох вэ?

б. Савхнуудаа холбосон баримлын шавар биетийн юу болох вэ?

в. Цаасаар биетийн юуг хийж болох вэ? Квадрат, куб ямар ялгаатай вэ?




342



Куб хэлбэртэй хайрцгийн дэлгээсийг харъя.

Куб хэлбэртэй хайрцаг, хайч бэлтгэе. Болгоомжтой ажиллаарай.

а. Хайрцгийг задлаад, ажиглаарай. Хайрцгийн “дэлгээс” үүснэ.



б. Хайрцгаа зурагт үзүүлснээс өөрөөр задалсан сурагч байна уу? Хэчнээн ялгаатай дэлгээс үүсгэх боломжтой вэ? Яаж мэдсэн бэ?

Дэлгээс нь хэдэн ширхэг, ямар дүрсээс тогтож байна вэ?

в. Дэлгээсийн аль талсууд тэнцүү байна вэ? Дүгнэж ярилцаарай.

343



4 см талтай квадратуудаар куб хэлбэртэй хайрцаг хийе.

Хэдэн квадрат бэлтгэх хэрэгтэй вэ?

а. Квадратуудыг скочоор (наалддаг тууз) холбоод, кубийн дэлгээс хийгээрэй.

б. Зөв дэлгээс эсэхийг куб бүтээж шалгаарай. Талсуудыг скочоор холбоорой.

в. Кубийн дэлгээс өөр ямар байж болох вэ? Хийж туршаарай.


344



2 см ирмэгтэй кубийг дэлгээсээр нь бүтээе.

Цаас, цавуу, хайч, харандаа, шугам бэлтгэнэ.

Цаасаа гамтай хэрэглээрэй. Хайчтай болгоомжтой харьцаарай.



а. Зурагт үзүүлсэн дэлгээсийг зураарай.

б. Дэлгээс нь цавуудах хэсэгтэй байхаар хайчлаарай.


в. Хайчилсан хэвийг зураасын дагуу нугалж, куб бүтээгээрэй.

г. Зургаа хараад, цавуудах хэсгийг тооцолгүй дэлгээсийн талбайн хэмжээг олоорой.




д. Дэлгээсийн талбайн хэмжээг олсон аргуудаа ярилцаарай.

## СОРИХ

- 345** Зурагт үзүүлсэн биетийн нэр, шинжийг гүйцээн бичээрэй.  
 Биетийн нэр: ..... . Биет  талс,  орой,  ирмэгтэй.  
 Бүх ирмэгийн урт нь .....




- 346** Кубийн дэлгээсийг аль дүрсүүдээр хийх боломжтой вэ? Яагаад?







Кубийн дэлгээсийн талбайн хэмжээг олоорой.

## БАТАТГАХ

- 347** Дүрс, биетийн ялгааны талаар ярилцаарай.  
 а. Зурагт аль нь дүрс, биет вэ? Юугаараа ижил, ялгаатай вэ?  
 б. Бодит биет, дүрсийг барьж үзээд, шалгаарай.  
 в. Орчин тойрноосоо куб хэлбэртэй юмсыг олж бичээрэй.



- 348** Аль дэлгээсээр куб бүтээж болох вэ? Яаж мэдсэнээ тайлбарлаарай.



Кубийн дэлгээс өөр ямар хэлбэртэй байж болох вэ?



- 349** Дараах тохиолдолд кубийн дэлгээсийн талбайн хэмжээг олоорой.  
 а. Нэг талсын талбай 36 см.кв                      в. Ирмэгийн урт 7 см  
 б. Ирмэгийн урт 5 см                                  г. Нэг талсын периметр 12 см

**350**



Талбайн хэмжээг олъё.






Өгсөн хэмжээтэй куб хийж, “байшин” гэж төсөөлье. Хаалга, цонх хийж, наагаарай. Хана, шалны талбайн хэмжээг олоорой.



**351**




Кубийн тоог олж бичээрэй.



## АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ

- 352** Жигнүүрт 22 ширхэг бууз байв. Таван хүүхэд тэнцүү тоогоор хувааж идэж чадах уу? Ярилцаарай.
- 353** 94 номыг 4 сургуульд хуваарилах болов. Сургууль бүрд тэнцүү тоогоор өгөх боломжтой юу? Яагаад?
- 354** Зогсоолд 312 машин байв. Хэрэв нэг эгнээнд 20 машин байрладаг бол хамгийн багадаа хэдэн эгнээнд машин тавигдсан бэ?
- 355** Нэг хайрцагт 12 шилэн аяга байв. Нагац ах цайны газартаа 30 ширхэг шилэн аяга авах хэрэгтэй байв. Хамгийн багадаа хэдэн хайрцгийг авах хэрэгтэй вэ?

**Жишээ 1** Гурван анги 546 кг хаягдал цаас цуглуулав. Хоёрдугаар анги нэгдүгээр ангиас 19 кг илүү, гуравдугаар анги нөгөө хоёр ангийн нийт цуглуулсантай тэнцүүг цуглуулсан бол анги тус бүр хэдэн килограмм цаас цуглуулсан бэ? Бодолтыг ажиглаад, гүйцээгээрэй. Хэрхэн бодсоныг тайлбарлаарай.



1) Нэгдүгээр ангийн цаасны хэмжээг харуулах хэрчимтэй тэнцүү хэрчим нийт хэд байна вэ?

$$1 + 1 + 2 = 4 \text{ (тэнцүү хэрчмийн тоо)}$$

2) Эдгээр нь хэдэн килограмм цаасыг илэрхийлэх вэ?

$$546 - 19 - 19 = 508 \text{ (кг)}$$

3) Нэгдүгээр анги хэдэн килограмм цаас цуглуулсан бэ?  $508 \div 4 = \square$  (кг)

4) Хоёрдугаар анги хэдэн килограмм цаас цуглуулсан бэ?  $\square + 19 = \square$  (кг)


5) Гуравдугаар анги хэдэн килограмм цаас цуглуулсан бэ?  $\square + \square = \square$  (кг)

Шалгая:  $\square + \square + \square = \square$  (.....)

- 356** Хоёр тооны нийлбэр 277. Нэг тоо нөгөөгөөс 87-оор илүү. Эдгээр тоог олоорой.
- 357** Хоёр тавиур дээр бүгд 106 ном байв. Хэрэв нэгдүгээр тавиураас 18 ном авбал хоёр тавиурын номын тоо тэнцэнэ. Анх тавиур бүрд хэдэн ном байсан бэ?
- 358** Гурван тооны нийлбэр 6780. Хоёрдугаар тоо нэгдүгээрээс 247-оор их, гуравдугаараас 388-аар бага бол тоо тус бүрийг олоорой.
- 359** Гурван тавиур дээр 870 ном байв. Нэгдүгээр тавиурт хоёрдугаараас 50-аар олон, гуравдугаар тавиурт хоёрдугаараас 130-аар олон ном байсан. Тавиур бүрд хэдэн ном байсан бэ?

**Жишээ 2** Бичгийн хоёр хавтсанд бүгд 1250 цаас байв. Нэг хавтсанд нөгөөгөөс 4 дахин бага цаас байсан бол хавтас бүрд хэдэн цаас байсан бэ?

Бодолт: Нэг хавтас нөгөөгөөс 4 дахин бага цаастай. Бага цаастай хавтсыг 1 нэгж хэрчмээр дүрсэлье.



1) Тэнцүү нэгж хэрчим хэд байна вэ?

$$1 + 4 = 5 \text{ (тэнцүү хэрчмийн тоо)}$$

2) 5 хэрчим хэдэн цаасыг дүрслэх вэ?  
1250 (цаас)

3) 1 нэгж хэрчимд хэд ногдох вэ?  $1250 \div 5 = 250$  (нэгдүгээр хавтасны цаас)


4) Дөрвөн нэгж хэрчим буюу хоёрдугаар хавтсанд хэдэн цаас байсан бэ?

$$250 \times 4 = 1000 \text{ (хоёрдугаар хавтасны цаас)}$$

Шалгая:  +  =  (.....)

**360** Номин 8 бодлого бодсон нь Туяагийнхаас 4 дахин их, Батынхаас 3 дахин бага бол Бат Туяагаас хэдээр олон бодлого бодсон бэ?

Тэд нийт хэдэн бодлого бодсон бэ? Зураглал хэрэглэн бодоорой.



**361** Тэгш өнцөгтийн урт ба өргөний ялгавар 190 см, нийлбэр нь 206 см. Урт, өргөнийг олоорой. Тэгш өнцөгтийн периметр, талбайн хэмжээг олоорой.

**362** Хадлангийн багууд өвс бэлтгэв. Нэгдүгээр баг 600 боодол, хоёрдугаар баг нэгдүгээрээс 10 дахин их, гуравдугаар нь нэгдүгээрээс 10 дахин бага боодол өвс бэлтгэв. Бүгд хэдэн боодол өвс бэлтгэсэн бэ?

**363** Ногооны гурван талбайнаас байцай хураав. Нэгдүгээр талбайнаас 274 кг байцай хураасан. Хоёрдугаар талбайнаас нэгдүгээр талбайнаас хураасан байцайнаас 27 кг-аар их, гуравдугаар талбайнаас нэгдүгээрхээс 2 дахин бага байцай хураасан бол бүгд хэдэн килограмм байцай хураасан бэ?

**364** Гурван тооны нийлбэр 537. Тэдгээрийн нэг нь хамгийн их хоёр оронтой тоо, харин хоёр дахь нь гурав дахиас 2 дахин их. Эдгээр тоог олоорой.

**365** Хүү, охин, эцэг гурвын нас нийлээд 55. Эгч нь дүүгээсээ 3 дахин, эцэг нь хүүгээс 7 дахин өндөр настай бол тус бүрийн насыг олоорой.

**366** Хоёр саванд бүгд 140 л ус байв. Нэгдүгээр савнаас 26 л, хоёр дахиас 60 л ус авахад нэгдүгээрт хоёр дахиас 2 дахин их ус үлджээ. Сав бүрд хэдэн литр ус байсан бэ?



## ХУГАЦАА ХЭМЖИХ

**367**




Хонгорын нэг өдөр хийсэн зүйлсийг зургаар харуулжээ. Зарим зурагт үйл явдлын эхэлсэн, дууссан цагийг харуулсан байна. Зургийн үйл явдлыг зөв дараалалд оруулж, дугааруудыг жагсаан бичээрэй.

**368**

Асуултад хариулаарай.

- а. Хонгор хэдэн цагт, юу хийсэн бэ?
- б. Сургуульд хичээллэхэд ямар хугацаа зарцуулсан бэ?
- в. Асуулт зохиож, ярилцаарай.
- г. Хонгор өглөө босоод, цайгаа уух хүртэл ямар хугацаа өнгөрсөн бэ?
- д. Хонгор хэдэн цаг тоглосон бэ?



Дижитал цаг

7:01

Аналоги цаг

Долоон цаг нэг минут

1 цаг = 60 минут



**369** Цагийг дэвтэртээ дүрслэх буюу бичээрэй.

Аналоги цаг		Дижитал цаг	
			
12 цагаас 20 минут өнгөрч байна.	12 цагаас 38 минут өнгөрч байна.	10 цагаас __ минут өнгөрч байна.	5 цагаас 19 минут өнгөрч байна.
1 цагт 40 минут дутуу байна.	1 цагт __ минут дутуу байна.	11 цагт __ минут дутуу байна.	6 цагт __ минут дутуу байна.

Өчигдөр эдгээр цагт чи юу хийж байсан бэ?

**370** Хэдэн цаг болж байгааг харуулсан байна вэ? Асуултад хариулаарай.



- 1 цагийн дараа хэдэн цаг болж байх вэ?
- 1 цагийн өмнө хэдэн цаг болж байсан бэ?
- 50 минутын өмнө хэдэн цаг болж байсан бэ?
- 40 минутын дараа хэдэн цаг болж байх вэ?

**371** Хүүхдүүдийн яриаг уншаад, юу ойлгосноо тайлбарлаарай.



Биеийн тамирын хичээл дээр гүйсэн хугацааг секундээр хэмжиж байсан. Секунд гэж юуг хэлж байна вэ?



Зарим цаг секундийн зүүтэй байдаг. Секундийн зүү 1 бүтэн эргэхэд 1 минут болдог гэсэн.



- Секундийн зүү 12-ыг заасан хуваариас эхлэн 1 бүтэн тойрох хүртэл хэдэн хуваарь байгаа вэ?
- 1 минут хэдэн секундтэй тэнцэх вэ?

**372** Хэдэн секундийг зааж байгааг бичээрэй.



18 секунд



Дижитал цаг

7:04:06



6 секунд

3:42:25

9:13:48

4:59:32

**373** Нэг хоногт хэдэн цаг байдгийг ярилцаарай.



**374** 12 болон 24 цагийн горимоор цагийг дэвтэртээ бичээрэй. Цагийн загвар хэрэглэн хугацааг харуулаарай.

12:00	13:00	14:00			17:00	18:00		
0:00		2:00	3:00			6:00		8:00

**375** Гурван сарын цаг тооны бичгийг хүснэгтэд үзүүлэв.

	9 дүгээр сар					10 дугаар сар					11 дүгээр сар			
Да	1	8	15	22	29	6	13	20	27	3	10	17	24	
Мя	2	9	16	23	30	7	14	21	28	4	11	18	25	
Лх	3	10	17	24		1	8	15	22	29	5	12	19	26
Пү	4	11	18	25		2	9	16	23	30	6	13	20	27
Ба	5	12	19	26		3	10	17	24	31	7	14	21	28
Бя	6	13	20	27		4	11	18	25	1	8	15	22	29
Ня	7	14	21	28		5	12	19	26	2	9	16	23	30

**Баяр, тэмдэглэлт өдрүүд:**

- 09.01 Эрдмийн баяр
- 10.01 Ахмадын өдөр
- 11.26 Улс тунхагласан өдөр

Дээрх цаг тооны бичгийг хэрэглэн асуултад хариулаарай.

- а. Эрдмийн баяраа ямар гарагт тэмдэглэсэн бэ?
- б. 10 дугаар сарын эхний лхагва гарагт ямар баяр тэмдэглэсэн бэ?
- в. 9 дүгээр сарын 3-аас хэдэн долоо хоногийн дараа Монгол Улс тунхагласан өдөр болох вэ?
- г. Сар бүрийн 2 дахь пүрэв гараг хэдний өдөр байна вэ? Адил байна уу? Яагаад?
- д. Асуулт зохиож, бусдын асуултад хариулаарай.

**376** Хугацааг хэмжих нэгжүүдийн хамаарлыг бататгая. Ямар нэгжийг шинээр мэдэж авсан бэ?

**Хугацааны нэгжүүдийн хамаарал:**

- 1 зуун = 100 жил
- 1 жил = 12 сар
- 1 хоног = 24 цаг
- 1 минут = 60 секунд
- 1 жаран = 60 жил
- 1 улирал = 3 сар
- 1 цаг = 60 минут

**Жишээ 1** Ажиглаад, тайлбарлаарай.

- а. 20 зуун =  $(20 \times 100)$  жил = 2000 жил      г. 4 жил =  $(4 \times 12)$  сар = 48 сар  
 б. 800 жил =  $(800 \div 100)$  зуун = 8 зуун      д. 6 улирал =  $(6 \times 3)$  сар = 18 сар  
 в. 21 сар =  $(21 \div 3)$  улирал = 7 улирал      е. 5 хоног =  $(5 \times 24)$  цаг = 120 цаг

**377** Тохирох тоог олж бичээрэй.

- а. 21 зуун =  жил      д. 3 хоног =  цаг      и. 300 жил =  зуун  
 б. 7 жил =  улирал      е. 12 улирал =  сар      к. 5 жил =  сар  
 в. 8 жаран =  жил      ж. 32 улирал =  жил      л. 60 сар =  улирал  
 г. 24 улирал =  жил      з. 12 сар =  улирал      м. 200 жил =  зуун

**Жишээ 2** Ажиглаад, тайлбарлаарай.

- а.  $60 = 10 \times 6$ , 180 жил =  $(180 \div 60)$  жаран =  $(180 \div 10 \div 6)$  жаран = 3 жаран  
 б.  $72$  сар =  жил,  $12 = 3 \times 4 = 4 \times 3$ ,  $12 = 6 \times 2 = 2 \times 6$   
 $72$  сар =  $(72 \div 3)$  улирал =  $(72 \div 3 \div 4)$  жил =  $(24 \div 4)$  жил = 6 жил  
 в. 120 цаг =  хоног,  $24 = 6 \times 4 = 4 \times 6$ ,  $24 = 3 \times 8 = 8 \times 3$   
 120 цаг =  $(120 \div 24)$  хоног =  $(120 \div 6 \div 4)$  хоног =  $(20 \div 4)$  хоног = 5 хоног

**378** Үржвэрийн утгыг олоод, ярилцаарай.

Жишээ:  $60 = 6 \times 10 = 10 \times 6$ ,  $60 \times 9 = 540$ ,  $12 \times 60 = 12 \times 6 \times 10 = 720$

Үржигдэхүүн	60	60	60	60	60	60	60	60	60	60	60	60	60
Үржигдэхүүн	2	3	4	5	6	7	8	9	10	12	15	21	34
Үржвэрийн утга													

**379** Хугацааны нэгжүүдийг заасан нэгжээр илэрхийлээрэй.

- а. 4 жаран =  жил      г. 8 жил =  сар      ж. 6 хоног =  цаг  
 б. 120 жил =  жаран      д. 36 сар =  жил      з. 72 цаг =  хоног  
 в. 360 жил =  жаран      е. 96 сар =  жил      и. 168 цаг =  хоног

**Жишээ 3** Ажиглаад, ярилцаарай. Тэмдэглэгээ: секунд (с)

- а.  $60 = 6 \times 10 = 10 \times 6$ , 45 минут =  $(45 \times 60)$  с =  $(45 \times 6 \times 10)$  с = 2700 с  
 б. 2 цаг 35 минут = 2 цаг + 35 минут =  $(2 \times 60)$  минут + 35 минут = 155 минут

**380** Хугацааны нэгжүүдийг заасан нэгжээр илэрхийлээрэй.

- а. 7 цаг =  минут      г. 5 минут =  с      ж. 40 хоног =  цаг  
 б. 10 цаг =  минут      д. 8 минут =  с      з. 20 жил =  сар  
 в. 24 цаг =  минут      е. 15 минут =  с      и. 5 цаг =  с

**381** Хугацааны нэгжүүдийг заасан нэгжээр илэрхийлээрэй.

- а. 4 цаг 55 минут =  минут      г. 6 минут 45 с =  с  
 б. 8 цаг 9 минут =  минут      д. 10 минут 38 с =  с  
 в. 12 цаг 49 минут =  минут      е. 8 жил 5 сар =  сар

**382** Мэдэгдэхгүй байгаа тоонуудыг олоорой. Бодолтоо бичээрэй.

Жишээ:  $60 = 10 \times 6$ ,  $420 \div 60 = 420 \div 10 \div 6 = 42 \div 6 = 7$

Хуваагдагч	600	480	180	420	240	60	300	360	120	540
Хуваагч	10	8			60	60			60	
Ногдворын утга			60	60			60	60		60


**383** Хугацааны нэг нэгжийг заасан нэгжээр илэрхийлээрэй.

Жишээ:  $480 \text{ минут} = (480 \div 60) \text{ цаг} = (480 \div 10 \div 6) \text{ цаг} = 8 \text{ цаг}$

- а.  $120 \text{ минут} = \square \text{ цаг}$       г.  $60 \text{ с} = \square \text{ минут}$       ж.  $180 \text{ жил} = \square \text{ жаран}$   
 б.  $540 \text{ минут} = \square \text{ цаг}$       д.  $600 \text{ с} = \square \text{ минут}$       з.  $300 \text{ с} = \square \text{ минут}$   
 в.  $360 \text{ минут} = \square \text{ цаг}$       е.  $420 \text{ с} = \square \text{ минут}$       и.  $240 \text{ минут} = \square \text{ цаг}$

**Жишээ 4** Ажиглаад, ярилцаарай. Тэмдэглэгээ: секунд (с)

- а.  $195 \text{ с} = \square \text{ минут } \square \text{ с}$       б.  $500 \text{ минут} = \square \text{ цаг } \square \text{ минут}$



Бодолт: а. Тоон шулуун дээр 195 нь 180 ба 240-ийн хооронд оршино.

$180 < 195$  тул  $195 = 180 + 15$

$195 \text{ с} = 180 \text{ с} + 15 \text{ с} = (180 \div 60) \text{ минут} + 15 \text{ с} = 3 \text{ минут } 15 \text{ с}$

б. 500 нь 480 ба 540-ийн хооронд оршино.  $480 < 500$  тул  $500 = 480 + 20$

$500 \text{ минут} = 480 \text{ минут} + 20 \text{ минут} = (480 \div 60) \text{ цаг} + 20 \text{ минут} = 8 \text{ цаг } 20 \text{ минут}$

**384** Хугацааны нэгжүүдийг заасан нэгжээр илэрхийлээрэй.

- а.  $210 \text{ с} = \square \text{ минут } \square \text{ с}$       г.  $83 \text{ минут} = \square \text{ цаг } \square \text{ минут}$   
 б.  $375 \text{ с} = \square \text{ минут } \square \text{ с}$       д.  $280 \text{ минут} = \square \text{ цаг } \square \text{ минут}$   
 в.  $148 \text{ с} = \square \text{ минут } \square \text{ с}$       е.  $570 \text{ минут} = \square \text{ цаг } \square \text{ минут}$

**385** Жишээрэй.

- а.  $60 \text{ минут } \square \text{ } 300 \text{ с}$       г.  $2 \text{ улирал } \square \text{ } 5 \text{ сар}$       ж.  $144 \text{ цаг } \square \text{ } 7 \text{ хоног}$   
 б.  $5 \text{ цаг } \square \text{ } 300 \text{ минут}$       д.  $5 \text{ жил } \square \text{ } 61 \text{ сар}$       з.  $240 \text{ жил } \square \text{ } 3 \text{ жаран}$   
 в.  $1 \text{ цаг } \square \text{ } 3600 \text{ с}$       е.  $9 \text{ зуун } \square \text{ } 890 \text{ жил}$       и.  $298 \text{ минут } \square \text{ } 5 \text{ цаг}$


**386** Жишээд, тайлбарлаарай.

- а.  $4 \text{ цаг } 10 \text{ минут } \square \text{ } 410 \text{ минут}$       г.  $8 \text{ жил } 3 \text{ сар } \square \text{ } 98 \text{ сар}$   
 б.  $230 \text{ минут } \square \text{ } 2 \text{ цаг } 30 \text{ минут}$       д.  $1 \text{ зуун } 20 \text{ жил } \square \text{ } 1 \text{ жаран } 50 \text{ жил}$   
 в.  $3 \text{ минут } 45 \text{ с } \square \text{ } 215 \text{ с}$       е.  $\text{Найман } 7 \text{ хоног } \square \text{ } 2 \text{ сар}$

**387** Хэмжээг өсөх эрэмбээр бичээрэй.

- а.  $301 \text{ минут}$ ,  $4 \text{ цаг } 50 \text{ минут}$ ,  $5 \text{ цаг}$       в.  $70 \text{ сар}$ ,  $3 \text{ жил } 9 \text{ сар}$ ,  $48 \text{ сар}$   
 б.  $1 \text{ цаг}$ ,  $59 \text{ минут } 30 \text{ с}$ ,  $3580 \text{ с}$       г.  $2 \text{ хоног}$ ,  $1 \text{ хоног } 22 \text{ цаг}$ ,  $47 \text{ цаг}$

**388** Хонгор хичээлээ давтахад ямар хугацаа зарцуулсныг олоорой.



Хэдэн цагаас хичээлээ хийж эхэлсэн бэ?  
Хэдэн цаг хэдэн минутад хийж дууссан бэ?  
Хичээл хийхэд ямар хугацаа зарцуулсан бэ?  
 $2 \text{ цаг } 42 \text{ минут} - 1 \text{ цаг} = \square \text{ цаг } \square \text{ минут}$   
Зарцуулсан хугацааг минутаар илэрхийлээрэй.

**Жишээ 5** Ажиглаад, бодолтыг тайлбарлаарай. Тэмдэглэгээ: минут (мин)

- а.  $8 \text{ цаг } 28 \text{ мин} + 2 \text{ цаг } 13 \text{ мин} = (8 + 2) \text{ цаг} + (28 + 13) \text{ мин} = 10 \text{ цаг } 41 \text{ мин}$   
б.  $5 \text{ цаг } 30 \text{ мин} - 3 \text{ цаг } 15 \text{ мин} = (5 - 3) \text{ цаг} + (30 - 15) \text{ мин} = 2 \text{ цаг } 15 \text{ мин}$

**389** Тооцоолоорой.

- а.  $15 \text{ минут } 27 \text{ с} + 26 \text{ минут } 18 \text{ с}$       д.  $7 \text{ цаг } 52 \text{ минут} - 4 \text{ цаг } 30 \text{ минут}$   
б.  $3 \text{ цаг } 9 \text{ минут} + 12 \text{ цаг } 36 \text{ минут}$       е.  $23 \text{ цаг } 39 \text{ минут} - 12 \text{ цаг } 15 \text{ минут}$   
в.  $4 \text{ жил } 10 \text{ сар} - 2 \text{ жил } 8 \text{ сар}$       ж.  $4 \text{ хоног } 13 \text{ цаг} + 3 \text{ хоног } 6 \text{ цаг}$   
г.  $32 \text{ минут } 50 \text{ с} - 18 \text{ минут } 37 \text{ с}$       з.  $11 \text{ хоног } 21 \text{ цаг} - 8 \text{ хоног } 9 \text{ цаг}$

**390** Болд даалгавраа 2 цаг 25 минутад хийж, 1 цаг 50 минут тоглов.

- 1) Даалгавар хийж эхлээд, тоглож дуустал ямар хугацаа өнгөрснийг олъё.  
 $2 \text{ цаг } 25 \text{ минут} = \square \text{ минут}$ ,       $1 \text{ цаг } 50 \text{ минут} = \square \text{ минут}$   
 $2 \text{ цаг } 25 \text{ минут} + 1 \text{ цаг } 50 \text{ минут} = \square \text{ минут} + \square \text{ минут} = \square \text{ минут}$
- 2) Алинд нь хэдээр илүү хугацаа зарцуулсан бэ?  
 $2 \text{ цаг } 25 \text{ минут} - 1 \text{ цаг } 50 \text{ минут} = \square \text{ минут} - \square \text{ минут} = \square \text{ минут}$

**391** Тооцоолоорой.

- а.  $4 \text{ цаг } 30 \text{ минут} + 2 \text{ цаг } 48 \text{ минут}$       г.  $8 \text{ минут } 32 \text{ с} - 5 \text{ минут } 49 \text{ с}$   
б.  $5 \text{ цаг } 5 \text{ минут} - 3 \text{ цаг } 24 \text{ минут}$       д.  $12 \text{ минут } 45 \text{ с} + 29 \text{ минут } 45 \text{ с}$   
в.  $12 \text{ минут } 45 \text{ с} + 29 \text{ минут } 45 \text{ с}$       е.  $6 \text{ хоног } 9 \text{ цаг} - 2 \text{ хоног } 13 \text{ цаг}$

**Жишээ 6** Ажиглаад, бодолтыг тайлбарлаарай.

- а.  $1 \text{ цаг } 20 \text{ минут} \times 5 = (60 + 20) \text{ минут} \times 5 = 80 \text{ минут} \times 5 = 400 \text{ минут}$   
б.  $3 \text{ цаг } 20 \text{ минут} \div 5 = (3 \times 60 + 20) \text{ минут} \div 5 = 200 \text{ минут} \div 5 = 40 \text{ минут}$

**392** Тооцоолоорой.

- а.  $3 \text{ цаг} \times 8$       в.  $828 \text{ минут} \div 9$       д.  $8 \text{ минут } 5 \text{ с} \times 9$       ж.  $56 \text{ цаг} \div 7$   
б.  $17 \text{ минут} \times 4$       г.  $3 \text{ цаг } 40 \text{ минут} \times 5$       е.  $2 \text{ цаг } 32 \text{ минут} \div 8$       з.  $492 \text{ с} \div 6$

**393**



1) Сурагчид ээлжлэн цаг бичсэн карт харуулахад нөгөө нь цагийн загвар дээр харуулж хэлнэ.

2) Жишээрэй: а.  $4 \text{ цаг } 2 \text{ минут} \square 244 \text{ минут}$

б.  $2 \text{ сар} \square 40 \text{ хоног}$       в.  $3 \text{ жил} \square 37 \text{ сар}$       г.  $62 \text{ с} \square 1 \text{ минут}$



## БАТАТГАХ

**394** а. Цаг хэд болж байгааг бичээрэй.



б. Нэгэн ижил хугацааг зааж буй цагийг ялган бичээрэй.

16:13, 22:22, 19:10, 24:00, 4:13, 10:10, 10:22, 7:10, 00:00

**395** Хэмжээг заасан нэгжээр илэрхийлээрэй. *Тэмдэглэгээ:* минут (мин)

- а. 5 мин 15 с =  с      г. 3 цаг 20 мин =  мин      ж. 3 мин 2 с =  с  
 б. 360 мин =  цаг      д. 26 сар =  жил  сар      з. 5 зуун =  жил  
 в. 7 жаран =  жил      е. 82 мин =  цаг  мин      и. 308 с =  мин  с

**396** Хэмжээг буурах эрэмбээр бичээрэй.

- а. 200 минут, 3 цаг 30 минут, 3 цаг      в. 1 жил 18 сар, 31 сар, 2 жил 8 сар  
 б. 10 минут 45 с, 661 с, 11 минут      г. 8 м 37 см, 90 дм, 850 см, 89 дм

**397** Тооцоолоорой.

- а. 5 цаг 27 минут + 3 цаг 35 минут      в. 40 минут 20 с + 13 минут 16 с  
 б. 3 цаг 30 минут – 1 цаг 54 минут      г. 24 минут 10 с – 12 минут 40 с  
 д. 367 цаг × 8      е. 736 минут ÷ 8      ж. 4 цаг 45 минут × 6      з. 360 хоног ÷ 9

**398** Жуулчин 40 минутад уулын оргил дээр гарахад 11 цаг 30 минут болж байв. Анх хэдэн цагт авирч эхэлсэн бэ? Яаж олсон бэ?



**399** Галт тэрэг Улаанбаатараас өглөөний 9:15-д хөдлөв.

2 цаг 56 минутын дараа Хангай өртөөнд ирэхэд хэдэн цаг болж байсан бэ?

**400** Хөлдсөн буузыг 15 минут жигнэнэ. Үүний өмнө усаа буцлах хүртэл 10 минут хүлээнэ. Буузаа 12:00 цагт тавгалахын тулд усаа хэдээс халааж эхлэх вэ?

**401** Кинотеатрт гарах үзвэрийн цагийн хуваарийг хүснэгтээр үзүүлэв.

Үзвэрийн дугаар	1	2	3	4	5
Эхлэх хугацаа	?	12:50	14:50	16:50	?

- а. 1, 5 дахь үзвэр хэдэн цагт эхлэх вэ? Олсон аргаа тайлбарлаарай.  
 б. Үзвэр 90 минут үргэлжилдэг. Сүүлийн үзвэр хэдэн цагт дуусах вэ?  
 в. Сүрэн амралтын өдөр үзвэр үзэхээр шийдэн, хийх зүйлээ төлөвлөв.

Хийх зүйл	Босоод, нүүр гараа угаах	Өглөөний цай уух	Хичээлээ давтах	Гэрээ цэвэрлэх	Хоолоо идэх	Кинотеатр уруу явах
Хугацаа	25 минут	20 минут	90 минут	40 минут	35 минут	45 минут

Тэр 2 дахь үзвэрийг үзэх бол өглөө хэдээс босох хэрэгтэй вэ?  
 Үзвэрээ үзэж дуусгаад, гэртээ хэдэн цагт ирэх вэ?



## ЭЕРЭГ, СӨРӨГ ТООГ ТАНИХ

402



Зургийг ажиглаад, асуултад хариулаарай.

Өвөл яагаад зузаан хувцасладаг вэ?  
Зун яагаад нимгэн хувцасладаг вэ?  
Халуун хүйтнийг яаж тэмдэглэдэг вэ?




Халуун хүйтнийг хэмждэг багажийг термометр гэнэ.



403


Саран 10 дугаар сарын 15-ны өдрийн агаарын температурыг 3 цаг тутамд 6 удаа хэмжив.



а. Дээрх зургийн термометрийн заалтуудыг уншиж, хүснэгтэд бичээрэй.




-2 хэм



4:00	7:00	10:00	13:00	16:00	19:00
	-2				



Термометрийн сөрөг заалтыг уншихдаа 0-ээс доош байрлах зураасуудаа тоолж температур хэд болохыг олно.

б. Термометрийн заалтуудыг тоон шулуун дээр цэгээр тэмдэглээрэй.



в. Хэдэн цагт хамгийн хүйтэн, хэдэн цагт хамгийн дулаан байна вэ?


**404** Термометрийн заалтуудыг бичээрэй



**-5** гэсэн тоог **хасах тав** гэж уншдаг:



**Жишээ 1** Тоон шулуун хэрэглэн тоонуудыг жишээрэй: а. 0 ба -3 б. -2 ба -5  
Тоонуудаа тоон шулуун дээр цэгээр тэмдэглэе.




- а. 0 нь -3-ын баруун гар талд оршиж байгаа тул  $0 > -3$ .  
-3 нь 0-ийн зүүн гар талд оршиж байгаа тул  $-3 < 0$ .
- б. -2 нь -5-ын баруун гар талд оршиж байгаа тул  $-2 > -5$ .

Тоон шулуун дээр тэмдэглэсэн тоонуудын баруун гар талын тоо нь их байна. Эерэг тоо нь сөрөг тооноос их байна.

**405** Тоон шулуун хэрэглэн тоонуудыг жишээрэй.  
 $0 \square 6$ ,  $-1 \square 0$ ,  $-2 \square 2$ ,  $1 \square -9$ ,  $-8 \square 0$ ,  $-4 \square -10$

**406** Тоон шулуун дээр цэгээр тэмдэглэн, багаас их рүү жагсааж бичээрэй.  
а. -4, 2, 0, 3, -1      б. 5, -2, 1, 3, -3      в. 4, 0, -6, -8, 2, -1

**407** -10-аас 10-ын хооронд орших таван тоо бичээрэй.  
а. Тоон шулуун хэрэглэж тоогоо 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолоорой.



- б. 0-ээс зүүн гар тийш 5, буцаж баруун гар тийш 2 нэгж явбал хэд дээр очих вэ?
- в. 0-ээс баруун гар тийш 5, буцаж зүүн гар тийш 2 нэгж явбал хэд дээр очих вэ?

**408**





1) Сурагч тооны өмнөх тэмдгийг анзааралгүй температурыг 18 гэж харав. Дулаан, хүйтний алинд тоо ямар байх вэ?

2) Тоон шулуун хэрэглэн жишээрэй:  $7 \square 3$ ;  $0 \square -2$ ;  $5 \square -6$ ;  $-4 \square -8$



## БАТАТГАХ

**409** Термометрийн заалтуудыг бичээрэй



**410** Өгсөн мэдээг хэрэглэн асуултад хариулаарай.

- Агаарын температур хаана адил байна вэ?
- Ялгаатай температурыг тоон шулуун дээр цэгээр тэмдэглээрэй.
- Хаана хамгийн хүйтэн байна вэ?
- Хаана хамгийн дулаан байна вэ?
- Эхний таван температурыг өсөх эрэмбээр бичээрэй.
- Монголд өвөлдөө аль аймагт хамгийн хүйтэн байдаг вэ? Зундаа аль аймагт хамгийн халуун байдаг вэ? Ярилцаарай.

1.	Арвайхээр	- 2
2.	Хархорин	- 1
3.	Булган	- 7
4.	Сүхбаатар	- 4
5.	Зуунмод	- 1
6.	Дархан	- 2
7.	Эрдэнэт	- 3
8.	Чойр	1
9.	Өндөрхаан	- 4
10.	Чойбалсан	1
11.	Баруун-Урт	1
12.	Мандалговь	1
13.	Даланзадгад	5
14.	Ханбогд	8
15.	Сайншанд	6
16.	Замын-Үүд	3

**411** Тоонуудыг эрэмбэлээрэй.

- 10; 8; 3; 0; -1
- 3; 7; -4; 0; 2
- 8; -5; 0; -2; 5
- 4; 9; -5; -2; 1
- 2; -6; 0; -7; -2
- 8; -9; 6; -1; -3

**412** 5 өдөр дараалан цаг агаарын мэдээнээс агаарын температурыг бичээрэй.

Агаарын температур	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
Өдөр					
Шөнө					

Аль гарагт өдөртөө хамгийн дулаан, аль гарагт хамгийн хүйтэн байсан бэ?  
Аль гарагт шөнөдөө хамгийн дулаан, аль гарагт хамгийн хүйтэн байсан бэ?

**413** -8; 6; 5; 0; -3; 2; 11; -15; -7; 7 тоонуудыг тоон шулуун дээр байрлуулаарай. Өсөх, буурах эрэмбээр уншаарай.


**414**



Эерэг, сөрөг тоог жагсаан байрлуулъя.

Сурагчид хоёроороо ажиллана. 6 эерэг, 6 сөрөг тоотой карт бэлтгэнэ. Картуудыг холиод багцаар нь доош харуулан тавина. Сурагчид ээлжлэн багцаас 3 карт авч өсөх дарааллаар байрлуулна. Нөгөө сурагч шалгана.

## ЗҮЙ ТОГТЛЫГ ОЛОХ



Зурагт юуг харуулсан байна вэ? Эдгээрт ямар зүй тогтол харагдаж байна вэ?

**415** Сараа -ыг эвлүүлж, зохиомж хийв.

1 дүгээр зохиомж	2 дугаар зохиомж	3 дугаар зохиомж	4 дүгээр зохиомж

а. Сараа эхний гурван зохиомжид тус бүр хэдэн (квадрат) хэрэглэсэн бэ? Квадратын тоог хүснэгтэд бичээрэй.

Зохиомжийн дугаар	1 дүгээр зохиомж	2 дугаар зохиомж	3 дугаар зохиомж
Квадратын тоо			

- б. Сараагийн бүтээсэн зохиомж өмнөхөөсөө ямар ялгаатай байна вэ?
- в. Дөрөв ба тавдугаар зохиомжийг дэвтэртээ зураарай.
- г. Наймдугаар зохиомжийг бүтээхэд хэдэн квадрат хэрэгтэйг зуралгүйгээр олоорой. Олсон аргаа тайлбарлан бичээрэй.
- д. Тодорхой зүй тогтлоор дүрсүүдийг эвлүүлэн, зохиомж хийгээрэй. Хийснээ өөр сурагчид харуулж, зүй тогтлыг олуулаарай.

**416** Тоонуудын зүй тогтлыг олоод, үргэлжлүүлээрэй.

- а. 3, 8, 13, ..., ..., ...      б. 7, 14, 21, ..., ..., ...      в. 72, 63, 54, ..., ..., ...

**417** Болд тодорхой дүрмээр тоонуудыг дараалуулан бичихдээ зарим тоонуудыг орхисон байна. 5, 12, 26, ....., 110, ....., .....

Зүй тогтлыг олоод, орхисон тоонуудыг гүйцээгээрэй. Хийснээ тайлбарлаарай.

**418**



Тоонуудын зүй тогтлыг олъё.

- а. Сурагч бүр тодорхой зүй тогтлоор тоонуудыг дараалуулан бичээрэй. Тоонуудаа зөв бичсэн эсэхээ шалгаарай.
- б. Сурагч бүр өөр сурагчийн зохиосон тоонуудыг дарааллаар нь дэвтэртээ бичээрэй. Уг тоонуудын зүй тогтлыг олоорой. Энэ мэтчилэн хэд хэдэн сурагчийн бичсэн тоонуудын зүй тогтлыг олно.

**419** Хэмжээнүүдийн дарааллыг ажиглаад, зүй тогтлыг олоод, гүйцээгээрэй.

- а. 210 см, 190 см, ....., 120 см, ....., .....
- б. 3 см, 30 см, 300 см, 3000 см, ....., ....., .....
- в. 8 см, 8 дм, 8 м, 80 м, ..... м, ..... км, ..... км, .....

**420** Тоо, хэмжээнүүдийн зүй тогтлыг олж, үргэлжлүүлээрэй.

- а. 3275, 3375, 3475, ....., ....., 3775, ....., ....., .....
- б. 2 км 394 м, 2844 м, 3 км 294 м, ....., ....., .....
- в. 3 цаг, 240 минут, 5 цаг, ....., 7 цаг, ....., .....

**421**




Зүй тогтлын дагуу тоолъё.

Тоглоомыг эхлүүлэх сурагчаа сонгоно.

- а. Эхний сурагч нэг оронтой тоо хэлнэ.
- б. Дараагийн сурагч хэлсэн тоог нь 5-аар нэмэгдүүлж хэлнэ.
- в. Дараагийн тоглогч өмнөх сурагчийн хэлсэн тоог 1-ээр хорогдуулж хэлнэ. Энэ мэтчилэн өмнөх сурагчийн хэлсэн тоог дараагийн сурагч нь 5-аар нэмэгдүүлж, түүний дараагийнх 1-ээр хорогдуулж хэлнэ.
- г. Багийн бүх гишүүн тоог хэлж дууссаны дараа бүгд дэвтэртээ тоонуудыг хэлсэн дарааллаар нь бичнэ.
- д. Сурагч бүр дараагийн таван тоог олж бичнэ.
- е. Гишүүд тоонуудаа зөв бичсэн эсэхээ баг дотроо ярилцана. Тоонуудыг хэлэх дүрмээ өөрчлөн тоглоорой.

**422** Дараах дүрсүүд нь дугуйгаас бүтнэ. Ямар зүй тогтолтой байгааг ажиглаарай.



Дүрс 1    Дүрс 2    Дүрс 3    Дүрс 4

Дүрсийн дугаар	Дугуйн тоо
1	1
2	3
3	5
4	

- а. Дүрс 4 нь хэдэн дугуйгаас бүтсэн бэ?
- б. Дүрс 5-д хэдэн дугуй байх вэ? Зурж үзүүлээрэй.
- в. Дүрс 10-д хэдэн дугуй байхыг зуралгүйгээр олоорой. Хэрхэн олсноо тайлбарлан бичээрэй.

**423**



Зүй тогтлыг олоод, тайлбарлан бичээрэй. Дарааллыг гүйцээгээрэй.

- а. .....
- б. 3, 11, 19, ....., 35, ....., .....

## БАТАТГАХ


**424** 3274, 4581, 5015, 3407, 6968, 7050 тоонуудыг 10, 100, 1000-аар тус тус нэмэгдүүлэн, хорогдуулан тоолоорой. (Тус бүр гурван тоо хэлээрэй.)

**425** Үржвэрийн утгыг олж, хүснэгтийн тохирох газарт бичээрэй.  
Нэг өнгийн багана дахь тоонууд ямар зүй тогтолтой байна вэ?  
Хүрд хэрэглэн хуваах үйлдлийн жишээг гаргаарай.

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
3										
4										
7										

×	1	2	3	4	5	6	7	8	9	10
4										
7										
11										

**426** Дүрсүүдийг ажиглаад, зүй тогтлыг олоорой. Дараагийн 3 дүрсийг будаарай.



**427** Зүй тогтлыг олоод, дараагийн гурван тоог бичээрэй.

а. 8, 16, 24, 32, ..... в. 63, 60, 57, 54, .....

б. 8, 15, 22, 29, ..... г. 12, 24, 36, 48, .....

5, 10, 20 дахь тоо нь хэд байх вэ? Яаж олсноо тайлбарлаарай.

**428** Цагаан толгойн үсгүүдийг дугаарлаарай.


Өгсөн тоонуудын зүй тогтлыг олж, дараагийн таван тоог бичээрэй.

а. 1, 3, 5, 7, ..... в. 34, 31, 28, 25, .....

б. 2, 4, 6, 8, ..... г. 35, 33, 31, 29, .....

Эдгээр тоонд цагаан толгойн ямар үсгүүд харгалзахыг бичээрэй.

**429** Зүй тогтлыг олоорой. 4, 10 дахь зохиомж хэдэн дүрсээс тогтох вэ?



4, 10 дахь зохиомж хэдэн дүрсээс тогтох вэ? Зохиомжийг зурахгүйгээр яаж олох вэ? Олох аргыг тайлбарлаарай.

## ХҮНДИЙГ ХЭМЖИХ



Зурагт юу байна вэ? Эдгээрийн хүндийг хэмжих ямар нэгж, хэрэгсэл байдаг талаар мэдэх үү? Мэдэхгүй зүйлээ хамтдаа сурцгаая.


**430** Ярилцаарай.



Шугам,  
харандааны  
аль нь хүнд вэ?



Хоёр гартаа  
барьж үзвэл  
мэдэгдэх  
болов уу?



Янз бүрийн зориулалттай олон төрлийн хэмжих багаж байдаг гэсэн. Тухайлбал, тавган жинлүүр. Үүнийг өлгүүр, утас, жижиг цаасан аяга хэрэглэн хийж болно.



Тавган жинлүүрээр юмсын хүндийн хэмжээг мэдэж болох уу? Яагаад?



Ахуйн жинлүүр  
Даац: 3 кг-аас 5 кг



Гар жинлүүр  
Даац: 1 кг-аас  
10 кг

**431** Элсэн чихэр, гурилын хүндийн хэмжээг бичээрэй.



Хүндийн хэмжээг заадаг заагч,  
хуваарьтай багаж байдаг.

**432** Хэмжих хэрэгслийг хэрэглэхдээ юуг анхаарах хэрэгтэй вэ? Хэмжихийн өмнө заагч нь ямар байх ёстой вэ? Хуваарийг яаж унших вэ?

Жинлүүр хэрэглэхдээ анхаарах зүйл:

1. Жинлүүрийг тэгш хавтгай гадаргуу дээр байрлуулна.
2. Заагч 0 хуваарийг зааж байгаа эсэхийг харна.
3. Заагчийн зааж буй хуваарийг харна.
4. Даацаас нь хэтэрсэн зүйл хэмжиж болохгүй.


Гар жинлүүрийн хувьд 2-оос 4 дүгээр алхмыг анхаараарай.



**433** Ном, цүнх, тарвасын хүндийг хэмжжээ. Хэмжээг бичээрэй.



Хүндийг хэмжих “грамм” гэдэг нэгж байдаг. Товчоор “г” гэж тэмдэглэдэг.



0-ээс 250 г хүртэлх хэсэг нь хуваариар 5 тэнцүү хэсэгт хуваагджээ.  $250 \div 5 = 50$  (г). Хоёр хуваарийн хоорондох хэсэг нь 50 г юм байна. Заагч 3 дахь хуваарь буюу 150 г-ыг зааж байна. Номын хүндийн хэмжээ 150 г байна.



**434**



1 килограмм, 1 грамм хэмжээг харьцуулъя

Элс, эсвэл будаа, 1 г, 1 кг хүндийг хэмжих жинлүүр, уут бэлтгэнэ.

- а. Нэг уутанд баримжаагаар 1 кг, нөгөө уутанд 1 г элс хийгээрэй.
- б. Хэмжих хэрэгслээр элстэй уутын хүндийг хэмжиж шалгаарай. Хэмжээг 1 кг, 1 г болгохын тулд ямар үйлдэл хийсэн бэ? Ярилцаарай.
- в. 1 кг ба 1 г элсийг өргөж, хүндийн хэмжээг харьцуулаарай.

**435**

Ажиглаад, ярилцаарай.



Килограмм нь хүндийг хэмжих үндсэн нэгж юм.


**Хүндийг хэмжих нэгж:** тонн (т),  
центнер (ц)  
килограмм (кг)  
грамм (г)  
миллиграмм (мг)

**Хүндийн нэгжүүдийн хамаарал:**  
 $1 \text{ т} = 10 \text{ ц} = 1000 \text{ кг}$   
 $1 \text{ ц} = 100 \text{ кг}$   
 $1 \text{ кг} = 1000 \text{ г}$   
 $1 \text{ г} = 1000 \text{ мг}$

**436**

Нэг шуудай гурилын хүндийн хэмжээ 20 кг байв. Хэдэн шуудай гурилын хүндийн хэмжээ 1 ц, 1 т болох вэ?

**437** Юмсын хүндийг хэмжих багаж хэрэгсэлтэй танилцъя.



**Жишээ 1** Хэмжих нэгжийг хэрхэн шилжүүлснийг тайлбарлаарай.

- а.  $6 \text{ т} = (6 \times 10) \text{ ц} = 60 \text{ ц}$       г.  $80 \text{ ц} = (80 \div 10) \text{ т} = 8 \text{ т}$   
 б.  $2 \text{ ц} = (2 \times 100) \text{ кг} = 200 \text{ кг}$       д.  $400 \text{ кг} = (400 \div 100) \text{ ц} = 4 \text{ ц}$   
 в.  $3 \text{ кг} = (3 \times 1000) \text{ г} = 3000 \text{ г}$       е.  $5000 \text{ кг} = (5000 \div 1000) \text{ т} = 5 \text{ т}$

**438** Тохирох тоог олж бичээрэй.

- а.  $7 \text{ ц} = \square \text{ кг}$       в.  $9 \text{ г} = \square \text{ мг}$       д.  $2300 \text{ кг} = \square \text{ ц}$       ж.  $7000 \text{ г} = \square \text{ кг}$   
 б.  $12 \text{ т} = \square \text{ ц}$       г.  $8000 \text{ мг} = \square \text{ г}$       е.  $580 \text{ ц} = \square \text{ т}$       з.  $10 \text{ кг} = \square \text{ г}$

**Жишээ 2** Хэмжих нэгжийг хэрхэн шилжүүлснийг тайлбарлаарай.

- а.  $2 \text{ кг } 300 \text{ г} = 2 \text{ кг} + 300 \text{ г} = (2 \times 1000) \text{ г} + 300 \text{ г} = 2300 \text{ г}$   
 б.  $2400 \text{ г} = 2000 \text{ г} + 400 \text{ г} = (2000 \div 1000) \text{ кг} + 400 \text{ г} = 2 \text{ кг} + 400 \text{ г} = 2 \text{ кг } 400 \text{ г}$

**439** Өгсөн нэгжээр илэрхийлж бичээрэй.

- а.  $3 \text{ кг } 20 \text{ г} = \square \text{ г}$       в.  $2 \text{ г } 500 \text{ мг} = \square \text{ мг}$       д.  $4 \text{ т } 5 \text{ ц} = \square \text{ ц}$   
 б.  $2500 \text{ г} = \square \text{ кг } \square \text{ г}$       г.  $240 \text{ кг} = \square \text{ ц } \square \text{ г}$       е.  $6700 \text{ кг} = \square \text{ т } \square \text{ кг}$

**440** Жишээрэй.

- а.  $8 \text{ кг } 500 \text{ г} \square 8 \text{ кг } 501 \text{ г}$       в.  $2 \text{ т } \square 20 \text{ ц}$       д.  $4 \text{ ц } 80 \text{ кг} \square 479 \text{ кг}$   
 б.  $3200 \text{ г} \square 3 \text{ кг } 20 \text{ г}$       г.  $7 \text{ г } 100 \text{ мг} \square 7010 \text{ мг}$       е.  $1 \text{ т } 30 \text{ кг} \square 1 \text{ т } 3 \text{ ц}$

**Жишээ 3** Бодолтыг тайлбарлаарай.

$$\begin{array}{r}
 + 2500 \\
 \hline
 + 1800 \\
 \hline
 4300
 \end{array}
 \quad
 \begin{array}{r}
 + 2 \text{ кг } 500 \text{ г} \\
 \hline
 + 1 \text{ кг } 800 \text{ г} \\
 \hline
 4 \text{ кг } 300 \text{ г}
 \end{array}
 \quad
 \begin{array}{r}
 - 2500 \\
 \hline
 - 1800 \\
 \hline
 700
 \end{array}
 \quad
 \begin{array}{r}
 - 2 \text{ кг } 500 \text{ г} \\
 \hline
 - 1 \text{ кг } 800 \text{ г} \\
 \hline
 700 \text{ г}
 \end{array}
 \quad
 \begin{array}{r}
 \times 974 \\
 \hline
 \times 6 \\
 \hline
 5844
 \end{array}
 \quad
 \begin{array}{r}
 \times 974 \text{ г} \\
 \hline
 \times 6 \\
 \hline
 5844 \text{ г}
 \end{array}$$

$$296 \text{ кг} \div 8 = 37 \text{ кг}$$

2	9	6	8
-	2	4	3
		5	6
		-	5
			6
			0

**441** Бодоод, тайлбарлаарай.

- а.  $34 \text{ кг} + 91 \text{ кг}$       в.  $5700 \text{ г} + 2900 \text{ г}$       д.  $3 \text{ кг } 200 \text{ г} + 1 \text{ кг } 600 \text{ г}$   
 б.  $3 \text{ кг } 200 \text{ г} - 1 \text{ кг } 600 \text{ г}$       г.  $3 \text{ ц } 58 \text{ кг} \times 9$       е.  $4 \text{ кг } 581 \text{ г} \div 9$



## БАТАТГАХ

**442** Хэмжээг бичээрэй.



**443** Хүний бие, суудлын машин, цүнх, бөмбөг, баллуур, үзэг, 1 ширхэг цагаан будааны хүндийн хэмжээг ямар нэгж, хэрэгслээр хэмжих вэ?

**444** Хэмжээнүүдийг өсөх эрэмбээр бичээрэй. Хамгийн их ба бага хэмжээний зөрөөг олоорой. Хэмжээнүүдийг тонноор тоймлоорой.

а. 2000 кг, 2 т 3 ц, 47 ц    б. 8 кг 65 г, 9 ц 76 кг, 9472 г    в. 1 т 368 кг, 14 ц, 1 т

**445** Хэмжээнүүдийг буурах эрэмбээр бичээрэй. Хэмжээнүүдийг килограммаар тоймлоорой. Хэмжээ бүр дээр хэдийг нэмэхэд 10 кг болох вэ?

а. 3 кг 350 г, 3020 г, 3750 г    б. 4 кг 832 г, 4160 г, 3980 г, 5 кг 90 г

**446** Ангийн 5 сурагчийн хүндийн хэмжээг бичээрэй.

а. Сурагчдын хүндийн хэмжээг баганан диаграммаар дүрслээрэй.

б. Хамгийн их болон хамгийн бага хэмжээний зөрөөг олоорой.

**447** Таны хичээлдээ авч явдаг цүнх хэр хүнд вэ? Цүнх, түүний доторх юмсын хүндийг хэмжээрэй. Сургуульд хэрэг болохгүй ямар юмс цүнхэнд байна вэ? Тэдгээрийг хасвал цүнхний хүндийн хэмжээ хэдээр багасах вэ?

**448** Хүү 3 жимсний хүндийг хэмжихэд алим 266 г, жүрж түүнээс 72 г-аар бага байв. Гадилын хүндийн хэмжээ жүрж ба алимн хагастай тэнцэв. Жимсний хүндийн хэмжээг баганан диаграммаар дүрслээрэй.

**449** Бодоод, тайлбарлаарай.

а. Цэцэгээ 2 кг 400 г төмс, 500 г лууван авав. Авсан лууван, төмсний хүндийн хэмжээний зөрөөг олоорой. Ногооны хүндийн нийт хэмжээг олоорой.



б. Ногоочин 237 кг улаан лооль хураажээ. Улаан лоолийг 6 кг-аар савлахад хэдэн хайрцаг хэрэгтэй вэ? Тэр хэдэн хайрцгийг дүүргэсэн бэ?

**450**




Хуваарьгүй жинлүүр ба 100 г, 300 г, 900 г-ын туухайгаар хүндийн хэмжээ нь ямар байх зүйлсийг хэмжиж болох вэ?

Жишээ:



400 г



200 г

**451**




Хэмжээнүүдийг жишээрэй. Нийлбэр, ялгаврын утгыг олоорой.

а. 3 кг 750 г ба 5600 г    б. 3 ц 70 кг ба 290 кг    в. 2 т 894 кг + 1247 кг



## БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨНИЙГ ТОГТООХ



Юмсын байршил заасан зургийг өмнө харж байсан уу? Яаж уншдаг вэ?  
Шатар, даам, тоглоомын хөлгийн үсэг, тоонууд юуг илэрхийлж байгаа вэ?

**452** Цагийн зүү аль чиглэлд эргэдэг билээ?


“Цагийн зүүний дагуу эргэх”, “цагийн зүүний эсрэг чиглэлд эргэх” гэдгийг хэрхэн ойлгож байгаагаа тайлбарлаарай.



**453** Зүг чигийг заах тэмдэгт ямар үгсийг үсгүүдээр товчилсон байна вэ?

а. Хүү тэмдэгт заасан баруун зүг уруу харж зогсов. Тэр цагийн зүүний эсрэг 2 удаа тэгш өнцгөөр эргэвэл аль зүг уруу харж зогсох вэ?


б. Охин өмнө зүг уруу харж зогсов. Цагийн зүүний дагуу 3, цагийн зүүний эсрэг 1 удаа тэгш өнцгөөр эргэвэл тэр аль зүг уруу харж зогсох вэ?



**454** Хүснэгтийн аль нүдэнд ямар тоо байхыг олж бичээрэй.

8 мянгат 3 зуут 5 нэгж	$4000 + 500 + 90 + 2$	16 зуут 13 аравт 9 нэгж
800-аас их, хамгийн бага 3 оронтой тоо	2800-г 10000 хүртэл гүйцээх тоо	5-д хуваагдах, хамгийн их дөрвөн оронтой тэгш тоо
$739 \times 8$	$3908 \div 4 + 7265$	$4829 + 4290 - 1925$

**455** Туулай -ий талын дагуу харайсаар лууванд хүрэхийг хүслээ.




Туулайд туслан лууванд хүрэх дөт замыг олж бичээрэй.

Туулай зүүн зүг уруу бүгд хэд харайх вэ?

Тэр өмнө зүг уруу бүгд хэд харайх вэ? Тэр хойд зүг уруу харайх уу?

456

Зурагт дүрсэлсэн газруудын байршлыг хүснэгтэд бичээрэй.



Газрын нэр	Цэнгэлдэх хүрээлэн	Сургууль	Дэлгүүр	Хотхон	Соёлын ордон	Тоглоомын талбай
Байршил	В5					

- ЖЗ-д цэцэрлэг, А5-д музей байрлана. Зургийн хаана “цэцэрлэг”, “музей” гэж бичих вэ?
- Байршил тогтооход мөр, баганын дугаарын алийг эхэлж хэлэх вэ?

457



Гэрээсээ сургууль хүрэх замд хаана юу байдаг вэ?

Тэдгээрийг дүрслэхэд хэдэн мөр, баганатай хүснэгт зурах вэ?

Хүснэгтэд гэрээс сургууль хүртэлх замд байрладаг барилга, газруудаас сонгон дүрслээрэй. Газар бүр ямар байршилд байгааг бичээрэй. Хаана ямар аюул учирч болох вэ? Хаагуур явах нь илүү аюулгүй вэ? Яагаад?

458

★ таван хошууг ГЗ байрлалаас Е2 байрлалд хэрхэн шилжүүлэх вэ?

Дараах хариултууд зөв үү? Яагаад?



- Зүүн гар тийш 1 нүд, доош 2 нүд
- Баруун гар тийш 1 нүд, доош 2 нүд
- Зүүн гар тийш 2 нүд, доош 1 нүд
- Баруун гар тийш 2 нүд, доош 1 нүд



459




а. Дүрсийн байршлыг хүснэгтэд бичээрэй.



- ♥-ийг баруун, зүүн, доош гэсэн хөдөлгөөнөөр В1 нүдэнд хэрхэн шилжүүлэхийг бичээрэй.

## БАТАТГАХ

**460** Зааврын дагуу ажиллаарай.



а. Дүрсийг ангилж, байршлыг бичээрэй.

Зургаан өнцөгт	(3,2)
Дөрвөн өнцөгт	
Таван өнцөгт	
Биет	

б. (7,2), (3,4), (2,5) нүдэнд ямар дүрс байна вэ?

- в. Дугуйг баруун гар тийш 2, дээш 1 нүд шилжүүлэн байршлыг бичээрэй. Гурвалжныг зүүн гар тийш 1, доош 4 нүд шилжүүлж байршлыг бичээрэй. Дөрвөн өнцөгт бүрийг (6,5) нүдэнд хэрхэн шилжүүлэхийг бичээрэй.
- г. Үүнтэй адил зааврыг ангийн найздаа өгөөрэй. Найзынхаа хэлсэн зааврыг биелүүлээрэй.

**461**



Орчноо дүрсэлье

а. Дэвтэртээ хүснэгт зураад, мөр, баганаа дугаарлаарай.

Гэрийнхээ орчны зам, байшин, тоглоомын талбайг дүрслээрэй.


Гэрийнхээ хаана тогловол илүү аюулгүй вэ? Байршлыг бичээрэй.

б. Сургуулийнхаа орчинд байдаг зам, байшин барилга, газруудыг дүрслээрэй. Газруудын байршлыг бичээрэй.

Сурагчид хаана тоглодог вэ? Зурагт дүрслээд, байршлыг бичээрэй.

**462** Хүснэгтийг дэвтэртээ зураарай.

- а. Тэгш хэмтэй дүрсийг гүйцээж будаарай.
- б. Будсан нүд бүрийн байршил, өнгийг бичээрэй.
- в. Ижил өнгөтэй нүднүүдийн эзлэх талбайн хэмжээг олж бичээрэй.
- г. Адил даалгаврыг зохиогоорой.



**463** Адил хоосон хүснэгтийг дэвтэртээ зураарай. Хүснэгтийн аль нүдэнд ямар тоо байхыг олж бичээрэй. Тооны хүснэгт дэх байршлыг бичээрэй.

3	4 мянгат 16 аравт 1 нэгж	$5000 + 70 + 8$	1 зуут 25 аравт 4 нэгж
2	$560 \times 9$	Хамгийн их 4 оронтой тоо	$5149 - 1750 \div 5$
1	$2750 + 399 \times 8$	$3208 \div 8 + 5099$	$5607 + (5110 - 2915)$
	1	2	3

## АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ

**464** Сувдаа 9 цагаас эхлэн 50 минутын турш хичээлээ давтав. Хэдэн цаг хэдэн минутад хичээлээ хийж дууссан бэ?

**465** Сурагч орой 10 цагт унтаад, өглөөний 7 цагт босов. Тэр хэдэн цаг унтсан бэ?

**466** Туяа хичээлээ тарж ирээд, 5 минутад гараа угаан, 20 минут цай уув. Цай ууж дуусаад цаг харахад 14:20 болж байсан бол хэдэн цагт гэртээ ирсэн бэ?

**467** Тэмүүжин сургууль хүртлээ 12 минут явдаг. Хэрэв 8:00 цагт сургуульдаа очих байсан бол гэрээсээ хэдэн цаг хэдэн минутад гарах ёстой вэ?

**468** Бодлого зохиож, бодоорой. Мэдэгдэхгүй байгаа тоо, хэмжээг яаж олсон бэ?

а.

Үржигдэхүүн	Үржигдэхүүн	Үржвэрийн утга
546	8	?
?	3	612
4	?	2008

в.

Урт (см)	Өргөн (см)	Талбайн хэмжээ (см.кв)
20	4	?
?	6	72
9	?	63

б.

Нэгж хугацаанд явсан зам	Хугацаа	Нийт зам
60 км	7 цаг	? км
5 км	? цаг	80 км
? м	5 с	95 м

г.

Нэгж хугацаанд хийх ажил	Хугацаа	Нийт ажил
15 сандал	4 цаг	?
10 шүр	? минут	120 шүр
?	5 өдөр	20 ширээ

д.

Нэг бүрийн үнэ (₮)	Тоо хэмжээ	Нийт үнэ (₮)
1600	6 м	?
?	8 кг	7200
1000	? ширхэг	10000

Эдгээрийг бодох арга юугаараа ижил байна вэ?

Бодлогуудад юу нь ялгаатай байна вэ?

**469** Хоёр хотын хоорондох зай 270 км. Машин энэ замыг 6 цагт явж туулсан бол цаг тутам хэдэн километр явсан бэ?

**470** Машин эхний 3 цагт, цаг тутам 80 км явав. Дараагийн 3 цагт, цаг тутам 75 км явсан бол бүгд хэдэн километр зам явсан бэ?

**471** Нисдэг тэрэг цагт 280 км зам туулдаг. 8 цагт хэдэн километр зам туулах вэ?

**472** Бат, Болд цанаар гулгаж тоглов. Бат 20 секундэд 80 м, Болд 30 секундэд 90 м газар гулгажээ. Нэгж хугацаанд хэн нь илүү хол гулгаж байсан бэ?

**473** Анар, Сувдаа хоёр цаасан шувуу нугалав. Анар 5 минутад 10, Сувдаа 4 минутад 12 ширхэг цаасан шувуу нугалсан бол хэн нь хурдан нугалсан бэ?

**474** Тэгш өнцөгт хэлбэртэй зураг 9 см урттай. Зургийн талбайн хэмжээ 54 см.кв. Зургийн хүрээний уртыг олоорой.

- 475** Худалдааны тооцоо хийгээрэй. Эхлээд нэг бүрийн үнэ хэдэн төгрөг байгааг судалж мэдээрэй. (₮ нь төгрөг)

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (₮)	Нийт үнэ (₮)
Гурил	кг	1		
Будаа	кг	1		
Талх	ширхэг	2		
Нийт үнэ				

- 476** Дараах бодлого тус бүрийг уншаад ямар өгөгдөл дутуу байгааг хэлээрэй. Өгөгдлийг гүйцээж, асуултад хариулаарай.
- а. 3 килограмм төмс авав. Худалдагчид хэдэн төгрөг төлсөн бэ?
- б. Эмээ . . . ширхэг талх авав. 1 талх 900 төгрөгийн үнэтэй бол эмээ хэдэн төгрөг төлсөн бэ?

- 477** Бодлого зохиож бодоорой. Яаж бодсоноо тайлбарлаарай.

Барааны нэр	Нэг бүрийн үнэ (₮)	Тоо хэмжээ (ширхэг)	Нийт үнэ (₮)
Жигнэмэг	300	2	?
Бохь	?	5	250
Шоколад	500	?	500
Баллуур	200	?	400
Харандаа	?	2	800
Бичгийн цаас	?	8	400
Өнгийн цаас	?	4	200

- 478** Ээж алим, лийр тус бүр 1 кг-ыг худалдан авав. Лийр 1 кг нь 5640 төгрөг, алим нь лийрээс 2 дахин бага үнэтэй байв. Ээж бүгд хэдэн төгрөг төлсөн бэ?
- 479** “Гоё” ундаа 700 төгрөг, “Цэвэр ус” 350 төгрөг, “Алимн шүүс” 650 төгрөгийн үнэтэй. Сурагчид аяллаар явахдаа 4 ширхэг “Гоё” ундаа, 6 ширхэг “Алимн шүүс”, 8 ширхэг “Цэвэр ус” худалдан авсан бол бүгд хэдэн төгрөг төлсөн бэ?
- 480** Жигнэмэг 250 төгрөг, ууттай самар жигнэмгээс 4 дахин илүү үнэтэй. Ууттай үзэм самраас 5 дахин хямд байсан бол тус бүрийн үнийг олоорой.
- 481** Сурагчдын үдийн цайнд нэг сурагчид 150 төгрөгийн чацарганын ундаа, 250 төгрөгийн жигнэмэг өгөв. 10 сурагчтай, мөн 20 сурагчтай анги тус бүр 1 өдөр үдийн цайнд хэдэн төгрөг зарцуулах вэ?
- 482** Мухлагт тус бүр нь 12 кг жинтэй 5 хайрцаг алим, бас 3 хайрцаг үзэм оруулав. Мухлагт оруулсан алим ба үзмийн бүх жин 90 кг байсан бол хайрцаг үзэм ямар жинтэй вэ?
- 483** Дэлгүүрт 960 ширхэг дэвтэр, дэвтрээс 4 дахин олон үзэг байв. Бүгд нийлээд хэдэн дэвтэр, үзэг байна вэ? Дэвтэр үзгээс хэдээр олон бэ?

## БОЛОМЖИЙН ТОО ОЛОХ

- 484** Өгсөн тоонуудыг ангилаарай. А, Б, В, Г нүдэнд байгаа тоонууд ямар шинжтэй байна вэ? Дараах модны загварыг ажиглаад, бодоорой. Хэрхэн бодсоноо ярилцаарай.

Модны загвараар юмсыг ангилахаас гадна боломжийг тоолж болно.

- 485** Ямар боломж байгааг бичээрэй.
- Зоос орхиход хэдэн янзаар буух боломжтой вэ?
  - Шоо орхиход хэдэн янзаар буух боломжтой вэ?

- 486** Нэг мөнгийг хоёр удаа орхиж, хэчнээн янзаар буух боломжтойг тоолъё. Буух боломжуудыг хүснэгтэд тэмдэглэв. Сүлдээр буусныг С, тоогоор буусныг Т үсгээр тэмдэглэв.

Туршилт	1	2	3	4
Нэгдүгээр орхилт				
Хоёрдугаар орхилт				

Мөчир

Мод

Т

С

Т модноос Т, С мөчир гарна.  
С модноос Т, С мөчир гарна.

Модны тоо - 2  
Мөчрийн тоо - 2  
Нийт боломжийн тоо  $2 \times 2 = 4$

Тоо дараа нь сүлдээр буух нь эхлээд сүлд дараа нь тоогоор буухаас ялгаатай. Иймд ТТ, ТС, СТ, СС гэсэн дөрвөн боломжтой байна.



- 487** Сурагч гэрээсээ сургууль хүртэл гурван ялгаатай замаар, сургуулиас номын сан хүртэл хоёр ялгаатай замаар очих боломжтой. Сурагч гэрээсээ сургууль, сургуулиас номын сан хүртэл хэчнээн ялгаатай замаар очих боломжтой вэ?

- 488** Зурагт үзүүлсэн дүрсэд хэчнээн ялгаатай гурвалжин байгааг хүснэгт хэрэглэн бүртгээрэй.



Гурвалжны тоо	1	2	3
Нийт гурвалжны тоо			
Бүгд			


**489** Сургуулийн цайны газарт үзэмний, алимын, нэрсний, чацарганын ундаа, ногоотой шөл, шоштой бууз, ороомог байв. Хүүхэд уух зүйл ба хоолыг хэдэн янзаар сонгон авч болох вэ?

УНДАА	ХООЛ
1. Алимын	1. Ногоотой шөл
2. Нэрсний	2. Шоштой бууз
3. Чацарганын	3. Ороомог
4. Үзэмний	4. <del>Цуйван</del>



**490** Туяа цагаан, цэнхэр өнгийн 2 цамц, хар, хөх, ногоон өнгийн 3 өмдтэй. Тэр хэдэн янзаар цамц, өмдөө хослуулан өмсөж болох вэ?


**491** Хүүхэлдэйг 3 өнгөөр хэдэн янзаар будаж болох вэ?



**492** Амар, Болд, Туяа, Чимгээ нар эгнэн зогсож зураг авахуулав. Хэдэн янзаар зогсох боломжтой вэ? Модны загвараар бодоорой.

**493** Уутанд 6 улаан, 1 шар бөмбөг байжээ. Уутнаас харахгүйгээр 1 бөмбөг авав.  
 а. Улаан бөмбөг гарч ирэх боломжийн тоо хэд вэ?  
 б. Шар бөмбөг гарч ирэх боломжийн тоо хэд вэ?  
 в. Ямар өнгийн бөмбөг гарч ирэх боломж их вэ?

**494** Уутанд 9 цэнхэр, 4 ногоон, 1 шар бөмбөг байв. Уутнаас харахгүйгээр 1 бөмбөг авчээ. Ямар өнгийн бөмбөг гарч ирэх нь хамгийн бага боломжтой вэ? Ямар өнгийн бөмбөг гарч ирэх нь хамгийн их боломжтой вэ?

**495**  цифрээр хоёр оронтой тоо хэдийг зохиож болох вэ? Дараах хоёр бодолтыг ажиглаарай. Цифр давтагдах, давтагдахгүй байх үед бодолт ямар ялгаатайг ярилцаарай.

**а. Цифр давтагдахгүй**

7	5	1
/ \	/ \	/ \
5 1	7 1	7 5
75 71	56 51	17 15

модны тоо 3,  
 мод бүрийн мөчрийн тоо 2  
 нийт боломжийн тоо  $3 \times 2 = 6$

**б. Цифр давтагдах**


7	5	1
/ \ /	/ \ /	/ \ /
7 5 1	7 5 1	7 5 1
77 75 71	57 55 51	17 15 11

модны тоо 3,  
 мод бүрийн мөчрийн тоо 3  
 нийт боломжийн тоо  $3 \times 3 = 9$

**496** 1, 7, 4 цифрээр хоёр оронтой тэгш тоо хэдийг зохиож болох вэ?

**497** 2, 0, 3, 7 цифрээр хоёр оронтой сондгой тоо хэдийг зохиож болох вэ?


**498** Өгсөн тоонуудыг шинжээр нь ялган хүснэгтийн нүдэнд бичээрэй. Нэг нүдэнд байгаа тоонууд ямар зүй тогтолтой байна вэ? Ажиглаад үргэлжлүүлээрэй.



	3-д хуваагддаг	5-д хуваагддаг
30-аас бага		
30-аас бага биш		

**499** Зурагт дартсын самбарыг үзүүлжээ.

- а. Дартсын 3 сумаар 10 оноо хэрхэн авч болох вэ?
  - б. Дартсын 4 сумаар 20 оноо хэрхэн авч болох вэ?
- Нийлбэр илэрхийлэл бичиж болно.




**500** Тоон дарааллын зүй тогтлыг олоод, үргэлжлүүлээрэй.

- а. 8, 21, 34, 47, ..., ..., ..., ...
- б. 256, 128, 64, 32, ..., ..., ..., ...
- в. 1, 3, 7, 15, ..., ..., ..., ...

**501** Мөр, багана, сумын дагуу нийлбэр 20 байх хос /зэрэгцээ/ тоог дугуйлан тэмдэглэнэ үү.

4	7	1	19	10	11
16	12	10	13	8	9
3	10	0	16	6	14
5	4	2	9	12	10
3	17	15	18	5	8
3	7	13	1	15	2

**502** Гурвалжны талууд дахь тоонуудын нийлбэр 100 байхаар 10, 20, 50, 60 тоонуудыг байрлуулаарай.



**503** Өгсөн цифрүүдээс сонгон дараах тоонуудыг зохиогоорой.



- а. 200-аас их, хамгийн бага 3 оронтой тоо
- б. 4500-аас их, хамгийн бага 4 оронтой тоо
- в. 7000-аас бага, бүх цифр нь тэгш байх хамгийн их дөрвөн оронтой тоо



## БАТАТГАХ

504



Тоог таая.

Орон, ангийн хүснэгт, дэвтэр, үзэг бэлтгэнэ.

Халиун, Номин хоёрын хэрхэн тоглосныг ажиглаарай.

а. Тэд 1, 2, 3, 4 цифрийг сонгоод, тус бүрдээ дөрвөн оронтой тоо зохиов. Халиун зохиосон тоо 1243-ыг орон, ангийн хүснэгтэд бичжээ.

б. Номин 2314 гэсэн тоо зохиож, Халиунаар таалгав. Номин: “Миний зохиосон тооны:

- мянгат нь чиний тооны мянгатаас их
- зуут нь чиний тооны зуутаас их
- аравт нь чинийхээс бага
- нэгж нь чинийхээс их” гэж хэлжээ.

мянгат	зуут	аравт	нэгж
1	2	4	3

в. Халиун Номингийн зохиосон тоо 2134 болохыг хэлж, хүснэгтэд бичив.

г. Номин Халиуны буруу олсон цифрийг дугуйлж, ямар алдаа гаргасныг асуув.

мянгат	зуут	аравт	нэгж
1	2	4	3
2	1	3	4

Халиун: “Чиний тооны зуут минийхээс их, харин нэгж нь минийхээс бага байсныг буруу тооцоолжээ.” гэлээ.

Тоглоомын дүрмийн талаар ярилцаад, хосоороо тоглож үзээрэй.

505

Гэрт цагаан, бор өнгийн 2 малгай, хар, шар, саарал өнгийн 3 ороолт байв. Малгай, ороолтыг хэдэн янзаар хослуулан өмсөж болох вэ?

506

Хайрцаг дахь харандаанаас харахгүйгээр нэгийг авах хэдэн боломж байгаа вэ? Ямар өнгийн харандаа гарч ирэх боломж хамгийн бага вэ? Яагаад?

а. Хайрцагт 10 ногоон, 2 улаан харандаа байв.

б. Хайрцагт 7 цэнхэр, 5 шар, 1 ногоон харандаа байв.

507



цифрүүдээр а. Цифр давтагдах, б. Цифр давтагдахгүй гурван оронтой тоо бичих болов.

Гурван оронтой тоо бичих нийт хэдэн боломж байгаа вэ?

2-т хуваагдах тоо үүсэх хэдэн боломж байгаа вэ?

5-д хуваагдах тоо үүсэх хэдэн боломж байгаа вэ?

508



1) Хайрцагт 8 цэнхэр, 3 ногоон харандаа байжээ. Хайрцагаас харахгүйгээр нэг харандаа авав. Ямар өнгийн харандаа гарч ирэх боломж их вэ? Яагаад?

2) 5, 2, 0, 4 цифрээр хоёр оронтой тэгш тоо хэдийг зохиож болох вэ?

## ЭЗЛЭХҮҮНИЙГ ХЭМЖИХ



Хоёр хүүхэд дэлгүүрээс ижил багтаамжтай хувин авчээ. Тэд хувингийнхаа багтаамжийг олохоор ундааны саваар ус хийж хувингаа дүүргэв.



Би ундааны саваараа  
9 удаа ус хийхэд хувин  
дүүрсэн.



Би ундааны саваараа  
6 удаа ус хийхэд хувин  
дүүрсэн.




9 ба 6-ийн аль нь хувингийн багтаамжийг илэрхийлэх вэ?

Хэмжилт хийхэд хэрэглэсэн савны багтаамжаас хамаарч хувингийн багтаамж өөр гарчээ. Иймд ямар нэгжээр хэмжсэнээ тооны ард бичих хэрэгтэй.



**509** Шингэнийг хэмжих ямар нэгж, хэрэгсэл байдаг талаар ярилцаарай.



Бага хэмжээтэй шингэнийг “миллилитр”-ээр хэмждэг. Жишээлбэл, аяганы багтаамж, тарианы хэмжээ гэх мэт.



**510** 1 литрийн багтаамжтай ямар сав мэдэх вэ?



Шингэнийг хэмжих нэгж:  
литр (л), миллилитр (мл)  
 $1 \text{ л} = 1000 \text{ мл}$


Литр нь шингэнийг  
хэмждэг үндсэн нэгж юм.




- 511** Савны багтаамжийг 1 литрийн багтаамжтай саваар  $1 \text{ л}$  хэмжин дүрслэв. Сав бүрийн багтаамжийн хэмжээг багаас их рүү бичээрэй.



- 512** Шингэний эзлэхүүний хэмжээг бичээрэй.



- 513** Шингэний хэмжээг литр, миллилитрээр илэрхийлэн бичээрэй. Жишээ: Зураг **б.**-д  $2 \text{ л } 700 \text{ мл}$  хэмжээтэй шингэн байна.



Сав бүрд  $500 \text{ мл}$  шингэн нэмбэл эзлэхүүний хэмжээ ямар болох вэ?

- Жишээ 1** Хэмжих нэгжийг хэрхэн шилжүүлснийг тайлбарлаарай.

- а.  $2 \text{ л} = (2 \times 1000) \text{ мл} = 2000 \text{ мл}$ ,      б.  $7000 \text{ мл} = (7000 \div 1000) \text{ л} = 7 \text{ л}$   
 в.  $2 \text{ л } 350 \text{ мл} = 2 \text{ л} + 350 \text{ мл} = 2000 \text{ мл} + 350 \text{ мл} = 2350 \text{ мл}$   
 г.  $7480 \text{ мл} = 7000 \text{ мл} + 480 \text{ мл} = 7 \text{ л} + 480 \text{ мл} = 7 \text{ л } 480 \text{ мл}$

- 514** Тохирох тоог олж бичээрэй.

- а.  $3 \text{ л} = \square \text{ мл}$       г.  $2000 \text{ мл} = \square \text{ л}$       ж.  $1 \text{ л } 670 \text{ мл} = \square \text{ мл}$   
 б.  $8 \text{ л} = \square \text{ мл}$       д.  $6000 \text{ мл} = \square \text{ л}$       з.  $9 \text{ л } 051 \text{ мл} = \square \text{ мл}$   
 в.  $5 \text{ л} = \square \text{ мл}$       е.  $10000 \text{ мл} = \square \text{ л}$       и.  $3 \text{ л } 859 \text{ мл} = \square \text{ мл}$

**515** Тохирох тоог олж бичээрэй.

- а. 4500 мл =  л  мл    в. 9023 мл =  л  мл    д. 1003 мл =  л  мл  
б. 5470 мл =  л  мл    г. 6142 мл =  л  мл    е. 7529 мл =  л  мл

**516** Ихээс бага уруу эрэмбэлээрэй.

- а. 1700 мл, 6040 мл, 4630 мл                      г. 1329 мл, 8100 мл, 6788 мл, 678 мл  
б. 3 л 25 мл, 4 л 20 мл, 3 л 40 мл            д. 3 л 635 мл, 2 л 950 мл, 4 л 900 мл  
в. 3 л 250 мл, 3750 мл, 3 л 200 мл        е. 2 л 635 мл, 4 л 560 мл, 5020 мл

**Жишээ 2** Бодолтыг тайлбарлаарай.

$$291 \text{ л} \div 3 = 97 \text{ л}$$

$\begin{array}{r} + 5830 \\ + 2290 \\ \hline 8120 \end{array}$	$\begin{array}{r} + 5 \text{ л } 830 \text{ мл} \\ + 2 \text{ л } 290 \text{ мл} \\ \hline 8 \text{ л } 120 \text{ мл} \end{array}$	$\begin{array}{r} - 6100 \\ - 3250 \\ \hline 2850 \end{array}$	$\begin{array}{r} - 6 \text{ л } 100 \text{ мл} \\ - 3 \text{ л } 250 \text{ мл} \\ \hline 2 \text{ л } 850 \text{ мл} \end{array}$	$\begin{array}{r} \times 1732 \\ \times 4 \\ \hline 6928 \end{array}$	$\begin{array}{r} \times 1 \text{ л } 732 \text{ мл} \\ \times 4 \\ \hline 6 \text{ л } 928 \text{ мл} \end{array}$
--	---	--	---	---	---

-	2	9	1	3	
	2	7		9	7
		-	2	1	
			-	2	1
					0

**517** Бодоод тайлбарлаарай.

- а. 1300 мл + 500 мл                      д. 6 л 200 мл – 2 л 950 мл                      и. 1 л 223 мл × 3  
б. 1800 мл – 600 мл                      е. 5400 мл + 1 л 750 мл                      к. 1 л 685 мл × 5  
в. 3718 мл + 4 л 562 мл                      ж. 3 л 150 мл – 1569 мл                      л. 726 мл ÷ 6  
г. 7 л 650 мл + 1 л 49 мл                      з. 379 мл × 5                      м. 1 л 428 мл ÷ 4

**518**



Миллилитрээр хэмжье.

- а. Баг бүр хоосон ба устай 2 цаасан аяга, янз бүрийн хэмжээтэй зүүгүй тариур бэлтгэнэ.  
б. Сурагчид цаасан аяган дахь уснаас тариурт 5 удаа соруулж, хоосон аяганд хийнэ.  
в. Тариураар юүлсэн усны хэмжээг тооцоолно.

*Жишээ:*

Туяа тариураар 3 мл, 2 мл, 3 мл, 3 мл, 1 мл хэмжээтэй усыг тус тус юүлжээ.

Туяа нийт 12 мл ус юүлсэн байна.

**519** Саванд 18 л ус байв. Усыг дараах хэмжээтэй хэдэн саванд суллах вэ?

- а. 2 л            б. 3 л            в. 6 л            г. 9 л            д. 10 л            е. 2 л ба 3 л

**520** Нэг дэх саванд 2 л 150 мл, хоёр дахь саванд нэг дэхээс 1 л 670 мл-ээр илүү цай байв. Хоёр саван дахь цайны нийт хэмжээг олоорой.

**521**




1) Хэмжээг олоорой.

- а. 6 л 487 мл + 3296 мл                      в. 1 л 350 мл × 4  
б. 4 л 230 мл – 1 л 680 мл                      г. 1 л 320 мл ÷ 6

2) Саванд 3 л 450 мл ус байв. 1785 мл-ийг өөр сав руу хийв. Саванд хэдий хэмжээний ус үлдсэн бэ?

## БАТАТГАХ

**522** Шингэний хэмжээг литр, миллилитрээр илэрхийлэн бичээрэй.



**523** Багаас их уруу эрэмбэлээрэй. Хамгийн их ба бага хэмжээний зөрөөг олоорой.

- а. 2 л 380 мл, 1 л 50 мл, 1504 мл      г. 1500 мл, 1 л 250 мл, 870 мл  
 б. 120 см, 2 м 6 см, 10 дм 3 см      д. 9 м 50 см, 84 дм 7 см, 18 м  
 в. 1 т 400 кг, 75 ц 50 кг, 6 т 4 ц      е. 80 ц 3 кг, 2500 кг, 3 ц 60 кг

**524** Хэмжээг их нэгжээр тоймлоорой.

- а. 6 л 278 мл, 3 л 510 мл, 4 л 794 мл, 7 л 40 мл, 9 л 750 мл, 8 л 500 мл  
 б. 4 м 8 см, 2 км 30 м, 8 дм 50 см, 3 кг 900 г, 1 т 620 кг, 5 ц 50 кг, 6 г 700 мг

**525**  Савны багтаамжийг олъё.


а. Хүснэгтийг дэвтэртээ зураарай.

Савны нэр	Багтаамж		Зөрөө
	Баримжаа хэмжээ	Хэмжилтийн дүн	
Хоолны сав	2 л	3 л	1 л

- б. Савны багтаамжийг баримжаалан хүснэгтийн 2 дахь баганад бичээрэй.  
 в. Савны багтаамжийг 1 л-ийн багтаамжтай, эсвэл хуваарьтай сав хэрэглэн хэмжээрэй. Хэмжээг хүснэгтийн 3 дахь баганад бичээрэй.  
 г. Баримжаа хэмжээ болон хэмжилтийн дүнгийн зөрөөг олоорой.

**526** Орон сууцын ихэнх айл хэрэглэсэн усны хэмжээг заах тоолууртай байдаг. Гэртээ тоолуургүй айл хоногт 230 л, тоолууртай нь 110 л ус хэрэглэв.

- а. Тоолуургүй айл тоолууртайгаас хоногт хэдэн литр ус илүү хэрэглэсэн бэ?  
 б. 7 хоногт айл бүр хэдэн литр ус хэрэглэх вэ?  
 в. Усаа хэмнэхийн тулд бид юу хийх хэрэгтэй вэ?


**527**  Үдийн цайндаа нэг ангийн сурагчид 10 литр нэрсний шүүс уув. Нэг сурагч 200 мл нэрсний шүүс уусан. Уг анги хэдэн сурагчтай вэ? 30 сурагчтай ангид ямар хэмжээний нэрсний шүүс хэрэгтэй вэ?

## ЭНГИЙН БУТАРХАЙТАЙ ТАНИЛЦАХ


### ЭНГИЙН БУТАРХАЙГ УНШИХ, БИЧИХ




Хүү гарын алдтай тэнцэх урттай туузыг хайчлан авав. Тэр туузын уртыг метрээр илэрхийлжээ. Метр хэрэглэн туузаа хэмжихэд 1 м-ээс илүү гарсан байна.



Туузын 1 м-ээс илүү гарсан хэсгийг метрээр яаж илэрхийлэх вэ? Уртыг нь 1 м-тэй харьцуулж үзье.



1 м-ийг 3 тэнцүү хэсэгт хувааж үзлээ. Түүний 1 хэсэгтэй нь туузын илүү гарсан хэсэг тэнцүү байна.



1 м-ийг 3 тэнцүү хуваасны 1 хэсэг нь  $\frac{1}{3}$  м-тэй тэнцүү. Үүнийг “гуравны нэг метр” гэж уншина.




Бичих дараалал:

$\frac{1}{3}$

**528** 1 м туузыг тэнцүү хэсгүүдэд хуваав.

Туузын будсан хэсэг нь хэдэн метртэй тэнцэх вэ?


Будаагүй хэсгийн урт нь хэдэн метртэй тэнцэх вэ?



**529** 1 м урттай туузыг төлөөлөх гурван тэгш өнцөгтийг зураарай.

Туузын өгсөн урттай хэсгийг будаарай. а.  $\frac{1}{4}$  м б.  $\frac{1}{8}$  м в.  $\frac{1}{10}$  м

**530** Дараах зурагт будсан болон будаагүй хэсгийн уртыг метрээр илэрхийлэн бичээрэй.



Туузыг 5 тэнцүү хэсэгт хуваасан байна. Будсан хэсэг нь 3 ширхэг  $\frac{1}{5}$  м-ээс тогтоно. Үүнийг  $\frac{3}{5}$  м гэж бичих ба “тавны гурван метр” гэж уншина.




Төө, сөөм гэдэг шиг  $\frac{1}{5}$  м-тэй тэнцүү урттай нэгж хэрчмээр туузын уртыг хэмжиж байна гэж ойлгож болох нь.

$\frac{1}{4}$ ,  $\frac{1}{5}$ ,  $\frac{3}{5}$  хэлбэрийн тоог энгийн бутархай гэж нэрлэдэг. Энд 1 ба 3 нь хүртвэр, 4 ба 5 нь хуваарь.

$\frac{3}{5}$  → хүртвэр  
→ хуваарь


**531** 1 м туузын будсан хэсгийн хэмжээг бичиж, үүссэн бутархайн хүртвэр, хуваарийг нэрлээрэй.



**532**  $\frac{3}{8}$ ,  $\frac{7}{8}$ ,  $\frac{6}{8}$ ,  $\frac{4}{8}$ ,  $\frac{2}{8}$ ,  $\frac{8}{8}$  бутархай бүрд хэдэн ширхэг  $\frac{1}{8}$  байна вэ?

$\frac{5}{6}$ ,  $\frac{2}{6}$ ,  $\frac{4}{6}$ ,  $\frac{3}{6}$ ,  $\frac{6}{6}$  бутархай тоо бүр хэдэн ширхэг  $\frac{1}{6}$  -ээс тогтох вэ?

**533** 1 м урттай туузыг 5 тэнцүү хэсэгт хуваажээ.



3 ширхэг  $\frac{1}{5}$  нь ямар урттай вэ?

4 ширхэг  $\frac{1}{5}$  нь ямар урттай вэ?

5 ширхэг  $\frac{1}{5}$  м нь ямар урттай вэ?




1 м туузыг 5 тэнцүү хэсэгт хуваахад 1 хэсгийн урт  $\frac{1}{5}$  м болно. 5 ширхэг  $\frac{1}{5}$  м нь  $\frac{5}{5}$  м буюу 1 м туузтай ижил урттай.

$$\frac{5}{5} = 1$$

## ЭНГИЙН БУТАРХАЙГ ЖИШИХ

**534** Туузыг тэнцүү хуваасныг зурагт үзүүлэв.


- Туузын будсан хэсгийн уртыг илэрхийлэх энгийн бутархайнуудыг бичээрэй. Хүртвэр, хуваарь нь ямар тоо байна вэ?
- Зургийг ашиглан бутархайнуудыг жишээрэй. Ямар дүгнэлт хийж болох вэ?
- Туузын будаагүй хэсгийн уртыг илэрхийлэх бутархайг бичээрэй.
- Туузын будсан, будаагүй хэсгүүд нийлээд ямар урттай байна вэ?



3 ширхэг  $\frac{1}{4}$  -нь 2 ширхэг  $\frac{1}{4}$  -ээс их. Иймд

$\frac{2}{4}$  нь  $\frac{3}{4}$  -аас бага буюу  $\frac{2}{4} < \frac{3}{4}$ .  $\frac{3}{4}$  нь  $\frac{2}{4}$  -оос их буюу  $\frac{3}{4} > \frac{2}{4}$ .

**535** Хэрчим дээр цэгээр тэмдэглэсэн тоог уншаарай. Тоонуудын аль нь их вэ?



**536** Жишээд, уншаарай.

- $\frac{1}{3}$  ба  $\frac{2}{3}$ ;      в.  $\frac{3}{8}$  ба  $\frac{7}{8}$ ;      д.  $\frac{3}{5}$  ба  $\frac{4}{5}$ ;      ж.  $\frac{4}{4}$  ба  $\frac{3}{4}$ ;      и.  $\frac{6}{6}$  ба 1
- $\frac{2}{4}$  ба  $\frac{3}{4}$       г.  $\frac{3}{8}$  ба  $\frac{6}{8}$       е.  $\frac{2}{6}$  ба  $\frac{4}{6}$       з.  $\frac{6}{10}$  ба  $\frac{9}{10}$       к. 1 ба  $\frac{7}{8}$

**537** Бутархайнуудын хуваарь, хүртвэрийг нэрлээрэй. Өсөх эрэмбээр бичээрэй. Тууз зурж, бутархайнуудыг илэрхийлэх хэсгийг тэмдэглэн шалгаарай.

- $\frac{6}{8}$ ;  $\frac{2}{8}$ ;  $\frac{8}{8}$ ;  $\frac{3}{8}$       б.  $\frac{2}{6}$ ;  $\frac{5}{6}$ ; 1;  $\frac{4}{6}$       в.  $\frac{9}{10}$ ; 1;  $\frac{7}{10}$ ;  $\frac{3}{10}$

**538** -ний оронд тохирох тоо олж бичээрэй. Өөр ямар тоог бичиж болох вэ?


$$\frac{5}{8} < \frac{\square}{8}; \quad \frac{9}{10} > \frac{\square}{10}; \quad \frac{\square}{5} > \frac{8}{5}; \quad \frac{3}{6} < \frac{\square}{6}; \quad \frac{\square}{3} > \frac{1}{3}; \quad \frac{\square}{4} < \frac{3}{4}; \quad \frac{\square}{\square} = 1$$

**539** Зүй тогтлыг олж, дараагийн 2 тоог бичээрэй.

- $\frac{1}{10}$ ,  $\frac{3}{10}$ ,  $\frac{5}{10}$ , ,
- $\frac{8}{8}$ ,  $\frac{6}{8}$ ,  $\frac{4}{8}$ , ,



## ЭНГИЙН БУТАРХАЙГ НЭМЭХ, ХАСАХ



Хоёр саванд байгаа ундааны хэмжээг зурагт үзүүлэв.

Сав тус бүрд хэдэн литр ундаа байна вэ?


Хоёр саван дахь ундааг нийлүүлбэл хэдэн литр болох вэ?

Эхний саванд хоёр дахиас хэдэн литр ундаа илүү байна вэ?

илэрхийлэл

илэрхийлэл

**Жишээ 1**  $\frac{3}{10} + \frac{2}{10}$  нийлбэрийн утгыг яаж олох вэ? Тайлбарлаарай.




3 ширхэг  $\frac{1}{10}$  л ба 2 ширхэг  $\frac{1}{10}$  л нийлээд  $(3 + 2)$  ширхэг  $\frac{1}{10}$  л.



$\frac{3}{10} + \frac{2}{10} = \frac{5}{10}$  (л). Иймд хоёр саван дахь ундааг нийлүүлбэл  $\frac{5}{10}$  л болно.

**Жишээ 2**  $\frac{3}{10} - \frac{2}{10}$  ялгаврын утгыг яаж олох вэ? Тайлбарлаарай.




3 ширхэг  $\frac{1}{10}$  л-ээс 2 ширхэгийг хасахад  $(3 - 2)$  ширхэг  $\frac{1}{10}$  л.



$\frac{3}{10} - \frac{2}{10} = \frac{1}{10}$  (л). Иймд эхний саванд хоёр дахиас  $\frac{1}{10}$  л ундаа илүү байна.


**540** Хоёр саван дахь шингэний хэмжээг зурагт үзүүлэв. Хоёр саванд нийт хэдэн литр шингэн байна вэ? Аль саванд хэдэн литрээр илүү шингэн байна вэ?



**541** Дараах энгийн бутархайнуудын нийлбэр, ялгаврын утгыг олоорой.

а.  $\frac{7}{10}$  ба  $\frac{2}{10}$  б.  $\frac{5}{10}$  ба  $\frac{3}{10}$  в.  $\frac{3}{6}$  ба  $\frac{1}{6}$  г.  $\frac{3}{8}$  ба  $\frac{5}{8}$  д.  $\frac{2}{5}$  ба  $\frac{2}{5}$  е.  $\frac{1}{3}$  ба  $\frac{2}{3}$


**542** 1 л багтаамжтай саванд хийсэн усны хэмжээг зурагт үзүүлэв.



- Саван дахь усны хэмжээг литрээр илэрхийлэн бичээрэй.
- Хэмжээнүүдийг ихээс бага руу жагсаан бичээрэй.
- Сав бүрийн усны хэмжээг 1 литр болгохын тулд хэдэн литр ус нэмэх вэ?
- Саванд байгаа усны хагастай нь тэнцэх хэмжээний усыг тухайн саванд нэмж хийвэл усны хэмжээ ямар болох вэ? Хасвал ямар болох вэ?

**543** Саванд  $\frac{3}{4}$  л цай байв. Охин  $\frac{1}{4}$  л-ийг нь уусан бол саванд ямар хэмжээтэй цай үлдсэн бэ?

**Жишээ 3** 60 кг алимын  $\frac{3}{10}$  нь хэдэн килограмм бэ?



$\frac{3}{10}$  нь 3 ширхэг  $\frac{1}{10}$  -ээс тогтоно.

1)  $\frac{1}{10}$  -д хэдэн килограмм алим ногдохыг олъё:  $60 \div 10 = 6$  (кг)

2) 3 ширхэг  $\frac{1}{10}$  -д хэдэн килограмм алим ногдохыг олъё:  $3 \times 6 = 18$  (кг)

**544** Бодлогыг бодоод, тайлбарлаарай.

- 32 л усны  $\frac{1}{4}$  нь хэдэн литр вэ?
- 250 кг будааны  $\frac{4}{10}$  нь хэдэн кг бэ?
- 72 т ачааны  $\frac{3}{8}$  нь хэдэн тонн вэ?
- 138 шүрний  $\frac{5}{6}$  нь хэдэн шүр вэ?
- 150 см-ийн  $\frac{2}{5}$  нь ямар урттай вэ?
- 3021 м-ийн  $\frac{2}{3}$  нь хэдэн метр вэ?

**545** Сургалтын төвд 680 ном байв. Нийт номын  $\frac{6}{10}$  хэсэг нь сурах бичиг,  $\frac{2}{10}$  нь дасгалын ном,  $\frac{1}{10}$  нь үлгэрийнх, бусад нь багшийн ном байв. Номын төрөл бүрээс тус бүр хэд байсан бэ? Олсон тоонуудаа эрэмбэлээрэй.

**546** Эмээгийн тарьсан хүнсний ногооны талбайн хэмжээг зурагт дүрслэв.

Ногооны талбайг 1 хэсэг гээ.

Төмс, лууван, хүрэн манжин, байцай тус бүрийг нийт ногооны талбайн ямар хэсэгт тарьсныг бутархайгаар бичээрэй.



## СОРИХ

**547** Дараах тоонууд хэдэн ширхэг  $\frac{1}{8}$ -ээс тогтох вэ?

- а.  $\frac{7}{8}$       б.  $\frac{3}{8}$       в.  $\frac{6}{8}$       г.  $\frac{1}{8}$       д. 1      е.  $\frac{2}{8}$       ё.  $\frac{5}{8}$

**548** Сумаар заасан цэгүүдэд харгалзах энгийн бутархайг бичээрэй.



**549**  $>$ ,  $<$ ,  $=$  тэмдгийн аль тохирохыг бичиж жишээрэй.

- а.  $\frac{2}{5}$  ба  $\frac{4}{5}$       б.  $\frac{3}{4}$  ба  $\frac{2}{4}$       в. 1 ба  $\frac{7}{8}$       г.  $\frac{5}{5}$  ба 1      д.  $\frac{3}{3}$  ба  $\frac{6}{6}$

**550** Тооцоолоорой.

- а.  $\frac{4}{10} + \frac{3}{10}$       б.  $\frac{3}{5} + \frac{2}{5}$       в.  $\frac{5}{6} - \frac{1}{6}$ ;      г.  $1 - \frac{3}{8}$       д.  $\frac{1}{4} + \frac{3}{4}$       е.  $1 - \frac{3}{3}$

## БАТАТГАХ

**551** Энгийн бутархайг бичээрэй. Хүртвэр, хуваарийг нэрлээрэй.

- а. 2 ширхэг  $\frac{1}{3}$ -ээс тогтох;      в. 5 ширхэг  $\frac{1}{6}$ -ээс тогтох;      д. 7 ширхэг  $\frac{1}{8}$ -ээс тогтох  
 б. 6 ширхэг  $\frac{1}{6}$ -ээс тогтох;      г. 3 ширхэг  $\frac{1}{5}$ -ээс тогтох;      е. 5 ширхэг  $\frac{1}{4}$ -ээс тогтох


**552** Уншаад бичээрэй.

- а. Тавны гурав      в. Наймны долоо      д. Аравны тав  
 б. Аравны ес      г. Зургааны тав      е. Гуравны дөрөв

**553** Жишээрэй.

- а.  $\frac{3}{6}$  ба  $\frac{4}{6}$       б.  $\frac{9}{10}$  ба  $\frac{7}{10}$       в.  $\frac{3}{8}$  ба  $\frac{5}{8}$       г.  $\frac{5}{5}$  ба  $\frac{2}{5}$       д. 1 ба  $\frac{1}{2}$       е.  $\frac{3}{4}$  ба  $\frac{2}{4}$

**554** 1 метрийн харгалзах хэсгийг будаарай.



Будсан зургийг ажиглаад, дараах зааврын дагуу ажиллаарай.

а. Тоон шулууны  $\square$ -д тохирох тоог олж бичээрэй.

б. 1 метрт  $\frac{1}{5}$  м хэд багтаж байна вэ?

в.  $\frac{3}{5}$  м ба  $\frac{4}{5}$  м-ийн аль нь хэдээр их вэ?

**555** 1 м урттай туузыг тэнцүү хэсгүүдэд хуваажээ. Асуултад хариулаарай.

а. Туузыг 3 тэнцүү хэсэгт хуваав. 3 ширхэг  $\frac{1}{3}$  м нь ямар урттай вэ?

б. Туузыг 10 тэнцүү хэсэгт хуваав. 10 ширхэг  $\frac{1}{10}$  м ямар урттай вэ?

**556** 1 дм туузыг төлөөлөх гурван тэгш өнцөгтийг зураарай.

Туузын өгсөн урттай хэсгийг будаарай. а.  $\frac{3}{4}$  м б.  $\frac{5}{8}$  м в.  $\frac{4}{10}$  м

**557** Өсөх эрэмбээр бичээрэй.

а.  $\frac{7}{8}$ ;  $\frac{1}{8}$ ; 1;  $\frac{3}{8}$ ;  $\frac{5}{8}$ ;  $\frac{4}{8}$  б.  $\frac{1}{6}$ ;  $\frac{6}{6}$ ;  $\frac{4}{6}$ ;  $\frac{3}{6}$ ;  $\frac{2}{6}$ ;  $\frac{5}{6}$  в.  $\frac{2}{5}$ ;  $\frac{4}{5}$ ;  $\frac{3}{5}$ ;  $\frac{5}{5}$ ;  $\frac{1}{5}$ ;  $\frac{6}{5}$

**558** -ний оронд тохирох тоо олж бичээрэй.

а.  $\frac{2}{5} < \frac{\square}{5}$  б.  $\frac{\square}{3} > \frac{1}{3}$  в.  $\frac{4}{10} < \frac{\square}{10}$  г.  $\frac{\square}{\square} = 1$  д.  $\frac{\square}{\square} = \frac{\square}{\square}$

**559**



Бутархай тоон шугам хийе.


1)  $\frac{1}{4}$  дм-ээр хэмжих шугам хийе.

а. Цаасаар 1 дм урттай тууз хийе.

б. Туузыг хагаслан нугалаарай.

в. Дахин хагаслан нугалаарай.

г. Туузаа дэлгээрэй. Нугалаас дээр зураас зурж, хэмжээг бичээрэй.



Туузыг яаж гурван тэнцүү хэсэгт хувааж нугалах вэ?




2)  $\frac{1}{3}$  дм-ээр хэмжих шугам хийе.

а. Цаасаар 1 дм урттай тууз хийе.

б. Дэвтрийн хоорондоо ижил зайтай зураасыг шугам хийхэд хэрэглэнэ.

в. 3 тэнцүү хэсэгт хуваахдаа 4 зураасын хооронд туузыг байрлуулна. Туузын дээд ирмэгийн голын зураастай уулзах хэсгийг тэмдэглэн хуваарь, хэмжээг бичнэ.



3)  $\frac{1}{5}$  дм,  $\frac{1}{6}$  дм,  $\frac{1}{8}$  дм,  $\frac{1}{10}$  дм-ээр хэмжих шугам хийгээрэй.

Хийсэн шугамаа хэмжилт хийх, уртыг харьцуулахдаа хэрэглээрэй.

**560** Дараах тоон шулууныг дэвтэртээ зураарай.



Энэхүү шулуун дээр дараах хэсгийг тэмдэглээд, бутархайг бичээрэй.

- |                             |                             |
|-----------------------------|-----------------------------|
| а. 1-ийн хагас              | д. 1-ийг 4 хуваасны 1 хэсэг |
| б. 1-ийг 3 хуваасны 1 хэсэг | е. 1-ийг 4 хуваасны 2 хэсэг |
| в. 1-ийг 3 хуваасны 2 хэсэг | ж. 1-ийг 4 хуваасны 3 хэсэг |
| г. 1-ийг 3 хуваасны 3 хэсэг | з. 1-ийг 4 хуваасны 4 хэсэг |

**561**  $\frac{4}{10}$ ,  $\frac{5}{6}$ ,  $\frac{1}{10}$ ,  $\frac{1}{3}$ ,  $\frac{5}{8}$ ,  $\frac{1}{5}$ ,  $\frac{1}{4}$  тоо бүр дээр хэдийг нэмбэл 1 гарах вэ?

**562** 1 дм туузын  $\frac{1}{8}$ ,  $\frac{1}{2}$ ,  $\frac{1}{4}$ ,  $\frac{1}{6}$ ,  $\frac{1}{5}$ ,  $\frac{1}{3}$ ,  $\frac{1}{10}$  хэсгийн аль урт вэ? Таамаглаад, шалгаарай.

**563** Тоог олоорой.

- а. 12-ын  $\frac{1}{4}$     б. 80-ын  $\frac{7}{10}$     в. 48-ын  $\frac{5}{8}$     г. 72-ын  $\frac{2}{3}$     д. 275-ын  $\frac{3}{5}$

**564** Та алийг сонгох вэ? Яагаад? а ба б-ийн хариулт яагаад ялгаатай байгаа вэ?

- а. Бялууны  $\frac{7}{10}$  ба  $\frac{9}{10}$     б. 500 ₮-ийн  $\frac{7}{10}$  ба 300 ₮-ийн  $\frac{9}{10}$

**565** Дэлхийн бөмбөрцгийн нийт гадаргуугийн  $\frac{7}{10}$  хэсгийг ус, үлдсэн хэсгийг хуурай газар эзэлдэг. Хэдэн хэсгийг хуурай газар эзэлдэг вэ? Ус ба хуурай газрын эзлэх хэсгийн зөрөөг олоорой.

**566** Багш амралтын өдрийг хэрхэн өнгөрүүлэх талаар сурагчдаас судалгаа авчээ. Сурагчдын  $\frac{3}{10}$  нь спортоор хичээллэх,  $\frac{5}{8}$  нь аяллаар явах, үлдсэн сурагчид амрах санал гаргажээ. Анги 40 сурагчтай бол спортоор хичээллэх, аялах, амрах хүсэлтэй тус бүр хэдэн сурагч байсан бэ?

**567** Дэлгүүрт ном 5000 ₮, зургийн дэвтэр 2500 ₮-ийн үнэтэй байв.

- а. Барааны үнэ  $\frac{1}{10}$ -ээр хямдарсан бол ном, дэвтэр ямар үнэтэй болсон бэ?  
б. Хүүхдийн баяраар бараа хямдарсан үнийн  $\frac{1}{10}$ -ээр дахин хямдарчээ. Ном дэвтэр ямар үнэтэй болсон бэ?

**568**



1. Нэг метр олсыг 6 тэнцүү хэсэгт хувааж огтлов. 4 хэсгийнх нь уртыг метрээр илэрхийлээрэй. 7 хэсгийн урт ямар байх бол?

2. Зүй тогтлыг олж, дараагийн 2 тоог бичээрэй.  $\frac{2}{10}$ ,  $\frac{4}{10}$ ,  $\frac{6}{10}$ , ,

## ТОЙРОГ, ДУГУЙГ ТАНИХ

**569** Зурагт үзүүлсэн юмс ямар хэлбэртэй харагдаж байна вэ?





**570**



Тойрог, дугуй зурж бүтээе.

Цагаан болон өнгийн цаас, харандаа, ундааны таглаа, эсгий бал, хайчаа бэлтгэе. Зурагт үзүүлсний дагуу хийгээрэй.




Үүссэн хоёр дүрс ямар ялгаатай байна вэ?



дугуй    тойрог

**571**

Зурагт цэгүүдийг үсгээр тэмдэглэжээ. Дэвтэртээ хүснэгтийг зураарай. Цэгүүдийг ялган хүснэгтэд бичээрэй.



Дугуйн гадна орших цэг	Дугуйн дотор талд орших цэг	Тойрог дээр орших цэг
	E,	

**572**



Зааврын дагуу цэг тэмдэглээрэй. Зөв хийсэн эсэхээ шалгаарай.

- а. Дэвтэртээ дугуй зуръя.
- б. Дугуйн гадна цэнхэр өнгөөр гурван цэг тэмдэглэе.
- в. Дугуйн дотор улаан өнгөөр гурван цэг тэмдэглэе.
- г. Тойрог дээр балын харандаагаар гурван цэг тэмдэглэе.




Дугуй, тойргийн төв, радиус, диаметрийг олъё.

- Дугуй зүйлс, хэв хэрэглэн цаасаар дугуй дүрс хийе.
- Дугуйн хүрээг давхцуулан нугалъя. Буцааж дэлгээд, нугалаасны шугамыг тодруулан зуръя.
- Дугуйн хүрээг давхцуулан өөр нугалаас үүсгэе. Цаасаа дэлгээд хоёр нугалаасны огтлолцсон цэгийг тодруулж тэмдэглэе.
- Зурагт улаанаар тодруулсан нугалаасны уртыг хэмжье.



- А, Б зураг дахь улаанаар зурсан нугалаасны урт ямар байна вэ?  
 В, Г, Д зураг дахь улаанаар зурсан нугалаасны урт ямар байна вэ?  
 Тойрог дээр ямар нэг цэг тэмдэглээрэй. Уг цэгээс О цэг хүртэлх зайг хэмжээрэй. Энэ зайг Д зураг дахь нугалаасны урттай жишээрэй.



Тойрог, дугуйн төвийг дайрсан хөвчийг **диаметр** гэнэ.

Тойрог, дугуйн төвөөс тойрог хүртэлх зайг **радиус** гэнэ.

О - дугуй, тойргийн төв;  
 ОА, ОК, ОМ, ОТ - радиус  
 АК, МТ - диаметр

Асуултад хариулаарай.

- Тойргийн диаметр дээрх цэг тойргийн цэг мөн үү?
- Тойргийн диаметр дээрх цэг дугуйн цэг мөн үү? Яагаад?
- Монгол гэрийн шал, хоолны савны амсар, тогооны таг, цагаригийн аль нь тойрог, аль нь дугуй хэлбэртэй харагдах вэ? Өөр жишээ гаргаарай.
- 2 см радиустай тойргийг яаж зурах вэ? Ярилцаарай.



Тойрог, дугуйг “гортиг” хэмээх тусгай багаж хэрэглэн зурдаг юм байна.




Гортигийн бүтэц:

- ① Харандаатай хөл
- ② Зүүтэй хөл
- ③ Бариул

575



Гортиг хэрэглэн 2 см радиустай тойрог зуръя.



O - тойргийн төв  
OA - радиус



Тойрог зурахын тулд тэмдэглэсэн цэгт гортигийн зүүг тогтооно. Гортигийн 2 хөлийн хоорондох зайг өөрчлөхгүйгээр бариулыг эргүүлэн харандааны үзүүрээр тойрог зурна.

576

Өгсөн радиустай тойрог зураарай.

- а. 1 см    б. 3 см    в. 8 мм    г. 1 см 3 мм    д. 2 см 4 мм


577

Хэрчмийн уртыг шугамаар хэмжиж олоорой.

- а. \_\_\_\_\_    б. \_\_\_\_\_    в. \_\_\_\_\_    г. \_\_\_\_\_

578


Тойргийн радиус, диаметрийн уртыг шугамаар хэмжиж олоорой.




579




Тойргуудыг жижигрүүлэн зуржээ. Дараах хэмжээнүүдийг олж тайлбарлаарай.



Өнгөөр ялгасан хэрчмийн урт:



Өнгөөр ялгасан хэрчмийн урт:




Тэгш өнцөгтийн периметр:   
Тэгш өнцөгтийн талбай:



## СОРИХ

**580** А, Б дүрсүүдийн нэрийг бичээрэй.  
Б дүрсийн радиус, диаметрийг хэмжиж олоорой.




**581** Гортигоор 1 см 5 мм радиустай дугуй зураад, будаарай.  
а. Дугуйн гадна талд цэнхэр өнгөөр хоёр цэг тэмдэглээрэй.  
Дугуйн дотор талд балын харандаагаар хоёр цэг тэмдэглээрэй.  
Тойрог дээр цэнхэр өнгөөр хоёр цэг тэмдэглээрэй.  
б. Тойрог ба дугуйн ялгааны талаар бичээрэй.

## БАТАТГАХ

**582** Өгсөн диаметртэй тойрог зураарай.  
а. 2 см      б. 4 см      в. 10 мм      г. 30 мм      д. 6 см

**583** Тойргийн радиус, диаметрийн уртыг шугамаар хэмжиж олоорой.




**584** 35 мм радиустай тойрог зураарай. Тойргийн төвөөс дараах зайд орших цэгүүдийг тэмдэглээрэй.


а. 2 см зайд орших А цэг,      б. 4 см зайд орших К цэг,  
в. 3 см 5 мм зайд орших М цэг,      г. 3 см зайд орших Е цэг

Цэгүүдийн аль нь дугуйн дотор, дугуйн гадна, тойрог дээр оршиж байна вэ?


**585** Хэмжилт хийлгүйгээр тооцоолоорой. Олсон аргаа тайлбарлаарай.



Тойргууд ижил хэмжээтэй бол ягаанаар тодруулсан хэрчмийн урт:



Квадратын периметр 24 см бол тойргийн радиус:



Тэгш өнцөгтийн периметр:   
талбай:

**586** Өгсөн хэмжээг хоёр дахин ихэсгээрэй.  
5 мм, 2 см, 3 дм, 50 ₮, 40 мм, 9 кг, 20 л, 14 см, 19 кг, 8 м, 25 мм

## НЭГДСЭН БАТАТГАЛ


### АРВАН МЯНГА ХҮРТЭЛХ ТООГ УНШИХ, БИЧИХ, ЖИШИХ, ТОЙМЛОХ

- 587** Тоонуудыг үгээр бичив: Гурван мянга долоон зуун дөчин ес, зуун тавь, найман зуун хоёр, мянга долоон зуун тав, гурван мянга гурван зуун гучин ес, дөрвөн мянга гуч, зургаан мянга тав, есөн мянга долоон зуу
- а. Тоонуудыг бичээрэй.  
 б. Орны нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичээрэй.  
 в. Хэдэн нэгж, хэдэн аравт, хэдэн зуут, хэдэн мянгатаас тогтож байна вэ?

мянгат	зуут	аравт	нэгж

- 588** Дараах тоонуудыг хуваарьгүй тоон шулуун дээр тэмдэглээрэй. Эдгээр тоог ихээс бага руу, багаас их рүү дараалуулан бичээрэй.  
 3452, 75, 705, 1979, 5050, 7300, 2907, 4000, 9998, 6001, 8100

- 589** Ногоон өнгөтэй тоонуудыг үгээр бичээрэй.



- 590** Дараах хүнсний барааны үнийг багалан диаграммаар дүрслээрэй.



- 591** Онцолсон цифр ямар утга илэрхийлж байгааг ярилцаарай.

2793      7900      5001      5605      1094

- 592** Дараах тоонуудыг жишээрэй:

а. 998  1000      г. 3497  3507      ж. 2017  2020  
 б. 2998  996      д. 3210  3157      з. 3999  8762  
 в. 1897  1890      е. 1700  2697      и. 2018  2108

- 593** 706 нь 0 ба 1000-ын алинд ойр вэ? Тоон шулуун дээр дүрсэлж үзүүлээрэй.

- 594** 3672, 4098, 5013, 7108, 1500 тоонуудыг  
 а. аравтаар    б. зуутаар    в. мянгатаар тус тус тоймлон бичээрэй.

**595**  $68 \cdot 4 > 6809$  байхын тулд \* -ны оронд ямар цифрүүд байж болох вэ?

**596** 8452-оос а. арваар нэмэгдүүлэн 8700 хүртэл тоолоорой.  
б. зуугаар нэмэгдүүлэн 10000 хүртэл тоолоорой.

**597** 1950-аас а. арваар хорогдуулан 1500 хүртэл тоолоорой.  
б. зуугаар хорогдуулан 50 хүртэл тоолоорой.

**598** 348 тооноос 50 нэгж зайд орших тоонуудыг тоон шулуун дээр тэмдэглээрэй. Хэрхэн олсноо тайлбарлаарай.

**599**



Сурагчид ээлжлэн дарагдсан тоог уншина. Бие биенээ зөв уншиж байгаа эсэхийг шалгана. Нэг өнгөөр будсан тоонууд ямар зүй тогтолтой байна вэ? Ярилцаарай.



901	902	903		905	906			909	1000
1001	1002		1004	1005	1006		1008	1009	1010
1011		1013	1014	1015	1016		1018		1020
	1022	1023	1024	1025	1026		1028	1029	1030
1031	1032	1033	1034	1035	1036		1038	1039	
	1042	1043	1044	1045	1046		1048	1049	1050
1051		1053	1054	1055	1056		1058	1059	1060
1061	1062		1064	1065	1066		1068	1069	1070
1071	1072	1073		1075	1076		1078	1079	1080
1081	1082	1083	1084		1086		1088	1088	1090

901	902	903	904		906	907			1000
1001	1002	1003		1005	1006	1007	1008		1010
1011	1012		1014	1015	1016		1018		1020
1021		1023	1024	1025	1026	1027	1028		1030
	1032	1033	1034	1035		1037	1038		1040
1041	1042	1043	1044	1045	1046	1047	1048		1050
	1052	1053	1054		1056	1057	1058		1060
1061		1063	1064	1065	1066	1067	1068		1070
1071	1072			1075	1076	1077	1078		1080
1081	1082	1083		1085	1086	1087	1088		1090



**600** 1978-аас их, 2013-аас бага байх тоонуудыг ялгаж бичээрэй.  
999, 3152, 2010, 2099, 1999, 909

**601** Тоонуудыг өсөх эрэмбээр байрлуулаарай.  
а. 94, 112, 100      б. 276, 275, 302, 288      в. 810, 830, 790, 791

**602** Ажиглаад, мэдэгдэхгүй байгаа тоог олоорой.

6318	6328	6338	?	6358	?	?	?	6398
9152	?	?	?	9552	9652	9752	?	?

**603** Тоонуудын нийлбэр, зөрөөг олоорой. а. 4732, 4800 б. 2549, 6082

**604**



Тоог таая.

а. Хоёр, хоёроороо баг болъё.

б. 3, 4, 1, 5 гэсэн цифрүүд, тооны орон, ангийн хүснэгт, харандаа бэлтгэе.

в. Нэг тоглогч нь цифр давтагдаагүй 4 оронтой тоо зохиож саная.

г. Түүний санасан тоог нөгөө нь 4 оронтой тоо зохиож таая.

д. Дүрээ сольж тоглоё.

Тоог тааж байгаа хүүхдэд эхний тоглогч санаа өгч болно. Жишээ нь 5413 тоог санасан гэе. Таагч 5314 гэж бичсэн байвал эхний тоглогч “Миний санасан тооны зуут нь чинийхээс их” гэх мэт дөхүүлж болно.

**605** Үзвэрийн тасалбаруудыг 1-ээс 1000 хүртэл дугаарлав. 13-аар төгссөн дугаартай үзэгчид азтай үзэгчээр шалгарав. Шалгарсан бүх дугаарыг бичээрэй. Хэдэн үзэгч шалгарсан бэ?

**606** а. 40 арав + 3 зуу + 4 арав + 3 нэгжтэй тэнцүү байх тоог олоорой.

б. Найман аравт дээр есөн аравтыг нэмсэнтэй тэнцэх тоог олоорой.

**607** 9, 5, 2, 8 гэсэн цифрүүдээр цифр нь давтагдахгүй байх 3, 4 оронтой тоонууд зохиогоорой. Үүссэн тоонуудаа аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

**608** Ямар тоонуудыг тоймловол 7000 болох вэ?

**609** 3, 4 цифрүүдээр дөрвөн оронтой тэгш тоо хэдийг зохиож болох вэ?

а. Зохиосон тоонуудаа уншаарай.

б. Орон, ангийн хүснэгтэд тоонуудаа бичээрэй.

в. Тоонуудаа тоон шулуун дээр цэгээр тэмдэглээрэй.

г. Тоо бүрд хэдэн бүтэн аравт, зуут, мянгат байгааг бичээрэй.

**610** Улаанбаатараас Өлгий сум 1709 км, Улиастай сум 1023 км, Хэрлэн сум 661 км, Чингис сум 338 км, Зуунмод 43 км зайд оршино.

а. Тоонуудыг уншаад, эрэмбэлээрэй.

б. Тоонуудыг хэрэглэн асуулт зохиож, бие биенээсээ асуугаарай.

**611** 4372, 3392, 5032, 5428, 6777, 6020, 7001 тоонуудыг 10, 100, 1000-аар тус тус нэмэгдүүлэн, хорогдуулан тоолоорой. (Тус бүр гурван тоо хэлээрэй.)

**612**



7499, 154, 509, 480, 73, 18 гэсэн тоонуудыг:

а. Үгээр бичээрэй. Цифрүүдийн утгыг бичээрэй.

б. Орны нэмэгдэхүүний нийлбэрт задлаарай.

в. Аравт, зуут, мянгатаар тоймлоорой.

## ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

**613** Хүүхдүүд ямар зайрмагт дуртайг зурган диаграммаар харуулжээ.

Шоколадтай	
Ургамлын сүүтэй	
Чацарганатай	
Нэрс жимстэй	



нь 2 зайрмаг

- Хэдэн хүүхэд шоколадтай зайрмагт дуртай вэ?
- Хэдэн хүүхэд нэрс жимстэй зайрмагт дуртай вэ?
- Долоон хүүхдийн дуртай зайрмагийг нэрлэнэ үү?
- Энэ судалгаанд хэдэн хүүхэд оролцсон бэ?

**614** Хайрцагт өнгө өнгийн цэцгэн дүрс байв. Тэдгээрийг өнгө өнгөөр нь зурган диаграммаар дүрсэлжээ. Асуултад хариулаарай.

- Ягаан өнгийн цэцгэн дүрс хэдэн ширхэг байна вэ?
- Ямар өнгийн цэцгэн дүрс тэнцүү тоотой байна вэ?
- 3, 3 асуулт тавьж хариулаарай.

Улаан	
Хөх	
Ногоон	
Шар	
Ягаан	
Хар	



нь 2 цэцгэн дүрс

**615** Биеийн тамирын дугуйланд хичээллэсэн 3<sup>а</sup> ангийн сурагчийн тоог зурган диаграммаар дүрсэлжээ.

Хавар	
Зун	
Намар	
Өвөл	



нь 2 сурагч




нь 1 сурагч

- Ямар улиралд хэдэн сурагч хичээллэснийг олоорой.
- Баганан диаграммаар дүрсэлж үзүүлээрэй.

**616** Манай гэр 5 ам бүлтэй. Аав 50, ээж 45, том хүү 20 настай. Дунд хүү ээжээс 3 дахин бага настай. Харин бага хүү ааваас 10 дахин бага настай. Хүн тус бүрийн насыг диаграммаар дүрслэн харуулаарай.

**617** Таван сурагчийн минутад уншсан үгийн тоог хүснэгтэд бүртгээрэй. Бүртгэлээ баганан диаграммаар дүрслээрэй.

**618** 3<sup>б</sup> ангийн сурагчид тэжээдэг амьтдын талаар судалгаа авчээ. Судалгааг баганан диаграммаар дүрслэв.



- Хэчнээн сурагч туулай тэжээдэг вэ?
- Сурагчид ямар амьтныг илүү их тэжээдэг вэ?
- Ямар амьтныг хамгийн цөөн сурагч тэжээдэг вэ?
- Нохой тэжээдэг сурагч яст мэлхий тэжээдэг сурагчаас хэдээр олон бэ?
- Нийт хэдэн сурагч амьтан тэжээдэг вэ?

**619** Хүснэгтэд өгсөн өгөгдлийг баганан диаграммаар дүрслээрэй.


Хүүхдүүдийн нэр	Үсэрсэн тоо (дээс)
1 Дорж	8
2 Сувд	22
3 Амар	10
4 Болд	8
5 Туяа	15
6 Бат	20

- Хэн хамгийн олон үсэрсэн бэ?
- Хэн 15 удаа үсэрсэн бэ?
- Сувд Батаас хэдээр олон үсэрсэн бэ?
- Адил тоотой үсэрсэн хүүхэд хэн хэн бэ?
- Бүх хүүхэд нийлээд хэд үсэрсэн бэ?

**620** Сайншанд хотын агаарын температурыг хүснэгтээр үзүүлжээ. Үүнийг баганан диаграммаар дүрслээрэй. Асуултууд зохиож, хариулаарай.

11 дүгээр сарын 11	11 дүгээр сарын 12	11 дүгээр сарын 13	11 дүгээр сарын 14	11 дүгээр сарын 15
6	5	3	4	4

**621** Саран, Наран, Туяа, Болд, Баяр нарын өндрийг хэмжив. Тэд харгалзан  
 1 м 30 см; 1 м 23 см;  
 1 м 19 см; 1 м 25 см;  
 1 м 23 см өндөртэй байсан бол хэмжээсийг сантиметрт шилжүүлэн баганан диаграммаар дүрслээрэй.




## АРВАН МЯНГА ДОТОР ТООГ НЭМЭХ, ХАСАХ

622

10т гэсэн тэмдэгтэй гүүрээр ачаатай машин гарах боллоо. Хоосон машин 4250 кг жинтэй бөгөөд 5345 кг ачаатай байв. Ачаатай машин гүүрээр гарч болох уу? Яагаад?



Хэрэв машины нийт жин 5 т-оос илүү байвал гүүрээр гарч болох уу?



Бодолтыг ажиглаад, ярилцаарай.

	4	2	5	0
+	5	3	4	5
	9	5	9	5

1 т = 1000 кг  
10 т = 10000 кг

9595 кг < 10000 кг  
Машин гүүрээр гарах боломжтой.

623

Баяр 11 алимтай байв. Хэдэн алим идсэний дараа 8 үлдэв. Аль тэнцэтгэл уг үйлийг илэрхийлэх вэ?

а.  $11 + 8 = \square$

б.  $8 = 11 + \square$

в.  $11 - \square = 8$

г.  $8 - \square = 11$

624

Асуултад хариулаарай.

а. Хоёр торны нэгэнд 5 кг, нөгөөд 1 кг ногоо байв. Хоёр гартаа барих ачааг хэрхэн тэнцүүлэх вэ?

б. 50 г, 100 г-ын туухайнуудыг жинлүүрийн хоёр тавганд тавив. Жинлүүрийн нэг тавган дахь туухайнууд нийлээд 700 г, нөгөө тавгийнх 800 г болов. Жинлүүрийг хэрхэн тэнцвэртэй болгох вэ?

625

Бичиг хэргийн дэлгүүр хичээлийн хэрэгслийн үнийг хямдруулжээ. Хүснэгт дэх ? тэмдгийн оронд байх тоог олоорой. Эдгээр тоо юуг илэрхийлэх вэ?

№	Хичээлийн хэрэгсэл	Анхны үнэ	Хямдарсны дараах үнэ	Үнийн зөрөө
1	Цүнх	32500₮	28300₮	?
2	Боодол бичгийн цаас	6800₮	?	1200₮
3	Зузаан дэвтэр	?	1560₮	450₮
4	Усан будаг	4500₮	3300₮	?

Цүнх, зузаан дэвтэр худалдан авбал хэдэн төгрөг хэмнэх вэ?

626

Хүснэгтийн багана, мөр, ташуу чиглэлийн дагуу орших 3 тооны нийлбэр ижил утгатай байхаар тоог олж бичээрэй.

а.

309	319	
	311	
		313

б.

		113
	119	
125		121

в.




**627** Илэрхийллийн утгыг олоорой.  
 а.  $7523 + 2157$       б.  $5301 + 3849$       в.  $9456 - 6508$       г.  $6809 - 2953$

**628** Багш хоёр тооны нийлбэрийг олоод, хариу зөв гарсан эсэхийг шалгах даалгавар өгчээ. Чимгээ, Тулгаа хоёр өөр аргаар шалгасан байв. Тэд яаж шалгасан бэ? Дүгнэлт хийгээрэй.

		Чимгээ				Тулгаа								
+	4	5	0	7	-	7	7	0	2	-	7	7	0	2
	3	1	9	5		3	1	9	5		4	5	0	7
	7	7	0	2		4	5	0	7		3	1	9	5



а. Алтайн нуруунд орших Таванбогд уулын “Хүйтэн”-ий оргил өөд спортын мастер И.Өсөхбаяр авирав. "Бид 3795 м өндөрт байна. Оргил хүрэхэд 579 м үлдлээ" гэсэн мэдээллийг тэр утсаар өгчээ. Монголын хамгийн өндөр цэг болох “Хүйтэн”-ий оргилын өндрийг олоорой.

б. Отгонтэнгэр уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 4008 м өндөрт өргөгдсөн. “Хүйтэн”-ий оргил нь Отгонтэнгэрээс хэдэн метрээр өндөр болохыг олоорой.

в. Дэлхийн хамгийн өндөр Эверест уулын орой далайн түвшнээс дээш 8848 метр өндөрт оршдог. Дэлхийн хамгийн өндөр цэгийг Монгол улсын хамгийн өндөр цэгтэй харьцуулан ярилцаарай. Зөрөө нь хэд байна вэ?



**630** Оновчтой арга сонгон бодоорой.  
 а.  $375 + 199$       б.  $7540 + 1960$       в.  $2786 - 995$       г.  $6942 - 1850$

**631**




1. Нийлбэр, ялгаврын утгыг олоорой.

а.  $2520 + 1107$       б.  $301 + 3240$       в.  $9006 - 6500$

2. Барилгын компани чиргүүлтэй машинаар элс татжээ. Машины толгойн тэвшинд 5250 кг, чиргүүлд 4350 кг элс ачив. Машинаар нийт хэчнээн килограмм элс татсан бэ?

3. Аялагчид Улаанбаатар хотоос Хархорин, тэндээс Хорго руу явжээ. Зарим аялагчид Хорго руу шууд очиход нийт 620 км зам туулжээ. Улаанбаатараас Хархорин хүртэл 380 км, Хархориноос Хорго хүртэл 290 км зайтай. Аялагчид хэдэн километр зам туулж Хоргод очсон бэ? Хорго орох хүртэл хэн бага зам туулсан бэ?





**632** Оёдлын үйлдвэр 2 тасагтай. Нэгдүгээр тасаг 245, хоёрдугаар тасаг 140 оёдолчинтой. Үйлдвэр зохион байгуулалтаа өөрчлөхөд нэгдүгээр тасагас 50 оёдолчин хасагдаж, хоёрдугаар тасагт 53 оёдолчин нэмэгджээ. Үйлдвэрийн нийт оёдолчны тоо өөрчлөгдсөн үү? Хэрхэн өөрчлөгдсөн бэ?

**633** Хүснэгтийг ажиглаарай. Хоосон нүдэнд тохирох илэрхийлэл бичээд, шалгаарай. Яаж олсноо тайлбарлаарай.

а.

Нэмэгдэхүүн	2530	$2530+470$	$2530-530$	?	?
Нэмэгдэхүүн	1374	?	?	$1374+626$	$1374-374$
Нийлбэрийн утга	3904	3904	3904	3904	3904

б.

Хасагдагч	8650	$8650+350$	$8650-650$	?	$8650-650$
Хасагч	2640	$2640+350$	$2640-650$	$2640+360$	?
Ялгаврын утга	6010	?	?	6010	6010

в. Хүснэгтэн мэдээллээ хэрэглэн бодлого зохиогоорой.

**634** Нэг нь нөгөөгөөсөө нэг зуугаар их байх хос тоог олоорой.

- а. 196 ба 206                      в. 568 ба 558                      д. 2100 ба 3100  
 б. 1654 ба 1754                    г. 9230 ба 9240                    е. 6750 ба 6650

**635** Сарнай дэлгүүрээс 2500 төгрөгөөр жигнэмэг, 3750 төгрөгөөр аньсны ундаа, 3000 төгрөгөөр алим худалдан авав. Чимгээ 2900 төгрөгөөр гадил, 5600 төгрөгөөр самар худалдан авчээ. Хэн нь хэдээр илүү мөнгө зарцуулсан бэ?

**636** Манай сургуулийн гурван анги 174 хүү, 219 охинтой. Сурагчдын 189 нь 7 настайдаа, бусад нь 6 настайдаа сургуульд орсон. Хэдэн хүүхэд 6 настайдаа сургуульд орсон бэ?

**637** Товч бичиглэлээр бодлого зохиож бодоорой.

Байсан        410 кг  
 Худалдсан   90 кг ба 160 кг  
 Үлдсэн        ?

**638** Гурван анги нийлээд 950 кг хаягдал цаас цуглуулав. Эхний анги 427 кг, хоёр дахь анги эхний ангиас 192 кг-аар бага цаас цуглуулсан. Гурав дахь анги хэдэн килограмм хаягдал цаас цуглуулсан бэ?

**639**



Сургууль 2035 сурагчтай. Үүнээс 1020 нь урлагийн дугуйланд, 915 нь биеийн тамирын дугуйланд суралцдаг.

108 сурагч ямар ч дугуйланд хичээллэдэггүй бол дугуйланд хэдэн сурагч хамрагдсан бэ? Хэдэн сурагч урлаг ба биеийн тамирын дугуйлангийн аль алинд суралцдаг вэ?

## АРВАН МЯНГА ДОТОР ТООГ ҮРЖҮҮЛЭХ, ХУВААХ

**640** Үржвэр, ногдворын утгыг олоод шалгаарай.

$$\begin{array}{cccccc} 223 \times 4 & 274 \times 3 & 312 \times 2 & 145 \times 6 & 642 \times 6 & 460 \times 6 \\ 728 \div 4 & 528 \div 4 & 360 \div 2 & 280 \div 40 & 720 \div 20 & 700 \div 10 \end{array}$$

**641** Үйлдлийг гүйцэтгээд, үр дүнгийн талаар ярилцаарай.

$+100$	$\times 100$	$\div 100$	$-100$
5	4	100	100
50	40	900	900
500	59	6700	6700
9900	100	10000	10000

**642** Халиун цуглуулгадаа наадаг зураг худалдан авахаар төлөвлөжээ. Наадаг зураг тус бүр 100 төгрөгийн үнэтэй. Тэр 3160 төгрөгтэй бол хамгийн олондоо хэдэн зураг худалдан авч чадах вэ?


**643** Ногоочин 363 кг өргөст хэмх хурааж, түүнийгээ 5 кг багтаамжтай хайрцагт савлаж зооринд хадгалахаар болжээ. Түүнд хэдэн хайрцаг хэрэгтэй вэ?

**644** Тойрон аялагчид очих эцсийн цэг хүртэл 2 өдөр явахаар төлөвлөжээ. Цаг агаарын байдлаас шалтгаалан эхний өдөр төлөвлөснөөс 40 км дутуу явав. Тэд хугацаандаа хүрэхийн тулд 2 дахь өдөр хэдэн километр зам илүү явах хэрэгтэй вэ?

**645** Хүснэгтэд өгсөн барааны тоо, хэмжээг хэрэглэн бодлого зохиож бодоорой.

Барааны нэр	Тоо ширхэг	Нийт үнэ (₮)
Дэвтэр	3	4500
	$3 \times 2$	?
Өнгийн харандаа	8	6400
	$8 \div 4$	?
Үзэг	5	3250
	$5 \times 2$	?

**646** Дэлгүүрийн агуулахад хураасан хайрцаг тус бүрд 10 ширхэг шилэн аяга хийжээ. Эдгээр хайрцаг дахь шилэн аяганы тоог олоорой.



**647** Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

- а. Нийлбэрийн нэг нэмэгдэхүүнийг 100-аар нэмэгдүүлж, нөгөөг 50-аар хорогдуулахад нийлбэрийн утга 50-аар .....
- б. Хуваагдагчийг 2 дахин ихэсгэхэд ногдворын утга .... дахин .....
- в. Хасагдагчийг 50-аар нэмэгдүүлж, хасагчийг 50-аар ..... ялгаврын утга өөрчлөгдөхгүй.

**648** Ногдворын утгыг олоорой. Загварын учрыг тайлбарлан ярилцаарай.

$$\begin{array}{r} 2400 \div 100 \\ \downarrow \times 2 \quad \downarrow \times 2 \\ 4800 \div 200 \end{array}$$

$$\begin{array}{r} 360 \div 20 \\ \downarrow \times 10 \quad \downarrow \div 10 \\ 3600 \div 2 \end{array}$$

$$\begin{array}{r} 9000 \div 1000 \\ \downarrow \div 2 \quad \downarrow \div 2 \\ 4500 \div 500 \end{array}$$

**649** Баяраагийн гэр бүл хоногт 120 литр ус хэрэглэдэг бол 10 хоногт хэдэн литр ус хэрэглэх вэ? Сард хэдэн литр ус хэрэглэх вэ? Нэг литр ус 2 төгрөгийн үнэтэй бол сард усны хэрэглээнд хэдэн төгрөг зарцуулах вэ?

**650** Бодолт хийлгүйгээр жишээрэй.

а.  $5039 - 916$    $6000 - 916$

в.  $(28 + 15) \times 4$    $28 \times 4 + 15 \times 4$

б.  $2603 + 376$    $376 + 2603$

г.  $685 \times 10$    $683 \times 10$

**651** Нэгэн байгууллага 775 бэлэг авчээ. 55-ыг нь цэцэрлэгт, үлдсэнийг нь 9 сургуульд тэнцүү хувааж өгөв. Сургууль бүрд хэдэн бэлэг өгсөн бэ?

**652** Бодлогуудыг бодоорой. Тэдгээрийн бодолтод ямар ялгаа байна вэ?

а.  $47 \times 9$

б. 47 сургуулиас тус бүр 9 сурагч тэмцээнд оролцов. Тэмцээнд нийт хэдэн сурагч оролцсон бэ?

в. Хэсэг төмсийг 9 кг-аар 47 уутанд савлав. Нийт хэдэн килограмм төмс савласан бэ?

**653**



1. Уурхайн олборлох хэсэг 1200, боловсруулах хэсэг 1500 ажилчинтай байв. Ажил ихсэж олборлох хэсэгт 500, боловсруулах хэсэгт 400 ажилчин нэмжээ. Уурхайн ажилчны нийт тоо хэрхэн өөрчлөгдсөн бэ?

2. Тохирох тоог нөхөж бичээрэй.

$120 \times 2 = 240$

$120 \times 3 = 240$

$25 \times 12 = 240$

$\downarrow \div 3 \quad \downarrow \times 3$

$\downarrow \div \square \quad \downarrow \times 4$

$\downarrow \times 6 \quad \downarrow \div \square$


$40 \times 6 = \square$

$30 \times 12 = \square$

$\square \times 2 = \square$

3. Усны цоргоноос 17 л болон 5 л-ийн саваар 7 л усыг хэрхэн авах вэ?

**654** Хэлхмэл тоон жишээг бодоорой. Нэг илэрхийллийн утга нь дараагийн илэрхийллийн эхний гишүүн бол яаж холбогдохыг зурж үзүүлээрэй.




**655** 1, 2, 3, 4, 5 цифрүүдээр 3 оронтой таван тоо зохиож бичээрэй. Хамгийн их, хамгийн бага тоонуудын зөрөөг олоорой.

**656**



Тэгш, сондгой тооны нийлбэр, ялгаврын утгыг олъя.


1-ээс 3 оронтой, 500-аас бага байх тоонууд бүхий олон төрлийн картууд, (тэгш, тэгш), (сондгой, сондгой), (тэгш, сондгой) гэсэн үг бичсэн 3 карт бэлтгэнэ.



Сурагчид 4-өөс 5 гишүүнтэй баг болж тоглоно.

- 1) Сурагч бүр 3 картаас харалгүйгээр нэгийг сугална.
- 2) Картуудаас өөрийн сугалсан шинж бүхий 5 хос тоо сонгоно.
- 3) Хос тоо бүрийн нийлбэр, ялгаврын утгыг олно.

Тухайлбал, тэгш, тэгш гэдгийг сугалсан гээ.



152 + 48, 152 – 48  
106 + 448, 448 – 106 гэх мэт бүх боломжит нийлбэр, ялгаврыг олно.

- 4) Сурагч бүр хийсэн үйлдлээ хажуугийн сурагчаар хянуулна. Алдаа гарсан бол хамтдаа засна.
- 5) Бусад сугалаанаас дахин сугалж тоглоно.
- 6) “Тэгш”, “сондгой” үгсийн аль тохирохыг бичиж, өгүүлбэрийг гүйцээнэ.

- а. Хоёр тэгш тооны нийлбэрийн утга .... тоо байна.
- б. Хоёр тэгш тооны ялгаврын утга .... тоо байна.
- в. Хоёр сондгой тооны нийлбэрийн утга .... тоо байна.
- г. Хоёр сондгой тооны ялгаврын утга .... тоо байна.
- д. Тэгш ба сондгой тооны нийлбэрийн утга..... тоо байна.
- е. Тэгш ба сондгой тооны ялгаврын утга..... тоо байна.

## ХЭМЖИХ

**657** Хугацааг минутаар илэрхийлээрэй.



$$4 \text{ цаг } 37 \text{ мин} < \begin{matrix} \square & \text{цаг} & = & \square & \text{мин} \\ \square & & & & \text{мин} \end{matrix}$$

$$4 \text{ цаг } 37 \text{ мин} = \square \text{ мин}$$

- а. 1 цаг 56 мин      в. 8 цаг 5 мин  
б. 3 цаг 40 мин      г. 4 цаг 9 мин

Хугацааг цаг, минутаар илэрхийлээрэй.


$$345 \text{ мин} < \begin{matrix} \square & \text{мин} & = & \square & \text{цаг} \\ \square & & & & \text{мин} \end{matrix}$$

$$345 \text{ мин} = \square \text{ цаг } \square \text{ мин}$$



- а. 365 мин      в. 300 мин  
б. 147 мин      г. 190 мин

**658** Асуултад хариулж, ярилцаарай.



**659** Хэмжээг граммаар илэрхийлээрэй.



$$8 \text{ кг } 405 \text{ г} < \begin{matrix} \square & \text{кг} & = & \square & \text{г} \\ \square & & & & \text{г} \end{matrix}$$

$$8 \text{ кг } 405 \text{ г} = \square \text{ г}$$

- а. 8 кг 921 г      б. 2 кг 38 г      в. 7 кг 6 г

Хэмжээг грамм, килограммаар илэрхийлээрэй.

$$5805 \text{ г} < \begin{matrix} \square & \text{г} & = & \square & \text{кг} \\ \square & & & & \text{г} \end{matrix}$$

$$5805 \text{ г} = \square \text{ кг } \square \text{ г}$$



- а. 3254 г      б. 8072 г      в. 4004 г

**660** Хэмжээг уншиж, жишээрэй.

320 см  32 дм

180 кг  204 кг

215 мин  3 цаг

352 г  400 г

1526 м  999 м

15 цаг 20 мин  15 цаг

1776 г  1 кг

326 км  918 км

785 км  782 км

- 661** Улаанбаатараас Сайншанд орох галт тэрэгний цагийн хуваарийг үзүүлэв. Галт тэргээр Улаанбаатараас Чойр хүртэл 247 км, Улаанбаатараас Сайншанд хүртэл 475 км явав.

Өртөөний нэр	Ирэх цаг	Явах цаг
Улаанбаатар		20:00
Чойр	00:10	00:30
Сайншанд	03:30	

- а. Улаанбаатараас Сайншанд ороход ямар хугацаа зарцуулах вэ?  
 б. Галт тэрэг Чойр өртөөнд хэдий хугацаанд зогсох вэ?  
 в. Чойроос Сайншанд ороход ямар хугацаа зарцуулах вэ?  
 г. Чойроос Сайншанд хүртэлх зайг олоорой.  
 д. Галт тэрэг 04:15-д Сайншандаас цааш явав. 3 цаг 35 минутын дараа Замын-Үүдэд ирсэн байна. Галт тэрэг хэдэн цагт Замын-Үүдэд ирсэн бэ?

- 662** Сурагч долоо хоногийн таван өдөр нь шатрын дугуйланд явдаг. Үүнээс хоёр өдөр нь тус бүр 40 минут, гурван өдөр нь тус бүр 35 минут хичээллэдэг. Таван өдөр шатраар хичээллэдэг нийт хугацааг цаг, минутаар гаргаарай.

- 663** 6 дугаар сарын цаг тооны бичгийг үзүүлэв. 6 дугаар сарын 7-ны бямба гарагаас Баярмаагийн зуны амралт эхэлнэ. Уг өдрөөс яг хоёр долоо хоногийн дараа тэр өвөөгийн дөв амрахаар хөдөө явна. Тэр хэдний өдөр хөдөө явах вэ? 45 хоногийн дараа буцаж ирэх бол түүний ирэх сар, өдөр, гаргийг олоорой.

Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30						

- Цаг тооны бичигт өнгөөр ялгасан тоонууд ямар зүй тогтолтой байна вэ?  
 а. Цэнхэрээр будсан 6, 14, 22 гэсэн тоонууд  
 б. Ягаанаар будсан 5, 11, 17, 23 тоонууд

- 664** Нэг долоо хоногт хүү  ширхэг ном уншдаг. 8 долоо хоногт түүний унших номын тоог олох илэрхийлэл аль нь вэ? Яагаад?

$$8 \div \square, \quad 8 \times \square, \quad \square + 8, \quad (\square + \square) \times 8$$

- 665** Зүй тогтлыг олж, дараагийн дөрвөн тоо, хэмжээг олж бичээрэй.

- а. 3, 6, 9, 12, ...      г. 7, 5, 3, ...      ж. 20, 70, 120, ...  
 б. 2 дм, 4 дм, 8 дм, ...      д. 1 т, 20 ц, 3 т, ...      з. 2 км, 1 км, 500 м, ...  
 в. 5, 4, 3, 2, ...      е. 30 с, 1 мин 15 с, 120 с, 2 мин 45 с, ...

**666** Дараах юмсын хүндийн хэмжээ ойролцоогоор ямар болохыг ярилцаж, хүснэгтэд тэмдэглээрэй. Дараа нь жинлүүрээр хэмжин тэмдэглээрэй. Хэн хамгийн бодитой баримжаалсан байна вэ?

	Ойролцоо хэмжээ	Бодит хэмжээ
Дугтуй		
Ном		
Алим		
Цүнх		
Аяга		



**667** Өгсөн зүйлсийг хэмжихэд тохирох нэгжийг дэвтэртээ бичээрэй.

Урт	Хүндийн хэмжээ	Багтаамж
Дэвтрийн зузаан Ангийн ханын өндөр Өнгийн цаасны өргөн 2 хотын хоорондох зай	Хүүхэд Баллуур Машин	Лаазтай ундаа Хувин дүүрэн ус

**668** Хэмжээг килограмм, граммаар илэрхийлэн бичээрэй.



**669** Хэмжээнүүдийг заасан нэгжид шилжүүлээрэй.

а. .... дм = 120 см

г. 7 ц = .... кг

ж. 4 л = .... мл

б. 8 дм = .... см

д. .... кг = 5 т

з. 6000 мл = .... л

в. 6 км = .... м

е. 7 кг = .... г


и. 8000 м = .... км

**670** 8 шуудай гурил, 10 шуудай будааны хүндийг хэмжихэд 410 кг байв. 5 шуудай гурил, 10 шуудай будаа 350 кг байлаа. 9 шуудай гурил, 7 шуудай будааг хэмжвэл хэдэн килограмм байх вэ?

**671** Ангид 20 ширээ, 4 кг будаг байв. Нэг ширээний тавцан будахад 150 г будаг хэрэглэдэг бол бүх ширээний тавцан будахад хэдэн грамм будаг орох вэ? Хэдэн грамм будаг үлдэх вэ?

**672** Зоригт онгоцоор 609 км, машинаар 382 км, мориор 29 км аялав. Зоригт нийт хэдэн километр аялсан бэ?

**673** Зурагт Булган, Эрдэнэт нь Улаанбаатараас ямар зайд оршихыг үзүүлжээ.




а. Эрдэнэт Улаанбаатараас ямар зайд орших вэ?

б. Булганаас Улаанбаатар уруу явахдаа Эрдэнэтээр дайрч явбал нийт хэдэн километр зам туулсан бэ?

в. Явган аялагч Булганаас Эрдэнэт руу явах замын яг дунд морьтой хүнтэй тааралдав. Тэр Булганаас ямар зайд морьтой хүнтэй уулзсан бэ?

г. Явган аялагч цагт 6 км зам туулж байв. Тэр Эрдэнэтээс Булган хүртэл хэдэн цаг аялах вэ?

**674** Бичгийн хавчаарын уртыг ойролцоогоор олоорой.




**675** Саванд 23 л ус байв. Уг савыг суллахын тулд усыг нь жижиг савнуудад хийх болжээ.

а. Бүх усыг савлахад 2 л багтаамжтай хэдэн сав хэрэгтэй вэ? Яагаад?

б. Бүх усыг савлахад 3 л багтаамжтай хэдэн сав хэрэгтэй вэ? Яагаад?

в. 3 л-ийн багтаамжтай 2 сав, 2 л-ийн багтаамжтай 12 сав байв. Бүх усыг савлахад 2 л ба 3 л-ийн савнаас хамгийн цөөндөө хэд хэрэгтэй вэ? Яагаад?

**676** Зурагт дүрсэлсэн модны өндөр 3 м байв. Байшингийн өндрийг ойролцоогоор олоорой. Олсон аргаа тайлбарлаарай.





**677** Багш дөрвөн хүүхдэд тус бүр нэг тууз өгчээ. Хүүхэд бүр туузаа хэмжиж үзэв. Хоёр дахь хүүхдийн тууз нь нэг дэх хүүхдийнхээс хоёр дахин урт, харин гурав дахь хүүхдийнх нь нэг дэх хүүхдийнхээс гурав дахин урт байв. Хэрэв дөрөв дэх хүүхдийн тууз гурав дахь хүүхдийн туузаас 2 см-ээр урт бол хүүхэд тус бүр хэдэн сантиметр тууз авсан бэ? (4 туузын уртын нийлбэр 1 м 10 см, 2 м 18 см байхад тус тус тооцоолоорой.)



## ЭНГИЙН БУТАРХАЙГ УНШИХ, БИЧИХ, ТЭМДЭГЛЭХ

**678**  $\frac{2}{4}$ ;  $\frac{3}{4}$ ; 1;  $\frac{5}{4}$  бутархайнууд хэдэн ширхэг  $\frac{1}{4}$  -ээс тогтох вэ?

**679** Тохирох энгийн бутархайг бичээрэй.



**680** Бутархайнуудыг жишээд, тайлбарлаарай.

а.  $\frac{5}{8}$  ба  $\frac{7}{8}$       б.  $\frac{4}{5}$  ба  $\frac{3}{5}$       в.  $\frac{5}{6}$  ба  $\frac{4}{6}$       г.  $\frac{7}{10}$  ба  $\frac{9}{10}$

**681** Бутархайнуудыг уншиж жишээрэй.

а.  $\frac{1}{5}$  ба  $\frac{3}{5}$ ;    б.  $\frac{1}{3}$  ба  $\frac{2}{3}$ ;    в.  $\frac{2}{4}$  ба  $\frac{1}{4}$ ;    г.  $\frac{2}{6}$  ба  $\frac{5}{6}$ ;    д.  $\frac{3}{8}$  ба  $\frac{5}{8}$ ;    е.  $\frac{7}{10}$  ба  $\frac{5}{10}$

**682**  $\frac{7}{10}$ ;  $\frac{1}{10}$ ;  $\frac{6}{10}$ ;  $\frac{9}{10}$ ;  $\frac{11}{10}$  тоонуудыг тоон шулуун дээр хэрчмээр дүрслээрэй.

Багаас их уруу эрэмбэлэн бичээрэй.

**683** Бялууны  $\frac{1}{8}$  хэсгийг Туяа,  $\frac{3}{8}$  хэсгийг Сувдаа,  $\frac{2}{8}$  хэсгийг Чимгээ тус тус идэв.

Хэн хамгийн том, хэн хамгийн жижиг хэсгийг идсэн бэ?

**684** Тоон шулуун дээр  $\frac{1}{8}$ ,  $\frac{2}{8}$ ,  $\frac{3}{8}$ ,  $\frac{5}{8}$  гэсэн бутархайнуудыг цэгээр тэмдэглээрэй.




Багаас их уруу жагсаан бичээрэй.

**685** -ны оронд тохирох тоог бичээрэй. Хэдэн тоо бичсэн бэ? Яагаад?

а.  $\frac{1}{3} < \frac{\square}{3}$       б.  $\frac{7}{8} > \frac{\square}{8}$       в.  $1 = \frac{\square}{\square}$       г.  $\frac{1}{10} < \frac{\square}{10}$


**686** Ижил хэмжээтэй тэгш өнцөгтийг 2, 4, 6 тэнцүү хэсэгт хуваажээ. Будсан хэсгүүдийг жишээд, тайлбарлаарай. Адил бодлого зохион бодоорой.



3 ширхэг  $\frac{1}{4}$  ба 5 ширхэг  $\frac{1}{6}$

1 ширхэг  $\frac{1}{2}$  ба 4 ширхэг  $\frac{1}{6}$

**687**  $\frac{3}{4}$ ,  $\frac{3}{6}$ ,  $\frac{3}{8}$ ,  $\frac{3}{10}$  тоонуудыг дүрслэн харуулаарай.




Бутархайнуудын хүртвэр ямар байна вэ?  
Хуваариуд ямар байна вэ?  
Хуваарь юуг илэрхийлэх вэ?  
Хуваарь ихтэй тоо бусдаасаа ямар байна вэ?

**688**  $\frac{3}{5}$  ба  $\frac{3}{6}$ ,  $\frac{2}{10}$  ба  $\frac{2}{8}$ ,  $\frac{3}{4}$  ба  $\frac{1}{6}$  -ийг зургаар дүрслэн үзүүлээрэй.

Бутархайнуудыг жишээд, тайлбарлаарай.



$\frac{3}{6}$  нь  $\frac{3}{5}$  -аас бага учир  $\frac{3}{6} < \frac{3}{5}$  гэж бичнэ.



$\frac{3}{5}$  нь  $\frac{3}{6}$  -аас их учир  $\frac{3}{5} > \frac{3}{6}$  гэж бичнэ.



**689** Аль нь багаас их уруу эрэмбэлэгдсэн байна вэ? Яаж мэдсэн бэ?


а.  $\frac{1}{2}$ ;  $\frac{1}{6}$ ;  $\frac{1}{10}$

б.  $\frac{1}{10}$ ;  $\frac{1}{6}$ ;  $\frac{1}{2}$

в.  $\frac{1}{6}$ ;  $\frac{1}{2}$ ;  $\frac{1}{10}$

г.  $\frac{1}{10}$ ;  $\frac{1}{2}$ ;  $\frac{1}{6}$

**690** Сурагч 500 төгрөгтэй байв. Тэр бүх мөнгөнийхөө  $\frac{2}{5}$ -оор нь самар авч иджээ. Түүнд хэдэн төгрөг үлдсэн бэ?




**691** 3<sup>а</sup> анги 40 сурагчтай.  $\frac{1}{4}$  нь дотуур байранд амьдардаг бол хэдэн сурагч дотуур байранд амьдардаг вэ?

**692** Сурагч Баяр зуны амралтаа дараах байдлаар өнгөрүүлэхээр төлөвлөжээ.

Амралтын хоногийн  $\frac{3}{10}$  -д хөдөө аялж,  $\frac{5}{8}$  -д англи хэлний сургалтад сууж, үлдсэн хэсэгт амрах болжээ. Амралт нь 80 хоногтой бол Баяр хэдэн өдөр хөдөө аялж, хэдэн өдөр англи хэлний сургалтад сууж, хэдэн өдөр амрах вэ?

## ДҮРС, БИЕТИЙГ ТАНИХ, ЯЛГАХ

**693** Өнцгүүдээ ангилж, хүснэгтэд дугаарыг бичээрэй. Яаж шалгах вэ?




Тэгш өнцгөөс их	Тэгш өнцөг	Тэгш өнцгөөс бага

**694** Цагийн зүү аль чиглэлд эргэдэг билээ? “Цагийн зүүний дагуу эргэх”, “цагийн зүүний эсрэг чиглэлд эргэх” гэдгийг хэрхэн ойлгож байгаагаа тайлбарлаарай.



**695** 2 цаасан туузыг холбон, цагийн зүүний аль чиглэлд эргүүлж өнцөг үүсгэсэн байна вэ? Улаан, ногоон сумын дагуу үүсгэсэн өнцгүүд хэдэн тэгш өнцгөөс тогтох вэ? Үүссэн өнцөг бүр нэг бүтэн эргэлтийн хэдэн хэсэг болох вэ?



**696** Тэгш өнцгийг олоорой. Яаж мэдсэн бэ?



**697** Ямар үсэг, цифрийн бичиглэлд тэгш, хурц, мохоо өнцөг харагддаг вэ?


**698**



Дугуй дүрсээр өнцөг үүсгэе.


Ижил хэмжээтэй, өөр өнгөтэй хоёр дугуй, хайч бэлтгэнэ.

а. Хоёр дугуйг радиусын дагуу хайчилна.




б. Хайчилсан хэсгээр зөрүүлж оруулна.

в. Нэг дугуйг эргүүлж, янз бүрийн өнцөг үүсгээрэй.




Аль нь тэгш өнцгөөс их, бага вэ?


**699** Дүрсийг дэвтэртээ дуурайлган зураарай. Тэгш хэмээр үргэлжлүүлээрэй.



**700** Дүрсийг үргэлжлүүлэн хээ үүсгээрэй.



**701** Аль дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг зөв зурсан байна вэ? Яагаад? Бусад дүрсийн хувьд яагаад буруу гэж үзсэн бэ?



**702** Тэгш өнцөгт хэлбэртэй ногооны талбай 45 м урттай, 8 м өргөнтэй. Баяр талбайг 1 тойрон алхаж ногооны ургалтыг харав. Түүний алхсан замын уртыг олоорой. 2 удаа тойрвол ямар зам туулах вэ?

**703**




1) Квадрат хэлбэртэй, 10 м урттай гүйлтийн замыг 6 удаа тойрч гүйвэл ямар зам туулах вэ?

2) Дүрс бүтээе.


Нэг тоглогч геосамбарт янз бүрийн дүрс бүтээнэ. Нөгөө нь дүрсийг нэрлээд, мэдэх шинжээ хэлнэ. Эхний сурагч зөв эсэхийг хянана. Тоглогчид үүргээ сольж тоглоно.

3) Дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг олж зураарай.




**704** Дүрс, биетийн нэрийг бичээрэй. Эдгээрийг дэвтэртээ ялган бичээрэй.

Дөрвөн өнцөгт	Дөрвөн өнцөгт биш



Өөр нэг болон хоёр шинжээр ялган дүрслээрэй.

**705** Туяад баруун гар талын зурагт үзүүлсэн хавтгай дүрс тус бүр 6 байв.



а. Ямар дүрсээс хэдийг хэрэглэн куб бүтээж болох вэ? Хариултаа тайлбарлаарай.

б. Үүсэх кубийн гадаргуугийн талбайг бодож олоорой.

**706** Нэг төвтэй 4 см диаметртэй тойрог, 1 см радиустай дугуй зураарай. Дугуйн төвөөс 1 см, 2 см, 3 см зайд орших гурван цэгийг тэмдэглээд, үсэг бичээрэй. Цэгүүд тойрог, дугуйн хаана байрлаж байгааг бичээрэй.

**707** 14 см урттай хэрчим зураарай. Түүний долооны дөрөвтэй тэнцүү урттай хэрчим зураарай. Хоёр хэрчмийн уртын зөрөө хэд байна вэ? Үүнтэй төстэй бодлого зохиогоорой. Бодлогоо бодоод, шалгаарай.

**708** Периметр нь 16 см байх квадрат зураарай. Ижил периметртэй ямар тэгш өнцөгтүүд байх вэ? Зурсан квадрат, тэгш өнцөгт бүрийн талбайг олоорой.

**709**




“Дүрс, биетийн талаар миний мэдэх зүйлс”

Зургийн дэвтрийн цаас, хайч, өнгийн болон балын харандаа, үзэг бэлтгэнэ.

Багаараа, хосоороо тоглож болно.

- Зургийн дэвтрийн цаасыг зурагт үзүүлснээр хэд хэдэн удаа хагаслан нугалж хайчлаарай.
- Нэг жижиг цаасан дээр нэг дүрс эсвэл биет байхаар зураарай.
- Өөр цааснууд дээр дүрс эсвэл биетийн ямар нэг шинжийг бичнэ.
- Цааснуудыг дүрс, биет, шинжтэй хэсгээр нь доош харуулж холино. Нэгийг сугалж, сонгосон дүрс, биетийн талаар ярилцана.



## ЗҮЙ ТОГТОЛ, БОЛОМЖИЙН ТООГ ОЛОХ

- 710** Улаан, ягаан, хөх, ногоон өнгөөр дарагдсан тоонуудыг ялган бичээрэй. Ямар зүй тогтол ажиглагдаж байна вэ? Тухайлбал, ногоон: 21; 34; 47; 60; ...

	22		24	25			28	29	30
31	32			35			38	39	40
41	42		44		46			49	50
51	52			55	56	57	58		


- 711** Дүрсүүдийн зүй тогтлыг ажиглаарай.



Дараах зүй тогтлын аль нь дээрхтэй адил байгааг олж тайлбарлаарай.

- а. НННАНННАННААНА    б. НАННААНННАААН    в. НАААНННААННАН

- 712** Зүй тогтлыг ажиглаарай. 4 дэх биетэд хэдэн куб байхыг олоорой.




5, 6 дахь биетэд тус бүр хэдэн куб байх вэ?

- 713** Дараах тоон дарааллын зүй тогтлыг олж, үргэлжлүүлээрэй.

- а. 347, 352, 349, 354, 351, , ,   
 б. 583, 561, 572, 550, 361, 539, , ,

- 714** дүрсээс уруу хэдэн янзаар хүрэх боломжтой вэ?

Модны загвараар бодоорой.



- 715** 3, 4, 6, 7 цифрүүдээр гурван оронтой тоо хэдийг зохиож болох вэ?

Модны загвар хэрэглэн дараах тоонуудыг олж бичээрэй.

- а. Цифрүүд нь ялгаатай, хамгийн их гурван оронтой тоо  
 б. Цифрүүд нь ялгаатай, хамгийн бага гурван оронтой сондгой тоо  
 в. Цифрүүд нь ялгаатай, 50-аас бага тэгш тоо

- 716** Үсэгт тааврыг тааж, тайлбарлаарай. Ижил үсэг нь ижил цифрийг төлөөлнө.

а. 

+		У	С	
		У	С	
	Г	О	Л	

    б. 

+	С	У	Р	
	С	У	Р	
	Н	О	М	


    в. 

-	Ж	О	Р	
	Г	А	А	
		Э	М	

    г. 

+	А	Б	В	
	А	В	Б	
	Б	Б	Б	


717



1-8 хүртэлх цифрүүдийг квадратын тал бүрийн дагуух тоонуудын нийлбэр 11, 10, 12, 13 байхаар байрлуулаарай.

$$\begin{array}{r} \bigcirc + \bigcirc = \bigcirc \\ + \\ \bigcirc \quad \quad \quad + \\ \hline \bigcirc \times \bigcirc = \bigcirc \bigcirc \end{array}$$

Үнэн тэнцэтгэлүүд байхаар 0-9 хүртэлх цифрүүдийг дугуйнуудад байрлуулаарай.



Ялгавар нь хамгийн бага байхаар 1-8 хүртэлх цифрүүдийг дугуйнуудад байрлуулаарай.

718

Харандаагаа цааснаас салгахгүйгээр, зурсан муруй дээгүүр дахин явахгүйгээр өгсөн дүрсийг дэвтэртээ зураарай. Аль цэгээс эхэлж зурах вэ?



719

Туяа 3000 төгрөгийн үнэтэй сэтгүүл авав. Туяад 1000 төгрөгийн 3, 500 төгрөгийн 6, 100 төгрөгийн 5 ширхэг дэвсгэрт байсан бол 3000 төгрөгийг хэдэн янзаар өгч болох вэ? Хүснэгтийг нөхөөрэй.

	1000	500	100	нийт
а				3000
б				3000
в				3000
г				3000
д				3000
е				3000

720

Таван хүүхэд уралдаж тоглов. 1, 2, 3 дугаар байрыг хэдэн янзаар эзэлж болох вэ? Модны загвар хэрэглэн бодоорой.

721

Ангийн гурван найз зэрэгцэн зогсож зураг авахуулав. Хэдэн янзаар зургаа авахуулж болох вэ?

722

Шатрын тэмцээнд За, Зб, Зв, Зг, Зд, Зе ангиудаас нэг, нэг шатарчин оролцов. Гуравдугаар ангийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд хэдэн өрөг тоглох вэ?

723

0, 2, 3 цифрүүдээр цифр давтагдахгүй 3 оронтой тоо хэдийг зохиож болох вэ? Цифр давтагдах 3 оронтой тоо хэдийг зохиож болох вэ?

724

25 л ордог саванд 20 л ус байв. 5 л, 9 л-ийн багтаамжтай саваар литр усыг яаж авах вэ? 8 л усыг хэрхэн авах вэ?

25 л	9 л	5 л
20	0	5
20	5	0
15	5	5
15	9	1

725



4 л, 9 л-ийн багтаамжтай хоёр сав хэрэглэн 6 л усыг хэрхэн авах вэ?


## БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨНИЙГ ТОГТООХ

**726** Нарангийн гэрийн орчныг зураглан үзүүлэв.  
Жишээ: номын сан А4-д байрлаж байна.


6								
5								
4	Номын сан				Дэлгүүр			
3			Сургууль					
2								
1								
	А	Б	В	Г	Д	Е	Ж	З

- Байршлыг бичээрэй: Сургууль \_\_\_\_\_ ; Дэлгүүр \_\_\_\_\_
- Нарангийн гэр Г5-д байдаг бол гэрийн байршлыг олж, Х-ээр тэмдэглээрэй.
- Орчинд нь өөр юу байж болох вэ? Нэр, байршлыг бичээрэй.

- 727** а. Цох А1 нүдэнд байрлана. Зурагт саадыг , өвсийг -ээр дүрслэв. Эдгээрийн байршлыг бичээрэй. Цох саадыг тойрч, өвс бүрд байгаа хоолыг идэхээр явав. Цох аль чиглэлд, хэдэн нүдээр явж хоолоо идэх вэ?
- б. Шатар, даамны хөлөг хэрэглэн хосоороо тоглоорой. Хөлөг дээр “хүү”-нүүдийг байрлуулан, байршлыг хэлээрэй. Бие биедээ заавар өгч “хүү”-г нүүгээрэй.




**728** Өгсөн байршлыг будаарай. Ямар дүрс үүсэж байна вэ?



- |        |        |        |
|--------|--------|--------|
| (1, 3) | (7, 3) | (3, 3) |
| (3, 5) | (6, 6) | (8, 4) |
| (9, 3) | (5, 3) | (5, 7) |
| (2, 4) | (7, 5) | (4, 3) |
| (2, 3) | (6, 3) | (8, 3) |



729




- а. Баг дотроо заавар өгөх, оролцох, ажиглах хүүхдүүдээ сонгоорой.
  - б. Заавар өгөх, ажиглах хүүхдүүд оролцогчдын зогсох газрыг заана.
  - в. Зааварлагчид оролцогч бүрд явах зам, чиглэлийг хэлнэ.
  - г. Оролцогч зааварлагчийн хэлснээр явна.
  - д. Ажиглагчид оролцогч зөв явсан эсэхийг хэлнэ.
  - е. Дүрээ сольж тоглоорой.
- Тоглоомын дүрмийг өөрчлөн тоглоорой.

730

Амьтдын аль чиглэлд хэдэн нүдний дагуу явсныг хүснэгтэд харуулав. Тэдний явсан замыг зураарай.

	2 →	1 ↓	2 →	3 →
	2 ←	2 ↓	1 ↖	2 ←
	3 →	2 ↑	2 ↘	2 →



731



Дүрмийг уншаад, тоглоорой


6				●		●	
5		●					
4			●				●
3	●				●		
2			●				
1				●		●	
	А	Б	В	Г	Д	Е	Ж

- а. Ижил өнгийн дугуйг олж, байршлыг хэлээрэй.
  - б. Тэдгээр дугуйн нэгийг нөгөөгийн байршилд шилжүүлэхийн тулд аль чиглэлд хэдэн нүд нүүхийг хэлээрэй.
- Өөр өнгийн дугуйн байрлах нүдийг дайрахгүй шилжүүлэх дөт замыг хэлээрэй.

Жишээ: Ягаан өнгийн дугуйнууд Г6, Д1-д байрлана. Г6-д байрлах дугуйг Д1-д шилжүүлье. Доош нүүхэд ногоон өнгөтэй дугуй байна. Иймд Г6-д байрлах дугуйг баруун гар тийш 1, доош 5 нүд шилжүүлнэ.


## ЭЭРЭГ, СӨРӨГ ТООГ УНШИХ, БИЧИХ, ТЭМДЭГЛЭХ

**732** Зурагт ямар улирлыг дүрсэлсэн байна вэ?




Зурагт дүрсэлсэн өдөр агаарын температур ямар байхыг таамаглаарай.

**733** Температурыг бичээрэй.



**734** Термометрийн заалтуудыг бичээрэй. Тоон шулуун дээр тэмдэглээрэй.



**735** Тоон шулуун хэрэглэн дараах тоонуудыг жишээрэй.

а.  $17 \square 3$ , б.  $0 \square -2$ , в.  $5 \square -6$ , г.  $-14 \square -8$  д.  $-2 \square -3$

**736** 6, 5, 0, -3, 1, 10, -15, -7, 7, -8 тоонуудыг тоон шулуун дээр байрлуулаарай. Өсөх, буурах эрэмбээр уншаарай.

**737** 2014 оны өдрийн сонинд 5 хоногийн цаг агаарын мэдээг нийтэлжээ.

Хотын нэр	III / 10		III / 11		III / 12		III / 13		III / 14	
	Шөнө	Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө	Өдөр
Улаанбаатар	-17	-7	-17	-3	-15	1	-13	3	-9	4
Багануур	-24	-6	-24	-5	-21	0	-18	2	-16	3
Өлгий	-16	-3	-14	4	-10	5	-9	8	-4	11
Улаангом	-30	-12	-30	-12	-25	-8	-24	-9	-24	-11


- а. Хот бүрд хэдний өдөр хамгийн хүйтэн, хэдний өдөр хамгийн дулаан байна вэ?
- б. 3 дугаар сарын 14-нд аль хотод өдөртөө, аль хотод шөнөдөө хамгийн дулаан байна вэ?
- в. 3 дугаар сарын 10-нд аль хотод өдөртөө, аль хотод шөнөдөө хамгийн хүйтэн байна вэ?

- г. Улаанбаатарт байгаа сурагч эдгээр өдөр яаж хувцаславал тохиромжтой вэ? Улаангомд байгаа сурагч адил хувцаслаж болох уу? Яагаад?
- д. Асуулт зохиож, сурагчдаас асуугаарай. Хариулт зөв эсэхийг шалгаарай.

**738** Дараах нөхцөлийг хангах тус бүр 3 тоо олоорой. Учрыг тайлбарлаарай.

- а. 0-ээс бага,  $-10$ -аас их  
б.  $-2$ -оос их, 1-ээс бага  
в.  $-10$ -аас их, 10-аас бага  
г.  $-100$ -аас их, 10-аас бага

**739** Дэвхрэг 0 цэгээс баруун гар тийш 6, тэр цэгээсээ зүүн гар тийш 10 нэгж харайв. Дэвхрэг ямар цэгт очсон бэ?



Дэвхрэг ямар цэгт очсоныг тоон шулуун дээр дүрсэлж харуулаарай. Асуултад хариулаарай.

- а. Дэвхрэг 0-ээс эхлээд зүүн гар тийш 8, дараа нь баруун гар тийш 10 нэгж харайвал ямар тоон дээр очих вэ?  
б. Дэвхрэг  $-3$ -аас баруун гар тийш 12 нэгж харайвал ямар тоон дээр очих вэ? Тэр тооноос зүүн гар тийш 13 нэгж харайвал ямар тоон дээр очих вэ?  
в. Дэвхрэг эхлээд 1-ээс баруун гар тийш харайж 4 дээр очив. Дараа нь тэр тооноос зүүн гар тийш харайн  $-5$  дээр очив. Тэр аль чигт хэд харайсан бэ?

**740** Өгсөн тооноос эхлэн арван тоог хэлж тоолоорой.

- а. 10-аас эхлэн 1-ээр нэмэгдүүлэн тоолоорой.  
б. 10-аас эхлэн 1-ээр хорогдуулан тоолоорой.  
в. Ямар нэг сөрөг тоо сонгон, 1-ээр нэмэгдүүлэн тоолоорой.  
г. 0-д ойр эерэг тоо сонгон, 1-ээр хорогдуулан тоолоорой.


**741** Гадаа агаарын температур ямар байгааг бичжээ. Яаж хувцаслах вэ?

- а.  $8^{\circ}\text{C}$     б.  $-5^{\circ}\text{C}$     в.  $0^{\circ}\text{C}$     г.  $15^{\circ}\text{C}$     д.  $28^{\circ}\text{C}$     е.  $-16^{\circ}\text{C}$


**742** 8 цагт агаарын температур  $-4^{\circ}\text{C}$  байжээ. 12 цагт хэд болох вэ?

- а. Агаарын температур цаг тутамд 1-ээр нэмэгдэх үед олоорой.  
б. Агаарын температур цаг тутамд 2-оор нэмэгдэх үед олоорой.  
в. Агаарын температур цаг тутамд 1-ээр хорогдох үед олоорой.

**743** Дэвтэртээ тоон шулуун зураарай. 5, 0,  $-3$ ,  $-7$  цэгүүдийг байрлуулаарай.



**744** Тоон шулуун дээр 7-г тэмдэглэв.



- а. Түүнээс баруун гар тийш 5 нэгж зайд орших тоог олоорой.  
б. Түүнээс зүүн гар тийш 10 нэгж зайд орших тоог олоорой.

## АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ

Бодлого бодохдоо гүйцэтгэдэг 4 алхмыг сэргээн санаарай.

**Жишээ 1** Амьтдыг халамжлах газарт галуу, гахай нийлээд 53 байв. Тэдний хөлийг тоолбол 152 байв. Хэд нь нисэж чадах вэ? Бодолтыг тайлбарлаарай.

Бодлогыг  
ойлгох



Төлөвлөгөө  
зохиох



Төлөвлөгөөг  
биелүүлэх



Бодолтоо  
шалгах

Амьтдын тоо - 53. (Гахай, галуу тус бүрийн тоо тодорхойгүй.)  
Амьтдын хөлийн тоо - 152. Гахай 4, галуу 2 хөлтэй.  
Галуу нисдэг тул галууны тоог олно.

- 1) Нэг гахай ба нэг галууны хөлийн тооны зөрөө:  $4 - 2 = 2$
- 2) Хэрэв бүгд галуу байвал нийт хөлийн тоо:  $53 \times 2 = 106$
- 3) Амьтдын хөлийн тоо 152 байсан тул зөрөөг олъё:  $152 - 106 = 46$
- 4) Нэг гахайн 2 хөлийг тоолж, үлдсэнийг тоолоогүй. Бүх гахайн тоолоогүй хөлийн тоо 46. Иймд гахайн тоо:  $46 \div 2 = 23$
- 5) Галууны тоо:  $53 - 23 = 30$

Нийт хөлийн тоо:  $30 \times 2 = 60$ ,  $23 \times 4 = 92$ ,  $60 + 92 = 152$

Бодлогыг хүснэгт хэрэглэх, тааж шалгах зэрэг аргаар бодож болно.

Амьтны нэр	Амьтны тоо	Нэг амьтны хөлийн тоо	Амьтдын нийт хөлийн тоо
Гахай	?	4	?
Галуу	?	2	?
Бүгд	53		152

**745** Дэлгүүрт бүгд 8 хоёр дугуйт ба гурван дугуйт байв. Тэдгээрийн дугуйн тоо нийлээд 19 байсан бол хэдэн гурван дугуйт байсан бэ?

**746** Тахиа, туулай нийлээд 13, тэдний хөлийн тоо 36 байв. Хэдэн тахиа, хэдэн туулай байсан бэ? Бодолтоо тайлбарлаарай.

**747** Тоть, муур нийлээд 9, тэдний хөлийн тоо 24 байв. Хэдэн тоть, хэдэн муур байсан бэ?

**748** Зогсоол дээр суудлын тэрэг, 2 дугуйтай мотоцикл нийлээд 14, тэдгээрийн дугуйн тоо 48 байв. Хэдэн суудлын тэрэг, хэдэн мотоцикл байсан бэ?

**749** Цэцэрлэгт хүрээлэнд хүүхдүүд нохойгоо салхилуулав. Хүүхэд, нохой нийлээд 22, тэдний хөлийн тоо 68 байв. Хэдэн хүүхэд, хэдэн нохой байсан бэ?

**750**



2 ангид нийлээд 51 сурагч байв. Нэг ангиас 20, нөгөө ангиас 15 сурагч гарсны дараа ангиудад ижил тооны сурагч үлдэв. Анх анги бүрд хэдэн сурагч байсан бэ?

- 751** Эрүүл биетэй насанд хүрсэн хүний зүрх нэг минутад дунджаар 70 удаа цохилдог байна. 1 цагт, 1 хоногт хэдэн удаа цохилох вэ?
- 752** Хүн өдөрт 5 км явган явбал эрүүл мэндэд ашигтай гэдэг. Явган хүн 1 км замыг ойролцоогоор 12 минутад туулдаг. Тэгвэл өдөрт хэдэн минут явган явбал эрүүл мэндэд тустай вэ?
- 753** Хүн тайван байх үедээ нэг цагт 950 удаа амьсгалдаг. 3 цаг тайван байсан бол хэдэн удаа амьсгалсан бэ?
- 754** Өөрийнхөө төө, үзүүр тохой, алд, алхмыг хэмжиж мэдээрэй. Өөрийн чинь 2 үзүүр тохой, 4 төө нийлээд хэдэн метр хэдэн сантиметр вэ?
- 755** Амьдардаг байшин, хашааныхаа хэмжээг алхмаар хэмжиж олоорой.
- 756** Зөгий секундэд 6 м зам туулдаг. 360 м замыг хэдэн секундэд туулах вэ?
- 757** Хөхөө шувуу цагт 100 ширхэг шавж идэх чадвартай. Тэрээр дулааны улиралд манай нутагт 135 хоног байж, өдөрт 10 цагаар идэш хайдаг. Нэг хөхөө хэчнээн шавж идэх боломжтой вэ?
- 758** Тэмээ хоногт 20 л ус ууна. Харин ямаа түүнээс 10 дахин бага ус уудаг. 340 л усыг ямаа хэд хоногт уух вэ? Тэмээний 1 хоногт уух усыг ямаа хэд хоногт уух вэ? 340 л усыг тэмээ хэд хоногт уух вэ?
- 759** Тоть дунджаар 150 жил насалдаг. Хавч түүнээс 5 дахин бага насалдаг. Тоть хавчаас хэдэн жилээр урт насалдаг вэ?
- 760** Африкийн заан өдөрт 349 кг хүнс иддэг. Сард хэдэн килограмм хүнс идэх вэ?
- 761** Шаазгай 27 жил, хараацай шаазгайнаас 3 дахин бага насалдаг. Хэрээ хараацайнаас 40 жилээр илүү насалдаг бол хэрээ, хараацай тус бүр хэд насалдаг вэ?
- 762** Хус 125 жил насалдаг. Царс түүнээс 8 дахин урт насалдаг. Царс хэдэн жил насалдаг вэ?
- 763** Монгол оронд байдаг голуудаас хамгийн урт Орхон гол 1124 км. Хэрлэн Орхоноос 34 км-ээр богино. Туул Хэрлэнгээс 271 км-ээр богино бол голуудын нийт урт хэд вэ?
- 764** Манай улс Орос улстай 3485 км, Хятад улстай 4673 км урт хилийн шугамаар хиллэдэг. Манай улсын хилийн нийт уртыг олоорой. Аль улстай хэдэн километрээр илүү хиллэдэг вэ?
- 765** Улаанбаатараас Өндөрхаан хүртэл 331 км, Өндөрхаанаас Баруун-Урт хүртэл 229 км. Машинаар Улаанбаатараас гарч Өндөрхааныг дайрч Баруун-Урт хүрээд, замаараа буцаад Өндөрхаанд ирэв. Бүгд хэдэн километр явсан бэ?

## Хичээлийн жилийн явцад өөрийгөө үнэлэх хуудас ✓

д/д	3... ангийн сурагч ..... миний гаргаж байгаа амжилт	😊	😐	😞
1	10000 хүртэлх тоог уншиж, бичиж, жишиж чадна.			
2	10000 хүртэлх тоог тоон шулуун дээр цэгээр тэмдэглэн тоймлож чадна.			
3	10000 дотор тоог нэмж, хасаж, тооцооллыг ойролцоогоор хийж чадна.			
4	10000 дотор аравт, зуутагд ойр байх хоёр тоог цээжээр нэмж, хасаж чадна.			
5	10000 дотор тоог 10, 100-аар үржүүлж, 10, 100-д хувааж чадна.			
6	Тоог нэгжээр үржүүлж, нэгжид хувааж, тооцооллыг ойролцоогоор хийж чадна.			
7	Хоёр тооны нийлбэр ба зөрөөгөөр тоо тус бүрийг олж чадна.			
8	Сөрөг тоог уншиж, бичиж, жишиж, 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолж чадна.			
9	2, 3, 4, 5, 6, 8, 10 хуваарьтай энгийн бутархайг уншиж, бичиж, дүрсэлж, жишиж чадна.			
10	Ижил хуваарьтай энгийн бутархайнуудыг нэмж, хасаж чадна.			
11	Тоо, хэмжээний 2, 3, 4, 5, 6, 8, 10-ны хэсгийг олж чадна.			
12	Тоон илэрхийлэл, тоон тэнцэтгэл, тоон тэнцэтгэл биш бичиж, зохиож чадна.			
13	Нэмэх, үржүүлэх үйлдлийн чанарыг хэрэглэн тооцоолж, шалгаж чадна.			
14	Үйлдлийн нэг гишүүн мэдэгдэхгүй үед нөгөө хоёр гишүүнээр олж чадна.			
15	Үйлдлийн гишүүдийн хамаарлыг тайлбарлан, тооцоололд хэрэглэж чадна.			
16	Дараалуулсан тоо, дүрс, юмсын зүй тогтол, орхисон гишүүнийг олж чадна.			
17	Өгүүлбэртэй бодлогыг ойлгон товч бичиглэл, зураглал хийж чадна.			
18	Өгүүлбэртэй бодлогыг бодох алхмаа төлөвлөж, асуулт бичиж чадна.			
19	Төлөвлөгөө, асуултын дагуу бодлогоо бодож чадна.			
20	Өгүүлбэртэй бодлогын бодолт, хариуг шалгаж, тайлбарлаж чадна.			
21	Хугацааг тохирох нэгжээр илэрхийлж, хэмжээг жишиж, үйлдэл гүйцэтгэж чадна.			
22	Уртыг хэмжиж, хэмжээг жишиж, үйлдэл хийж, дүрсийн периметрийг олж чадна.			
23	Хүндийг хэмжиж, хэмжээг бичиж, жишиж, үйлдэл гүйцэтгэж чадна.			
24	Шингэний эзлэхүүнийг хэмжиж, хэмжээг бичиж, жишиж, үйлдэл гүйцэтгэж чадна.			
25	Нэгж квадратаар дүрс бүтээж, талбайн хэмжээг (см.кв-аар) олж чадна.			
26	Куб, түүний дэлгээсийг таньж, дэлгээсийн талбайн хэмжээг олж чадна.			
27	Харилцан эгц, зэрэгцээ шулуун, тэгш, хурц, мохоо өнцөг, олон өнцөгт, тойрог, дугуй дүрсийг нэрлэж, дүрсэлж чадна.			
28	Тэгш хэмтэй дүрсийг олж, тэгш хэмийн тэнхлэгийг зурж чадна.			
29	Зураг, хүснэгт дэх дүрс, юмсын байршлыг бичиж, заасан байршилд хүрэх зам, чиглэлийг хэлж, дүрсэлж чадна.			
30	Юмсыг нэг, хоёр шинжээр ангилж, дүрсэлж чадна.			
31	Өгөгдөл цуглуулж, бүртгэж, зурган, баганан диаграммаар дүрсэлж чадна.			
32	Модны загвар хэрэглэн боломжийг тооцоолж чадна.			

Жилийн эцэст ямар чадвартай болсноо үнэлээрэй.